



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СТАТИСТИКИЙН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН
ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2016

Танилцуулгыг хянасан:

Д.Лхамсүрэн
Т.Алтансүх
Н.Байгалмаа

Танилцуулгыг бэлтгэсэн:

О.Өүжингэ	<i>Хүн ам, Хөдөлмөр эрхлэлт, Өрхийн орлого, зарлага Эрүүл мэнд, Хотын аюулгүй байдал</i>
Д.Гансүх	<i>Нийслэлийн төсөв, Өмч, Нийгмийн даатгал</i>
Э.Цэнд-Аюуш	<i>Боловсрол</i>
Н.Байгалмаа	<i>Соёл урлаг, чөлөөт цаг, биеийн тамир Тээвэр: Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан авто машин, Нийтийн тээвэр Харилцаа холбоо</i>
Т.Алтансүх	<i>Байгаль орчин, Хөдөө аж ахуй, Газар тариалан</i>
Э.Зоригбат	<i>Хэрэглээний үнэ, Дотоод худалдаа</i>
Б.Энхболд	<i>Аж үйлдвэр</i>
Ц.Уранбилэг	<i>Барилга</i>
Б.Цэвэлмаа	<i>Аж ахуйн нэгж байгууллага (Бизнес регистр)</i>

Танилцуулгыг нэгтгэсэн:

Н.Байгалмаа

Холбоо барих

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
1 дүгээр хороо, Бага тойруу-3,
Ц.Жигжиджавын гудамж-9, Хангарди ордон

Утас: (976-11)-324854; 328787; 327946

Факс: (976-11)-322783

И-мэйл: ulaanbaatar@nso.mn

Вэб: www.ubstat.mn



Өмнөх үг

Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2016 оны танилцуулгыг өмнөх дөрвөн жилийн үндсэн үзүүлэлтүүдтэй харьцуулан тухайн жилд хийгдсэн тооллого, судалгааны үр дүнгээр баяжуулан Та бүхэнд толилуулж байна.

Та бүхэн www.ubstat.mn вэб сайтаас манай байгууллагын үйл ажиллагааны танилцуулга болон нийслэлийн эдийн засаг, нийгмийн олон жилээр зэрэгцүүлсэн статистик мэдээллийг 300 гаруй үзүүлэлтээр график, хүснэгтэн хэлбэрээр үзэж, танилцах боломжтой юм. Бид энэхүү вэб сайтаараа нийслэлийн нийгэм, эдийн засгийн танилцуулгыг сар, жилийн давтамжаар цахим хэлбэрээр хэрэглэгч та бүхэндээ тархаан ажилладаг билээ.

Мэдээллийн технологийн эрин үед амьдарч байгаа нийслэлчүүд маань нийгэм, эдийн засгийн бүхий л мэдээллийг цахим орчноос авч байгаагийн дотор фэйсбүүк зэрэг нийгмийн сүлжээнээс мэдээлэл авах нь элбэг байна.

Иймд бид нийгмийн сүлжээний <https://www.facebook.com/ubstat> хуудсаар байгууллагынхаа үйл ажиллагааны мэдээллийг хэрэглэгчдэд давхар түгээхээс гадна хэрэглэгчдийн санал хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авч, өдөр тутмын үйл ажиллагаатайгаа уялдуулан хэрэглэгчдэд хурдан шуурхай үйлчлэх, үйлчилгээнийхээ чанарыг ахиулахад анхааран ажиллаж ирсэн.

Манай байгууллагаас долоо хоног тутам нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах 11 супер маркет, хүнсний заххаас цуглуулдаг “Хүнсний гол нэрийн барааны үнийн судалгаа”-ны ханшийн мэдээллийг фэйсбүүк мессенжерийн автомат

хариулагчийн <https://www.messenger.com/t/1139861422795108> хаягаар дамжуулан хүргэх үйлчилгээг нэвтрүүлсэн нь хэрэглэгчдийн сэтгэлд нийцсэн, тэдний талархлыг хүлэсэн үйлчилгээ болсон.

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан “Нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн сан”-гийн системийг нэвтрүүлэхэд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, албан ёсны болон захиргааны статистик мэдээллийг орон зайн мэдээллийн системтэй холбож, хэрэглэгчдэд статистик мэдээллийг газарзүйн байршлаар, ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр хүргэх боломжийг бий болгон ажиллаж байна.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын сар бүрийн мэдээний танилцуулга, жилийн эмхэтгэл болон бусад тоон мэдээлэлтэй танилцахыг хүсч байвал “1212.mn” аппликейшныг танд санал болгож байна.

Энэхүү аппликейшныг та өөрийн ухаалаг гар утас, таблет зэрэг төхөөрөмжүүддээ татан авч Үндэсний Статистикийн хорооноос эрхлэн гаргадаг бүхий л мэдээ, мэдээллийг монгол, англи хэл дээр хэрэглэх боломжтой.

Манай байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, өөрийн санал хүсэлтээ бидэнд ирүүлдэг хэрэглэгчид, хамтран ажилладаг байгууллага, хамт олонд талархал илэрхийлж, хамтын ажиллагаагаа цаашид улам өргөжүүлэн ажиллах болно.

НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН
ГАЗРЫН ДАРГА
Д.ЛХАМСҮРЭН





УЛААНБААТАР ХОТ

Улаанбаатар хот нь Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу улсын нийслэл бөгөөд хуулиар тусгайлан олгосон онцлог чиг үүрэг, өөрийн удирдлагатай, засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор бүхий тусгай статустай хот юм.

Нийслэл Улаанбаатар хот хууль ёсны “Хангарди” сүлд тэмдэг, өөрийн тугтай.

Нийслэл нь мөрөвчит дугуй дүрсний төвд байрласан Богд Хан уулын уламжлалт шүтээн Хангарди бүхий сүлд тэмдэгтэй. Нийслэлийн сүлд тэмдэг Хангарди нь магнайдаа төрт ёс, эрдэм мэдлэгийн бэлгэдэл соёмботой, баруун гартаа түмэн олондоо үүд хаалгаа цэлгэр сайхнаар нээж өөдлөн дэвшихийн санааг илэрхийлсэн очир бариулт түлхүүртэй, зүүн гартаа энэлэн үгүй ариун тэгш оршихуйн баталгаа бадам цэцгийг нандигнан барьж, аливаа хорын үндсийг эгнэгт устган дарах санааг гишгэн зогсож буй могойгоор илэрхийлсэн байна. Хангарди нь бат түвшин эрэмгий байдлыг илэрхийлж нийслэл хот өргөжиж алдар нэр нь тив дэлхийд мандан бадрахын утга санааг агуулдаг.

Нийслэлийн туг нь мөнх хөх тэнгэрийн өнгөтэй, өргөн, урт нь 1:1.5-ын харьцаатай, голд нь нийслэлийн сүлд тэмдэгийг цагаан торгоор дүрслэн алтлаг мөнгөн утсаар зээглэн үрласан байдаг. Нийслэлийн туг нь нийслэлчүүд ариун цагаан сэтгэлээр төрт ёсоо дээдлэн, мандан бадрахын утга санааг бүхэлдээ агуулна.



Газар зүйн байршил

Улаанбаатар хот Монгол орны физик газар зүйн мужлалаар Хангай Хэнтийн уулархаг их мужийн хэсэгт, тухайлбал Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд шувтрага үзүүрт Туул голын өргөн хөндий, ай сав цутгал голуудын бэлчирт байрладаг.

Улаанбаатар хот далайн төвшнөөс дээш 1350 метр өндөрт Номхон далайгаас 1600 орчим км алсад, дэлхийн экватороос хойш 5310 км, хойд туйлаас урагш 4690 км зайтай буюу дэлхийн хойд өргөрөгийн 47°55', зүүн уртрагийн 106°55'-ын солбицолд, дэлхийн цагийн 7 дугаар бүсэд Лондон хотоос 7 цаг 08 минутын зөрүүтэй оршиж байна. Улаанбаатар хот урдуураа Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг, баруунаараа мөн аймгийн Алтанбулаг, Аргалант, Баянцогт, баруун хойгуураа мөн аймгийн Батсүмбэр, зүүн хойгуур, зүүн талаараа мөн аймгийн Батсүмбэр, Эрдэнэ сумтай хиллэн нийт 473511.6 га талбай бүхий нутаг дэвсгэрийг эзэлдэг.

Уур амьсгал

Улаанбаатар хотын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай. Өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь хасах 49°C хүрдэг, үнэмлэхүй их температур нь 38.6°C, үнэмлэхүй их бага температурын агууриг нь 87.6°C болдог эрс тэс ялгаатай бөгөөд ийм их зөрөө дэлхийн аль ч улсын нийслэлд гардаггүй байх.

Жилийн дундаж температур нь -3°C, “хамгийн хүйтэн” 1-р сарын температур нь -26°C байх бөгөөд -30°C-аас бууж хүйтрэх өдрийн тоо жилд 40 орчим байна.

Улаанбаатарт хүйтрэлтгүй үргэлжлэх хугацаа 5-р сарын 29-ний орчмоос 9-р сарын 2 орчим хүртэл буюу 90 хоног байна. Энэ хугацаанд агаарын температур 0°C-аас доош буухгүй. Жилийн хамгийн дулаан сар нь 7-р сар бөгөөд дундаж температур нь 17°C, хамгийн халуун болсон нь 38°C хүрсэн. Зундаа 30°C-аас давж халуун болох өдрийн тоо 10 орчим, ган болох магадлал 30 орчим хувь байдаг.

Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн цэлмэг хөх тэнгэрт хотуудын нэг бөгөөд жилдээ 250-иад хоног цэлмэг байдаг. Улаанбаатар хот манай орны салхи багатай газрын тоонд орно. Жилдээ салхигүй өдөр 100 орчим байх бөгөөд салхины хурд 4-6 м/с, баруун хойд зүгийн салхи голлоно. Өвөл салхи багатай, хавар нь салхи ихтэй.

Монгол орны уур амьсгалын мужлалын хувьд авч үзвэл Улаанбаатар хот нь хуурайдуу сэрүүн зунтай хахир өвөлтэй нутагт багтана. Улаанбаатар хот орчимд жилд дунджаар 233 мм тунадас унаж, ууршилт нь 648 мм болдог. Чийгшлийн байдал 0.36 байдаг. Агаарын харьцангуй чийг 1-р сард 70 орчим хувь, 7-р сард 60 орчим хувь байдаг.

Нийслэл Улаанбаатар хотын нутаг нь бүхэлдээ Хойд мөсөн далайн савд багтана. Бараг бүх гол нь Туул голын сав гол юм. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт Туул голын хөвөөнд нүүрсхүчлэлт магнийн исгэлэн давст цацраг идэвхит бодистой гидрокарбонат кальцит рашаан бий. Гацуурт тосгонд Цагаан эрэгний, Сэлбийн Дамбадаржаад мөн Их тэнгэрийн аманд рашаан бий. Налайх дүүргийн нутаг дэвсгэрт гидрокарбонат, каль-магнит, нүүрсхүчлийн хийтэй, радонтай Аржанчивлангийн рашаан бий. Налайхын Бүст нуурыг ардууд рашаан гэж ашигладаг байна.

Засаг захиргаа

Улаанбаатар нь Монгол Улсын Нийслэл хот бөгөөд засаг захиргааны хуваариар аль нэгэн аймагт харьяалагдахгүй тусгай нэгж юм.

Нийслэл хот нь Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Налайх, Багануур, Багахангай гэсэн 9 дүүрэгт хуваагддаг. Дүүрэг бүр нь хороодод хуваагдана.

Нийслэл Улаанбаатар хот нь засаг захиргааны хувьд 9 дүүрэг, нийт 152 хороогоор дамжуулан үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотын захиргааг анх 1925 онд байгуулсан бөгөөд 1992 онд баталсан Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах болж, энэ үеэс эхлэн Улаанбаатар хотын удирдлага нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид, Засаг дарга, Улаанбаатар хотын Захирагчаас бүрэлдэн тогтов.

Нийслэл хотыг 4 жил тутамд хотын нийт иргэдээс сонгогддог Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал удирдаж, хотын даргын нэрийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дэвшүүлж Монгол Улсын Ерөнхий сайдад өргөн барьдаг бөгөөд Ерөнхий сайд бүрэн эрхийн хүрээнд хотын даргыг 4 жилийн хугацаатайгаар томилдог. Хотын дарга нь Улаанбаатар хотын нийт газар нутагт Монгол Улсын хуулийг хэрэгжүүлдэг бөгөөд үйл ажиллагаагаа Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнадаг.

Улаанбаатар хотын дарга нар:

Ажилласан хугацаа	Хотын даргын нэр
1924-1926	Моононгийн Баяр
1926-1927	Санжийн Батсүх
1927-1929	Дуламжавын Гомбожав
1929-1930	Ламжавын Мижиддорж
1930-1931	Дуламжавын Гомбожав
1931-1932	Бадамын Цэдэндамба
1932.07	Өлзийн Равдан
1932-1933	Дансранбилэгийн Догсом
1933-1936	Дамдингийн Чимэддаваа
1936-1939	Дуламжавын Гомбожав
1939.05-11	Лодойн Тавхай
1940-1941	Өлзийцогтын Мажиг
1941.07-08	Гомбодонийн Дамдин
1941.09-11	Рэндоогийн Лувсаннаваан
1942-1944	Сономын Шагдар
1944-1956	Гүндийн Багаа
1956	Бадрахын Ламзав
1956-1959	Будын Батжаргал
1959-1962	Санжийн Батаа
1962-1965	Магалжавын Лувсанчоймбол
1965-1971	Догсомын Цэдэв
1971-1972	Сономын Лувсангомбо
1972-1976	Сүрэнжавын Балбар
1976-1978	Очирын Цэнд
1978-1990	Самбуугийн Мөнхжаргал
1990-1992	Лхамсүрэнгийн Энэбиш
1992-1996	Цэрэндэмбэрэлийн Баасанжав
1996-1998	Жанлавын Наранцацралт
1999-2005	Миеэгомбын Энхболд
2005-2007	Цогтын Батбаяр
2007-2008	Түдэвийн Билэгт
2008-2012	Гомбосүрэнгийн Мөнхбаяр
2012-2016	Эрдэнийн Бат-Үүл
2016-	Сундуйн Батболд

Эдүгээ хүртэл Улаанбаатар хотын даргаар нийт 31 хүн ажиллаж байжээ.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд 2016 оны 7 дугаар сараас ажиллаж байгаа Улаанбаатар хотын 32 дахь дарга юм.

Нийслэл хотын захиргаа нь хотын нутаг дэвсгэрт төр засгийн тогтоол, шийдвэр хууль дүрмийг мөрдүүлэх, хотыг хөгжүүлэх зураг төлөвлөгөө гаргах, хотын гудамж талбай, зам, гүүр, цэцэрлэг, хамгаалалт барих тохижуулах, хотыг гэрэл, ус, хоол хүнсээр хангах, худалдаа, зах зээлийн асуудлыг ард олны эрх ашигт нийцүүлж зохион байгуулах, ард олны амгалан тайван байдлыг хангах, соёлжих гэгээрэх, эрүүл мэндийг хамгаалах ажлыг үүсгэн зохион байгуулах зэрэг олон чухал арга хэмжээг авч хэрэгжүүлэх салбар чиглэлийн ажил үүрэг хариуцсан байгууллагуудыг байрлуулж, өөрийн харьяанд ажиллуулж ирсэн байна.

Улаанбаатар хотын Засаг захиргааны нэр

1923 оны 10 дугаар сард нийслэл хотын анхны захиргааг байгуулах Засгийн газрын шийдвэр гарснаас хойш нэр нь өнөөг хүртэл дараах байдлаар өөрчлөгдөж ирсэн тухай түүхэн болон архивын баримтуудад тэмдэглэгдэн үлджээ.

1924 он Улаанбаатар хотын түр захиргаа

1925 он Улаанбаатар хотын жинхэнэ захиргаа

1931 он Улаанбаатар аймгийн захиргаа

1933 он Улаанбаатар хотын захиргаа

1937 он Улаанбаатар хотыг захирах яам

1939 он Улаанбаатар хотын захиргаа

1952 он Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатүүдын хурлын гүйцэтгэх захиргаа

1962 он Улаанбаатар хотын Ардын депутатүүдын хурлын Гүйцэтгэх захиргаа

1990 он Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа

1992 он Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

АГУУЛГА

	Өмнөх үг	3
	Нийслэл Улаанбаатар хот	4
	 Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт	8
1	 Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж	9
2	 Сонгууль	10
3	 Нийслэлийн хүн ам	12
4	 Хүн амын хөдөлмөр эрхлэлт	27
5	 Өрхийн орлого, зарлагын бүтэц	40
6	 Нийгмийн даатгал	45
7	 Боловсрол	47
8	 Эрүүл мэнд	57
9	 Соёл урлаг, цөлөөт цаг, биеийн тамир	61
10	 Байгаль орчин	67
11	 Нийслэл хотын аюулгүй байдал	69
12	 Нийслэлийн төсөв	74
13	 Нийслэлийн өмч	79
14	 Хэрэглээний үнэ	81
15	 Хөдөө аж ахуй	93
16	 Газар тариалан	97
17	 Аж үйлдвэр	99
18	 Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан авто машин	104
19	 Нийтийн тээвэр	109
20	 Харилцаа холбоо	115
21	 Дотоод худалдаа	119
22	 Барилга	121
23	 Аж ахуйн нэгж байгууллага	124


Хүснэгт 1. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2012	2013	2014	2015	2016
Хүний хөгжлийн индекс	коэффициент	0.795	0.800	0.808	0.813	0.812 ¹
Нэмүү өртөг	тэрбум төгрөг	11 126.3	12 252.7	14 070.0	14 964.7	15 620.1 ¹
Нэг хүнд ногдох нэмүү өртөг	мянган төгрөг	8 541.5	9 109.2	10 288.8	10 846.9	11 012.7 ¹
Хэрэглээний үнийн жилийн индексийн өөрчлөлт	хувь	14.2	12.3	10.7	1.1	0.5
Валютын зах зээлийн ханш	1US\$ =₮	1 359	1 526	1 818	1 971	2 148
Аж ахуйн нэгж, байгууллага	тоо	65 587	71 654	81 748	92 366	104 477
Үйл ажиллагаа явуулж буй ААНБ	тоо	33 143	34 777	37 124	40 381	46 153
Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	тэрбум төгрөг	160.1	239.6	197.8	215.6	200.3
Нийслэлийн төсвийн орлого	тэрбум төгрөг	456.4	727.7	812.4	844.8	872.9
Нийслэлийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	337.7	697.6	770.1	883.8	961.6
Нийслэл хотын суурин хүн ам	мянган хүн	1 227.0	1 267.0	1 314.5	1 345.5	1 380.8
Нийслэлийн 0-16 насны хүн ам	мянган хүн	338.6	357.6	370.1	417.2	423.2
Нийслэлийн 16-35 хүртэлх насны хүн ам	мянган хүн	445.5	452.0	466.5	458.8	464.1
Нас барсан хүн	мянган хүн	7.6	7.1	7.6	7.2	7.3
Шинээр төрсөн хүүхэд	мянган хүн	33.3	36.4	37.7	42.8	39.1
Нийслэлд шилжин ирсэн хүн	мянган хүн	19.9	27.7	31.4	30.3	25.2
Нийслэлээс шилжин явсан хүн	мянган хүн	7.0	10.1	10.0	11.7	14.3
Гэрлэлт	хос	5 699	6 736	7 933	8 263	8 288
Гэр бүл цуцлалт	хос	1 821	2 054	2 329	2 515	2 630
Нийслэлийн өрхийн тоо	мянган өрх	317.1	333.4	352.8	376.4	380.8
Эдийн засгийн идэвхтэй хүн	мянган хүн	393.3	447.3	476.1	494.1	511.5
Бүртгэлтэй ажилгүй хүн	мянган хүн	12.8	14.1	15.8	12.6	12.0
Өрхийн сарын дундаж орлого	төгрөг	983 912	1 097 813	1 249 877	1 169 820	1 073 118
Өрхийн сарын дундаж зарлага	төгрөг	957 902	1 042 471	1 176 705	1 097 901	1 034 986
Ядуурлын хамралтын хүрээ	хувь	19.9	19.9	16.4	16.4	24.8
Хүн амын дундаж наслалт	жил	70.2	70.65	70.65	71.79	71.74
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	25 128	18 739	18 653	40 461	40 178
Төрөхийн улмаас эндсэн эх	тоо	16	21	15	12	17
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	тоо	486	546	625	613	611
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	12 910	15 419	17 144	17 939	17 909
Инженерийн дэд бүтэцтэй сууцанд амьдардаг хүн амын эзлэх хувь	хувь	38.9	39.4	41.1	41.6	42.6
Инженерийн дэд бүтэцгүй сууцанд амьдардаг хүн амын эзлэх хувь	хувь	61.1	60.6	58.9	58.4	57.4
Ашиглалтад оруулсан орон сууц	айл	8 686	17 580	20 820	17 930	12 883
Нэг хүний цэвэр усны хоногийн хэрэглээ	литр	71.9	72.3	69.2	70.5	68.8
орон сууцанд амьдардаг	литр	177.7	177.2	164.8	163.8	157.2
гэр хороололд амьдардаг	литр	4.6	4.8	4.7	4.7	4.5
Зүлэгжүүлсэн талбай	мянган м ²	3 787.2	3 872.2	3 971.9	4 077.0	4 315.6
шинээр зүлэгжүүлсэн	мянган м ²	79.3	85.0	99.7	105.1	238.6
нөхөн зүлэгжүүлсэн	мянган м ²	194.8	328.1	325.4	209.8	482.5
Авто замын нийт урт	км	474.6	528.2	560.1	644.1	632.1
Автомашин ³	тоо	228 952	257 498	297 008	331 564	339 626
Нийтийн зорчигч тээврийн хэрэгсэл	тоо	2 780	2 648	2 343	2 314	1 830
автобус	тоо	1 020	1 048	1 091	1 313	1 203
троллейбус	тоо	58	66	64	56	56
микроавтобус	тоо	968	885	527	352	42
такси	тоо	734	649	661	593	529
Нийтийн зорчигч тээврийн чиглэлийн урт	км	4 492	4 543	4 361	3 874	3 978
Гар утас хэрэглэгч	мянган хүн	2 060.8	1 745.5	1 772.2	1 967.3	1 753.1 ²

¹ Урьдчилсан гүйцэтгэл,

² Идэвхтэй хэрэглэгчид,

³ Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан



Хүснэгт 2. Засаг захиргааны нэгж, км²

Дүүрэг	Нутаг дэвсгэрийн хэмжээ ¹ (км ²)	Хүн амын нягтрал (1 км ² -д ногдох хүн)			Хорооны тоо		
		2000	2010	2016	2000	2010	2016
Багануур	625.0	33	43	46	3	4	5
Багахангай	156.1	25	26	26	2	2	2
Баянгол	24.4	4780	6275	8784	19	20	23
Баянзүрх	1236.1	120	214	265	20	24	28
Налайх	689.0	34	46	53	5	6	7
Сонгинохайрхан	1200.1	132	210	263	21	25	32
Сүхбаатар	210.8	458	657	648	16	18	20
Хан-Уул	501.9	150	231	318	13	14	16
Чингэлтэй	91.7	1217	1651	1723	18	19	19
Бүгд	4735.1	164	247	292	117	132	152

¹ Хот байгуулалтын мэдээллийн сангийн UTM координатын системд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэв.

Хүснэгт 3. Улаанбаатар хотын Ардын депутатын хурал, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгууль

Сонгууль явагдсан он сар өдөр	Бүх сонгогчид	Сонгогдсон депутат, төлөөлөгчид	Депутат, төлөөлөгчийн бүрэлдэхүүн, хувиар		
			Эмэгтэй	Ажилчин	Сэхээтэн
1952.10.19	53 669	166	25.3	59.0	41.0
1954.10.24	58 431	166	27.7	33.1	66.9
1956.10.21	68 844	169	25.4	33.7	66.3
1959.10.25	89 570	67	23.9	28.3	71.7
1961.10.22	103 953	109	19.2	36.7	63.3
1963.06.09	109 092	135	23.7	34.1	65.9
1965.06.13	116 915	148	28.4	40.5	59.5
1967.06.25	124 737	157	28.0	38.2	61.8
1969.06.22	130 012	172	27.9	40.7	59.3
1972.06.18	144 000	195	24.6	29.7	70.3
1975.06.15	166 395	214	25.2	36.4	63.6
1978.06.11	188 194	225	28.0	31.5	68.5
1981.06.21	220 733	225	25.8	31.1	68.9
1984.06.17	248 417	225	26.2	34.7	65.3
1987.06.21	279 945	225	29.8	44.0	56.0
1990.07.29	264 294	151	13.2	15.9	84.1
1992.08.10	273 763	72	11.1	2.0	98.0
1996.10.06	294 557	40	2.0	-	100.0
2000.10.02	317 062	40	5.0	-	100.0
2004.10.17	337 532	40	15.0	-	100.0
2008.11.30	286 649	45	22.2	-	100.0
2012.06.28	517 006	45	13.3	-	100.0
2016.06.29	843 689	45	22.2	-	100.0

Хүснэгт 4. Улаанбаатар хотын Ардын депутатын хурал, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгууль

Сонгууль явагдсан он сар өдөр	Сонгогдсон депутат, төлөөлөгч	Үүнээс: Депутат, төлөөлөгчид, улс төрийн намаар, хувиар										
		МАН (хуучнаар МАХН)	АН	ИЗНН	МАХН-МУАН-ын Шударга ёс эвсэл	МУАН	МСДН	МУДН	МНН	БНН	Эх орон ардчилал эвсэл	Бие даагч
1952.10.19	166	100.0										
1954.10.24	166	100.0										
1956.10.21	169	100.0										
1959.10.25	67	100.0										
1961.10.22	109	100.0										
1963.06.09	135	100.0										
1965.06.13	148	100.0										
1967.06.25	157	100.0										
1969.06.22	172	100.0										
1972.06.18	195	100.0										
1975.06.15	214	100.0										
1978.06.11	225	100.0										
1981.06.21	225	100.0										
1984.06.17	225	100.0										
1987.06.21	225	100.0										
1990.07.29	151	59.2	15.7	-	-	-	2.0	2.7	-	-	-	20.4
1992.08.10	72	80.5	-	-	-	-	-	4.2	-	-	-	15.3
1996.10.06	40	57.5	-	-	-	22.5	15.0	-	2.5	-	-	2.5
2000.10.02	40	97.5	-	-	-	-	-	-	-	2.5	-	-
2004.10.17	40	92.5	-	-	-	-	-	-	-	-	5.0	2.5
2008.11.30	45	80.0	20.0	-	-	-	-	-	-	-	-	-
2012.06.28	45	31.1	57.8	2.2	8.9	-	-	-	-	-	-	-
2016.06.29	45	75.6	24.4	-	-	-	-	-	-	-	-	-

Тайлбар:


МАН - Монгол Ардын Нам, АН - Ардчилсан Нам, МАХН - Монгол Ардын Хувьсгалт Нам, ИЗНН - Иргэний Зориг, Ногоон Нам,
МУАН - Монголын Үндэсний Ардчилсан Нам, МСДН - Монголын Социал Демократ Нам, МҮДН - Монголын Үндэсний Дэвшлийн Нам,
МНН - Монголын Ногоон Нам, БНН - Бүгд Найрамдах Нам




НИЙСЛЭЛИЙН ХҮН АМ

Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 45.1 хувь буюу бараг 2 хүн тутмын нэг нь нийслэл хотод оршин сууж байна. Нийслэлийн хүн амын 95.0 хувь нь төвийн 6 дүүрэгт, тодруулбал Баянзүрх дүүрэгт 23.7 хувь, Сонгинохайрхан дүүрэгт 22.9 хувь, Баянгол дүүрэгт 15.5 хувь, Хан-Уул дүүрэгт 11.6 хувь, Чингэлтэй дүүрэгт 11.4 хувь, Сүхбаатар дүүрэгт 9.9 хувь, үлдсэн 5.0 хувь нь Налайх, Багануур, Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

Зураг 1. Монгол Улсын хүн ам, бүсээр



Зураг 2. Хүн амын тархалт, дүүргээр



2012 онд нийслэлийн хэмжээнд нэг км² нутаг дэвсгэрт 259 хүн оршин сууж байсан бол 2016 онд 292 хүн оршин суух болжээ. Нийслэлийн хэмжээнд хүн амын нягтрал 2013-2016 оны хооронд 9.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 5. Суурин хүн амын тоо, хүн амын нягтрал, дүүргээр


Дүүрэг	Нутаг дэвсгэр (км ²)	Хүн амын тоо (мянган хүн)					Хүн амын нягтрал, нэг км ² -д				
		2012	2013	2014	2015	2016	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	4 735.1	1227.0	1267.0	1314.5	1345.5	1380.8	259	269	279	286	292
Баянзүрх	1 236.1	294.9	304.3	308.7	320.9	327.1	232	245	248	258	265
Сонгинохайрхан	1 200.1	261.9	277.3	295.8	307.2	315.8	216	231	246	256	263
Баянгол	24.4	192.6	200.2	208.9	205.7	214.3	6521	6785	7081	6975	8784
Хан-Уул	501.9	153.9	131.1	138.4	151.0	159.5	1719	270	285	312	318
Чингэлтэй	91.7	127.5	155.9	159.5	154.8	158.0	255	1745	1786	1733	1723
Сүхбаатар	210.8	132.1	133.3	136.4	137.6	136.6	648	640	655	660	648
Налайх	689.0	32.9	33.2	34.6	35.8	36.4	48	48	50	52	53
Багануур	625.0	27.5	27.9	28.3	28.4	29.0	44	45	46	46	46
Багахангай	156.1	3.7	3.8	3.9	4.1	4.1	26	27	28	29	26

Нийслэлийн Баянгол (8784), Чингэлтэй (1723), Сүхбаатар дүүрэгт (648) хүн амын нягтрал хамгийн их байгаа нь нийслэлийн дунджаас 2.2-30.1 дахин их байна. Харин Налайх дүүрэгт 53, Багануур дүүрэгт 46, Багахангай дүүрэгт 26 байгаа нь хүн амын нягтрал хамгийн бага болохыг харуулж буй үзүүлэлт юм.

Зураг 3. Хотуудын хүн амын эзлэх хувь

Нийслэл нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн 0.3 хувийг эзэлж, хүн амын нягтралаар хамгийн өндөр хот хэвээр байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 2076.9 мянга (66.2%) нь хотын хүн ам буюу аймгийн төв, нийслэл, тосгоны хүн ам юм. Хотуудын хүн амын 66.4 хувь нь нийслэл хотод оршин сууж байна.



Нэг км² газарт ногдох хүний тоо буюу хүн амын нягтрал нийслэл хотод 292 хүн байгаа нь Монгол Улсын томоохон суурин газрууд болох Орхон (117), Дархан-Уул (30) аймгуудаас даруй 2.5-9.7 дахин их нягтралтай байна.

Хүснэгт 6. Нийслэлийн хүн ам, хороодын бүлгээр, 2016 он

Бүлгийн интервал (хүн амаар)	Бүлэгт хамаарах хорооны тоо	Бүлгийн хүн амын тоо	Дүнд эзлэх хувь
600-5000	23	84 263	6.1
5001-6500	23	134 721	9.8
6501-8000	23	163 597	11.8
8001-10000	25	218 326	15.8
10001-12000	24	264 523	19.2
12001-15000	19	250 999	18.2
15001+	15	264 363	19.1


Нийслэл хот 2011 оноос эхлэн засаг захиргааны анхан шатны 152 нэгжтэй болсон. 2016 онд нэг хороонд дунджаар 9084 хүн оршин суух болж, өмнөх оноос 232 хүнээр нэмэгдсэн байна. Энэ нь аймгуудын нэг сүмийн дундаж хүн амын тооноос даруй 1.8 дахин илүү байгаа юм.

Нэг хороонд ногдох хүн амын тоогоор Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүд тэргүүлж байна.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 15-р хороонд хамгийн их буюу 22229 хүн оршин сууж байхад Багануур дүүргийн 2-р хороонд хамгийн бага буюу 670 хүн оршин сууж байна.

2016 онд нийслэлийн суурин хүн амын тоо 1380792 (661900 эрэгтэй, 718892 эмэгтэй) болж өмнөх оноос 35.3 мянган хүнээр (2.6%) өссөн байна. Хүн амын жилийн дундаж өсөлтийн хурдыг тооллого явагдсан онуудаар авч үзвэл, 1956-1963 онд хамгийн өндөр буюу 9.5 хувь, 1963-1969 онд 3.0 хувь, 1969-1979 онд 4.2 хувь, 1979-1989 онд 3.1 хувь, 1989-2000 онд 3.0 хувь, 2000-2010 онд 3.9 хувь, 2010-2016 онд 3.1 хувиар түс түс өсчээ.

Зураг 4. Нийслэлийн хүн амын өсөлт



Сүүлийн жилүүдэд хүн амын төрөлт нэмэгдэж, хөдөө орон нутгаас нийслэлд шилжин ирэгсдийн тоо тогтвортой байгаагаас шалтгаалан нийслэлийн хүн амын өсөлтөд ердийн өсөлтийн эзлэх хувийн жин жил ирэх тусам нэмэгдсээр байна. 2000 онд 1000 хүн ам тутамд ногдох механик өсөлт буюу шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент 25 болж ердийн хөдөлгөөний цэвэр коэффициент буюу 1000 хүн ам

тутамд ногдох ердийн цэвэр өсөлтөөс бараг 3 дахин их байсан бол 2016 онд 1000 хүн ам тутамд ногдох цэвэр өсөлтийн түвшин механик өсөлтийн түвшнөөс 2.9 дахин илүү болжээ.

Хүснэгт 7. Хүн амын цэвэр өсөлт

Үзүүлэлт		2012	2013	2014	2015	2016
Нийслэл	Төрсөн хүүхдийн тоо	33 324	36 421	37 672	42 790	39 074
	Нас барсан хүний тоо	7 554	7 068	7 608	7 245	7 275
	Хүн амын цэвэр өсөлт	25 770	29 353	30 064	35 545	31 799
Улсын дүн	Төрсөн хүүхдийн тоо	73 839	79 780	82 839	82 130	79 920
	Нас барсан хүний тоо	17 761	17 247	16 521	17 620	17 763
	Хүн амын цэвэр өсөлт	56 078	62 533	66 318	64 510	62 157
Цэвэр өсөлтөд нийслэл хотын эзлэх хувийн жин		46.0	46.9	45.3	55.1	51.1

2016 онд нийслэлийн хэмжээнд нийт 37508 эхээс 39074 хүүхэд мэндэлж, 7275 хүн нас барж, ердийн цэвэр өсөлт 31799 хүнээр нэмэгдсэн байна. Монгол Улсын хүн амын цэвэр өсөлтөд нийслэлийн эзлэх хувийн жин 2012 онд 46.0 хувь байсан бол энэ үзүүлэлт жил ирэх тутамд өсөн нэмэгдсээр 2016 онд 51.1 хувьд хүрэв.

Хүснэгт 8. Жилийн эцсийн суурин хүн амын тооцоо

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Жилийн эхний хүн ам	1 206 610	1 226 991	1 267 024	1 314 486	1 345 500
Төрсөн хүүхэд	33 324	36 421	37 672	42 790	39 074
Нас барсан хүн	7 554	7 068	7 608	7 245	7 275
Шилжин ирсэн хүн	19 887	27 706	31 356	30 297	25 196
Шилжин явсан хүн	7 024	10 060	10 009	11 702	14 342

1990 оноос хойш нийслэлд хөдөө, орон нутгаас 590.0 мянга орчим хүн шилжин ирж, 120.0 мянга гаруй хүн хөдөө орон нутаг руу шилжин явсан байна. Монгол Улсын Дээд Шүүхийн шийдвэрээр нийслэлд шилжин суурьших иргэдээс авч байсан “төлбөр”цуцлагдсны улмаас 2004 онд хамгийн олон буюу 68.8 мянган хүн нийслэл хотод албан ёсоор шилжин иржээ. Гэхдээ эдгээр хүмүүсийн 27.2 мянга нь нийслэл хотод олон жилийн өмнөөс суурьшиж, суурин хүн амын тоонд бүртгэгдэж ирсэн байна.

Нийслэлийн хэмжээнд 2016 онд 25196 хүн албан ёсоор шилжин ирснээс, 6852 (27.2%) нь Баянзүрх, 6561 (26.0%) нь Сонгинохайрхан, 3514 (14.0%) нь Баянгол, 2592 (10.3%) нь Хан-Уул, 2506 (9.9%) нь Чингэлтэй, 2057 (8.2%) нь Сүхбаатар, 1114 (4.4%) нь Багануур, Багахангай, Налайх дүүрэгт тус тус суурьшжээ.

Хүснэгт 9. Нийслэлийн хүн амын шилжих хөдөлгөөн

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Шилжин ирсэн	19 887	27 706	31 356	30 297	25 196
Шилжин явсан	7 024	10 060	10 009	11 702	14 342
Механик өсөлт	12 863	17 646	21 347	18 595	10 854
Шилжин ирэлтийн коэффициент	16.34	22.22	24.29	22.78	18.48
Шилжин явалтын коэффициент	5.77	8.07	7.75	8.8	10.52


2016 онд нийслэлээс 14342 хүн бусад аймаг, орон нутаг руу албан ёсоор шилжин явсан байна. Нийслэлийн хэмжээнд 2016 онд 1000 хүн ам тутамд шилжин ирсэн хүний тоо 19 болж 2012 оноос 3 хүнээр, шилжин явсан хүний тоо 11 болж, 2012 оноос 5 хүнээр тус тус өсч, механик өсөлт 1000 хүн тутамд 8 болж 2012 оноос 3 хүнээр буурчээ.

Нийслэлийн нийт хүн амын 64.3 хувь нь 35 хүртэл насны залуучууд байна. Тодруулбал, нийт хүн амын 423224 (30.7%) нь 0-15 насны хүүхэд, 871818 (63.1%) нь 16-59 насны хүмүүс, 85750 (6.2%) нь 60 ба түүнээс дээш насны өндөр настнууд байна.

Хүснэгт 10. Нийслэлийн суурин хүн амын тоо, нас, хүйсийн бүтцээр

Насны бүлэг	2012		2013		2014		2015		2016	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Бүгд	1 226 991	646 010	1 267 024	664 076	1 314 486	686 649	1 345 500	694 521	1 380 792	718 892
0-4	132 928	65 993	142 717	70 314	154 393	75 884	184 061	89 790	179 506	87 778
5-9	95 976	48 028	104 351	52 075	112 618	56 157	130 587	64 003	140 362	68 925
10-14	91 450	45 785	92 468	46 188	85 648	42 558	84 732	41 395	86 704	42 338
15-19	93 285	47 766	94 681	48 397	91 648	47 041	90 873	45 775	88 152	44 414
20-24	126 639	67 605	122 655	64 572	116 953	61 450	110 522	57 531	104 399	54 508
25-29	130 306	69 747	136 416	72 908	150 537	79 627	151 482	78 346	152 785	79 878
30-34	113 507	60 609	116 284	61 970	124 864	65 614	123 747	63 886	135 422	70 657
35-39	101 900	54 219	104 215	55 212	108 447	57 136	104 209	53 751	110 161	57 672
40-44	85 976	45 794	88 826	47 106	94 255	49 392	91 416	47 428	97 122	51 532
45-49	76 764	41601	78 774	42 635	78 103	41 867	76 308	40 388	78 726	42 425
50-54	60 916	33 259	64 759	35 004	66 691	36 234	66 520	36 108	69 134	38 046
55-59	41 073	22 587	43 493	23 914	47295	26 174	50 533	28 389	52 569	29 734
60-64	26 548	14 833	27 629	15 470	30 062	16 907	29 255	16 892	32 847	18 996
65-69	18 870	10 412	19 486	10 919	20 290	11 663	20 441	12 101	20 493	12 272
70+	30 853	17 772	30 270	17 392	32 682	18 945	30 814	18 738	32 410	19 717

Зураг 5. Хүн амын нас, хүйсийн суварга, 2010, 2016 оны жилийн эцэс



Нийслэлийн хүн амын хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 92.1 болж 2012 оноос 2 хүнээр өссөн байна. Энэ нь хүн амын нас баралтад эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байгаа, мөн хөдөө орон нутгаас шилжин ирэгсдийн дунд эмэгтэйчүүд илүү байгаагаар холбоотой.

Хүснэгт 11. Нийслэлийн хүн амын хүйсийн харьцаа, насны бүлгээр

Насны бүлэг	2012	2013	2014	2015	2016
Бүгд	89.9	90.8	91.4	93.7	92.1
0-4	101.4	103.0	103.5	105.0	104.5
5-9	99.8	100.4	100.5	104.0	103.6
10-14	99.7	100.2	101.3	104.7	104.8
15-19	95.3	95.6	94.8	98.5	98.5
20-24	87.3	90.0	90.3	92.1	91.5
25-29	86.8	87.1	89.1	93.4	91.3
30-34	87.3	87.6	90.3	93.7	91.7
35-39	87.9	88.8	89.8	93.9	91.0
40-44	87.7	88.6	90.8	92.7	88.5
45-49	84.5	84.8	86.6	88.9	85.6
50-54	83.2	85.0	84.1	84.2	81.7
55-59	81.8	81.9	80.7	78.0	76.8
60-64	79.0	78.6	77.8	73.2	72.9
65-69	81.2	78.5	74.0	68.9	67.0
70+	73.6	74.0	72.5	64.4	64.4

Төрөх үеийн хүйсийн харьцаагаар 100 эмэгтэй хүүхдэд ногдох эрэгтэй хүүхдийн тоо байнга давамгайлж байгаа боловч насны түвшин нэмэгдэх тусам 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо цөөрч байна.

Хүснэгт 12. Төрөх үеийн хүйсийн харьцаа болон хүн ам зүйн ачаалал, дүүргээр

Дүүрэг	Төрөх үеийн хүйсийн харьцаа					Хүн ам зүйн ачаалал				
	2012	2013	2014	2015	2016	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дундаж	102	104	105	106	106	51.1	52.1	52.6	58.7	58.4
Багануур	98	104	105	106	109	52.7	53.2	53.2	59.9	58.9
Багахангай	94	104	122	111	88	57.7	59.0	61.9	62.8	60.7
Баянгол	97	107	105	109	105	48.4	49.5	51.3	57.8	57.6
Баянзүрх	106	107	103	106	106	51.0	50.3	48.8	56.9	55.8
Налайх	90	105	106	121	102	60.0	56.2	59.7	63.4	63.0
Сонгинохайрхан	106	97	103	108	105	52.0	55.3	56.8	58.8	58.6
Сүхбаатар	94	102	104	107	104	54.2	55.2	52.9	59.8	60.5
Хан-Уул	105	107	106	99	110	48.6	51.1	52.2	62.8	62.4
Чингэлтэй	103	102	109	104	105	50.4	50.9	52.6	57.3	57.5

2016 оны жилийн эцэст нийслэлд 60-аас дээш насны 85750 өндөр настан оршин сууж байсны 34765 (40.5%) нь эрэгтэй, 50985 (59.5%) нь эмэгтэйчүүд байв.

Зураг 6. 60 ба түүнээс дээш насны өндөр настан, хүйсээр, 2016 он



16 хүртэлх насны хүүхэд болон 60 ба түүнээс дээш насны өндөр настай хүн амын нийлбэрийг 16-59 насны хүн амд харьцуулсан дүнгээр илэрхийлэгддэг хүн ам зүйн ачаалал 2016 онд 58.4 хувь болж өмнөх оноос 0.3 пунктээр буурсан байна. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны 100 хүн бүр 58 хүнийг тэжээж байгаагийн 48 нь хүүхэд, 10 нь өндөр настнууд байна.

Төрөлтийн ерөнхий коэффициент буюу 1000 хүн амд ногдох төрөлт 2016 онд 27.5 болж, 2012 оноос 1.1 промилээр өссөн бол нас баралтын ерөнхий коэффициент буюу 1000 хүн амд ногдох нас баралт 5.1 болж, 2012 оноос 2.9 промилээр буурсан байна.


Нийслэлийн хэмжээнд 2016 онд нийтдээ 39074 хүүхэд мэндэлсэн нь 2012 оноос 4743 хүүхдээр (13.8%) олон байв. 2016 онд мэндэлсэн нийт хүүхдийн 3.8% нь 19 хүртэлх насны эхээс, 21.3% нь 20-24 насны эхээс, 34.1% нь 25-29 насны эхээс, 23.8% нь 30-34 насны эхээс, 13.3% нь 35-39 насны эхээс, 3.5% нь 40-44 насны эхээс, 0.2% нь 45-аас дээш насны эхээс тус тус мэндэлжээ.

Хүснэгт 13. Төрөлт, эхийн насны бүлгээр

Насны бүлэг	2012	2013	2014	2015	2016
Бүгд	33 324	36 421	37 672	42 790	39 074
15-19	1 104	1 159	1 071	1 748	1 496
20-24	9 993	9 948	8 363	9 985	8 331
25-29	10 848	11 908	12 025	14 027	13 311
30-34	6 670	7 208	8 855	10 018	9 289
35-39	3 755	4 829	5 272	5 595	5 206
40-44	888	1 203	1 809	1 368	1 367
45-49	66	166	277	49	74

Хүүхэд төрүүлсэн 20-24 насны 1000 эмэгтэй тутмаас 153 хүүхэд, 25-29 насны 1000 эмэгтэй тутмаас 167 хүүхэд, 30-34 насны 1000 эмэгтэй тутмаас 132 хүүхэд, 35-39 насны 1000 эмэгтэй тутмаас 104 хүүхэд мэндэлсэн байна.

Зураг 7. Хүүхэд төрүүлсэн эхчүүд, боловсролын түвшнээр



2016 онд хүүхэд төрүүлсэн эхчүүдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл 21633 (57.7%) нь дээд болон түүнээс дээш, 13907 (37.1%) нь бүрэн дунд, 649 (1.7%) нь суурь, 715 (1.9%) нь тусгай мэргэжлийн дунд болон техникийн мэргэжлийн, 130 (0.3%) нь бага боловсролтой, үлдэх 474 (1.3%) нь ямар нэг боловсрол эзэмшээгүй эмэгтэйчүүд байна. Түүнчлэн хүүхэд төрүүлсэн эхчүүдийн 3692 (9.8%) нь гэр бүлгүй, 33816 (90.2%) нь гэр бүлтэй хүмүүс байна.

Хүснэгт 14. Төрсөн хүүхдийн тоо, дүүргээр

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	33 324	36 421	37 672	42 790	39 074
Багануур	753	850	762	803	644
Багахангай	103	106	109	177	92
Баянгол	5 002	5 543	5 803	7 269	6 178
Баянзүрх	7 530	8 310	8 404	9 961	9 265
Налайх	874	968	947	1 059	860
Сонгинохайрхан	7 502	8 171	8 688	9 636	8 905
Сүхбаатар	3 430	3 914	3 889	4 213	3 515
Хан-Уул	3 471	3 999	4 450	4 921	5 140
Чингэлтэй	4 659	4 560	4 620	4 751	4 475
Улсын дүн	73 839	79 780	82 839	82 130	79 920
Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь	45.1	45.7	45.5	52.1	48.9

Хүснэгт 15. Нас барсан хүний тоо, насны бүлэг, хүйсээр

Насны бүлэг	2012		2013		2014		2015		2016	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Бүгд	7554	2901	7068	2879	7608	2969	7245	2944	7275	2891
<1	486	229	546	254	625	277	613	256	611	289
1-4	124	56	89	36	87	47	87	36	102	44
5-9	44	13	25	12	25	8	34	9	40	15
10-14	46	20	30	7	28	14	36	7	35	16
15-19	75	23	48	20	79	31	79	27	74	27
20-24	150	38	114	36	133	32	112	33	88	15
25-29	218	68	181	51	198	56	187	63	187	62
30-34	304	81	244	64	233	53	243	53	221	65
35-39	433	123	341	88	374	110	341	93	324	86
40-44	512	123	456	125	489	136	455	116	455	125
45-49	688	167	573	172	648	174	566	148	529	134
50-54	755	225	705	247	708	223	640	212	732	225
55-59	638	194	589	181	732	246	754	279	718	230
60-64	565	214	583	236	635	243	570	243	569	225
65-69	536	230	514	219	538	235	533	243	593	255
70+	1980	1097	2030	1131	2076	1084	1995	1126	1997	1078


Нийслэлийн хүн амын нас баралтын түвшин сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой байна. 2016 онд 7.3 мянган хүн нас барсан нь улсын хэмжээнд нас барсан нийт хүний 41.0 хувийг эзэлж байна. Нас барсан хүн амын дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр хэвээр байгаа нь нас ахих тусам 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо цөөрч, эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс илүү байгаагийн гол шалтгаан болж байна. 2012 онд нас барсан хүний 61.5 хувь нь эрэгтэйчүүд байсан бол 2013 онд 59.3 хувь, 2014 онд 61.0 хувь, 2015 онд 59.4 хувь, 2016 онд 60.3 хувь болжээ.

Хүснэгт 16. Эх, нялхсын эндэгдлийн зарим үзүүлэлт

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Төрөхийн улмаас эндсэн эх	16	21	15	12	17
Үр хөндөлт	13 895	10 385	11 900	13 164	13 805
Нялхсын нас баралт	486	546	625	613	611
Нялхсын нас баралтын коэффициент	14.2	15	16.6	14.3	15
Улсын дунд нийслэлийн эзлэх хувь	42.5	46.8	50	49.7	46.5


Нялхсын нас баралтын коэффициент буюу амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас нэг хүртэл насандаа эндсэн хүүхдийн тоо 2015 онд 2014 оноос 2.3 промилээр буурч байсан бол 2016 онд 2015 оноос 0.7 промилээр өссөн байна.

Зураг 8. Хүн амын дундаж наслалт




Нийслэлийн хүн амын дундаж наслалт 71.5 болж, өмнөх 2015 оноос бага зэрэг буурав. 2012 онд нийслэлийн хүн амын дундаж наслалт улсын дунджаас 1.5 жилээр дээгүүр үзүүлэлттэй байсан бол 2016 онд 1.9 жил болж өсчээ.

Зураг 9. Гэрлэлт ба гэр бүл цуцлалт



2016 онд 8288 хос гэрлэлтээ шинээр бүртгүүлсэн нь өмнөх оноос 0.3 хувиар, 2630 хос гэрлэлтээ цуцлуулсан нь өмнөх оноос 4.6 хувиар тус тус өсч, 639 хүүхэд үрчлэгдсэн нь өмнөх оноос 1.5 хувиар буурчээ.


Зураг 10. Гэр бүл цуцлалт, хамт амьдарсан жилээр



2016 онд гэр бүл цуцлуулсан дөрвөн хос тутмын нэг нь 7-9 жил хамт амьдарсан байгаа нь гэр бүл салалтыг амьдарсан хугацаагаар харуулсан үзүүлэлтийн хамгийн өндөр хувийг эзэлж байв.

Түүнчлэн 21.2 хувь (558) нь 20 ба түүнээс дээш жил, 19.2 хувь (505) нь 10-14 жил, 14.6 хувь (383) нь 4-6 жил, 12.5 хувь (328) нь 15-19 жил, 6.4 хувь (168) нь 1-3 жил, 0.8 хувь (20) нь нэг жил хүртэлх хугацаанд хамт амьдарсаны эцэст гэр бүлээ цуцлуулсан байна.

Зураг 11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шалтгаанаар



2016 оны жилийн эцэст нийслэлийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 33.7 мянган иргэн амьдарч байгаа нь өмнөх оноос 230 хүнээр (0.7%) бүүрчээ.

Хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн 88.0 хувь нь 18 ба түүнээс дээш насны хүмүүс байхад 39.7 хувь нь төрөлхийн, үлдэх хувь нь өвчнөөр болон осол гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүс байна.

Хүснэгт 17. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хүйс, дүүргээр

Дүүрэг	2012		2013		2014		2015		2016	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Нийслэлийн дүн	30 025	14 430	31 867	15 018	34 384	16 153	33 943	15 623	33 713	15 895
Багануур	1 115	478	1 155	478	1 133	470	1 077	393	987	427
Багахангай	118	46	132	50	131	47	150	62	164	63
Баянгол	4 284	2 017	4 647	2 062	4 827	2 388	4 764	2 223	4 693	2 326
Баянзүрх	6 204	3 095	5 889	3 099	7 040	3 428	7 233	3 346	7 794	3 793
Налайх	1 315	494	1 628	626	1 700	683	1 754	707	1 760	723
Сонгинохайрхан	6 161	2 995	6 987	3 292	7 294	3 222	7 271	3 248	7 284	3 308
Сүхбаатар	2 903	1 394	2 706	1 276	3 165	1 481	3 374	1 550	3 181	1 443
Хан-Уул	3 743	1 826	4 092	1 954	4 273	2 197	3 670	1 822	3 861	1 921
Чингэлтэй	4 182	2 085	4 631	2 181	4 821	2 237	4 650	2 272	3 989	1 891

2016 онд хагас өнчин хүүхдийн тоо 11512 болж, өмнөх оноос 162 (1.4%) хүүхдээр нэмэгдэж, бүтэн өнчин хүүхдийн тоо 1573 болж, өмнөх оноос 116 (6.9%) хүүхдээр бүүрчээ. Хагас өнчин хүүхдүүдийн 5842 (50.8%) нь эмэгтэй, бүтэн өнчин хүүхдүүдийн 806 (51.2%) нь эмэгтэй хүүхэд байна.

Хүснэгт 18. Өнчин хүүхдийн тоо, дүүргээр

Дүүрэг	Бүтэн өнчин хүүхдийн тоо					Хагас өнчин хүүхдийн тоо				
	2012	2013	2014	2015	2016	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	1 793	1 740	1 702	1 689	1 573	11 026	11 535	11 699	11 350	11 512
Багануур	53	47	44	35	39	332	285	289	298	287
Багахангай	8	6	8	6	10	53	62	57	60	48
Баянгол	125	137	140	156	149	1 051	1 124	1 029	976	887
Баянзүрх	660	602	575	503	402	3 294	3 340	3 289	2 720	2 889
Налайх	58	64	60	80	75	526	532	545	502	457
Сонгинохайрхан	382	404	368	368	416	2 317	2 536	2 624	2 644	2 655
Сүхбаатар	161	151	164	165	154	1 067	1 074	1 160	1 159	1 285
Хан-Уул	170	144	152	166	160	1 177	1 186	1 246	1 330	1 400
Чингэлтэй	176	185	191	210	168	1 209	1 396	1 460	1 661	1 604

Нийт өнчин хүүхдийн 12.0 хувь нь бүтэн өнчин, 88.0 хувь нь хагас өнчин, 1378 (10.5%) нь 0-4 насны, 3374 (25.8%) нь 5-9 насны, 4498 (34.4%) нь 10-14 насны, 3835 (29.3%) нь 15-17 насны хүүхдүүд байна.

Нийслэлийн өрхийн аж байдал:

2016 онд нийслэлийн хэмжээнд нийт 380828 өрх байгаа нь Монгол Улсын нийт өрхийн 43.8 хувийг эзэлж, нэг өрхийн дундаж ам бүлийн тоо 3.6 болов. Нийслэлийн өрхийн тоо 2015 оноос 4409 өрхөөр (1.2%), 2012 оноос 63697 өрхөөр (20.1%) тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 19. Нийслэлийн өрхийн тоо, дүүргээр, мянган өрх

Дүүрэг	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	317.1	333.4	352.8	376.4	380.8
Багануур	7.8	8.0	8.3	8.4	8.6
Багахангай	1.1	1.1	1.1	1.2	1.2
Баянгол	49.7	52.4	55.5	58.0	58.2
Баянзүрх	76.1	80.2	86.0	93.1	93.7
Налайх	9.1	9.3	9.7	10.1	10.4
Сонгинохайрхан	65.4	71.7	77.1	82.9	84.9
Сүхбаатар	36.0	36.0	36.1	37.9	38.0
Хан-Уул	34.0	35.4	39.2	43.3	45.2
Чингэлтэй	37.9	39.3	39.8	41.5	40.6
Улсын дүн	768.3	794.1	823.4	859.1	869.8
Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь	41.3	42.0	42.8	43.8	43.8

Нэг өрхийн дундаж ам бүлийн тоо 1990 оны эхэнд 5.1 байсан бол тухайн үеэс эхлэн буурсаар 2000 онд 4.6, 2008 онд 4.4, 2016 онд 3.6 болсон нь жил ирэх тутамд нэг өрхөд ногдох хүний тоо буурч байгааг харуулж байна.

Зураг 12. Нийслэлийн өрхийн тоо, дундаж ам бүл




Нийт өрхийн 12503 (3.2%) нь 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх байна. Нийслэлд ганц бие өндөр настай 6119 хүн, тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй өндөр настай 127 хүн амьдарч байна.

Хүснэгт 20. Өрхийн зарим үзүүлэлт

Төрөл	2012	2013	2014	2015	2016
18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх	6 048	9 779	11 860	10 779	12 503
Ганц бие өрхийн тоо, бүгд	3 280	4 471	3 836	6 678	6 119
Үүнээс: эрэгтэй (60 ба түүнээс дээш настай)	1 283	1 741	1 432	2 158	1 971
эмэгтэй (55 ба түүнээс дээш настай)	1 997	2 730	2 404	4 520	4 148
Тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй өндөр настай хүн, бүгд	508	712	440	247	127
Үүнээс: эрэгтэй (60 ба түүнээс дээш настай)	204	313	210	119	58
эмэгтэй (55 ба түүнээс дээш настай)	304	399	230	128	69

Зураг 13. 16 хүртэл насны хүүхэдтэй өрх толгойлсон хүн, хүйсээр



2016* онд 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон 13493 хүн байгаагийн 8335 (61.8%) нь 3 хүртэл хүүхэдтэй, 4040 (29.9%) нь 3-5 хүүхэдтэй, 1118 (8.3%) нь 6 ба түүнээс дээш хүүхэдтэй байна.

2016 онд өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 20.5 мянга болж, өмнөх оноос 580 хүнээр (2.8%) буурчээ.

* 18 хүртэл насны хүүхэдтэй гэр бүлгүй хүний тоо

Хүснэгт 21. Өрх толгойлсон, гэр бүлгүй хүний тоо, хүйс, дүүргээр

Дүүрэг	2012		2013		2014		2015		2016	
	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Нийслэлийн дүн	5 875	23 826	4 808	23 602	4 320	22 894	3 697	21 090	3 800	20 510
Багануур	123	695	114	651	95	737	125	528	131	593
Багахангай	25	182	31	203	21	161	20	149	19	151
Баянгол	528	2 240	612	2 101	419	2 032	380	1 842	307	1 880
Баянзүрх	897	5 342	806	5 628	875	5 836	738	4 976	697	4 407
Налайх	663	1 250	482	1 665	552	1 540	319	1 425	370	1 212
Сонгинохайрхан	1 418	4 256	882	4 055	820	4 262	684	3 881	666	3 526
Сүхбаатар	425	2 949	471	2 670	469	2 596	406	2 706	543	2 903
Хан-Уул	852	3 485	517	2 807	396	2 423	425	2 446	433	2 657
Чингэлтэй	944	3 427	893	3 822	673	3 307	600	3 137	634	3 181

Нийт өрхийн 6.4 хувийг гэр бүлгүй хүмүүс толгойлж байна. Ийм өрхүүдийн 15.6 хувийг эрэгтэйчүүд, 84.4 хувийг эмэгтэйчүүд толгойлж байна. Эдгээр өрхүүдийн 11880 (48.9%) нь 3 хүртэлх ам бүлтэй, 9143 (37.6%) нь 3-5 ам бүлтэй, 3287 (13.5%) нь 6 ба түүнээс дээш ам бүлтэй өрхүүд байна.

Өрхийн сууцны нөхцөл:


Хөдөө орон нутгаас нийслэлд шилжин ирэгсэд нь гол төлөв хотын зах орчимд суурьшиж, гэр хорооллын бүсийг тэлж байгаад иргэдийн орлогын түвшнээс хамаарч орон сууц худалдан авах боломж хомс байгаа байдал илүүтэй нөлөөлж байна. 2003 оноос өмнө нийслэлийн айл өрхүүдийн 50 гаруй хувь нь төвлөрсөн хангамжид холбогдсон орон сууцны хороололд амьдарч байсан бол сүүлийн жилүүдэд гэр хороололд амьдардаг өрх, хүн амын тоо харьцангуй нэмэгдэж, 2012 онд нийслэлийн нийт өрхийн 59.8 хувь, 2013 онд 59.1 хувь, 2014 онд 57.9 хувь, 2015 онд 58.1 хувь, 2016 онд 56.7 хувь нь гэр хороололд амьдарч байна.

Хүснэгт 22. Орон сууцны болон сууцны тусдаа байшин, гэрт амьдардаг өрхийн судалгаа

Үзүүлэлт		2012	2013	2014	2015	2016
Нийт өрхийн тоо		317 131	333 379	352 812	376 419	380 828
Үүнээс:	Орон сууцны хорооллын өрхийн тоо бүгд, үүнээс:	127 596	136 285	148 651	157 754	164 807
	нийтийн орон сууцны	126 338	135 037	147 381	156 199	163 141
	тусдаа тохилог орон сууц	1 123	1 178	1 208	1 515	1 630
	орон гэргүй	135	70	62	40	36
	Гэр хорооллын өрхийн тоо бүгд, үүнээс:	189 535	197 094	204 161	218 665	216 021
	тохилог орон сууцанд	2 033	1 860	1 711	1 782	2 022
	байшинд амьдардаг	103 348	106 395	108 770	110 707	109 327
	монгол гэрт амьдардаг	83 822	88 553	93 459	105 962	104 462
	орон гэргүй	332	286	221	214	210
	Орон сууцны хороололд амьдарч буй өрхийн эзлэх хувь	40.2	40.9	42.1	41.9	43.3
	Гэр хороололд амьдарч буй өрхийн эзлэх хувь	59.8	59.1	57.9	58.1	56.7

Сүүлийн жилүүдэд орон сууцны барилгууд нэмэгдэх хандлагатай болж, 2010 оноос орон сууцны хорооллын өрхийн тоо 40 шахам мянган өрхөөр нэмэгдсэн. 2016 онд нийслэлийн нийт өрхийн 56.7 хувь нь гэр хороололд, 43.3 хувь нь орон сууцны хороололд оршин сууж байна.

Зураг 14. Нийслэлийн өрх, байршлаар




Орон сууцны хорооллын өрх жилд дунджаар 6600 орчим өрхөөр нэмэгдэж, 2016 оны эцэст 164.8 мянгад хүрсэн байхад гэр хорооллын өрх жилд дунджаар 8000 орчим өрхөөр нэмэгдэж, 2016 оны эцэст 216.0 мянга болжээ.

Хүснэгт 23. Нийслэлийн өрх, байршил, сууцны төрлөөр, 2016 он


Дүүрэг	Нийт өрх	Үүнээс:						
		Орон сууцны хороололд			Гэр хороололд			
		Нийтийн орон сууц	Тусдаа тохилог орон сууц	Орон гэргүй	Тусдаа тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Монгол гэр	Орон гэргүй
Нийслэлийн дүн	380 828	163 141	1 630	36	2 022	109 327	104 462	210
Багануур	8 604	3 483	37	-	41	1 607	3 423	13
Багахангай	1 187	660	-	1	1	100	425	-
Баянгол	58 241	45 521	584	-	234	6 164	5 736	2
Баянзүрх	93 713	39 962	326	2	336	25 071	27 983	33
Налайх	10 349	2 322	37	-	18	3 853	4 116	3
Сонгинохайрхан	84 924	21 792	8	24	367	31 331	31 338	64
Сүхбаатар	38 021	18 102	43	-	305	10 487	9 081	3
Хан-Уул	45 200	22 912	591	5	418	11 453	9 805	16
Чингэлтэй	40 589	8 372	3	4	315	19 477	12 304	114

Зураг 15. Нийслэлийн өрх, сууцны төрлөөр



Гэр хороололд суурьшсан өрхийн тоо 2012 оноос 26486 өрхөөр нэмэгдэж, гэр хорооллын өрхийн жилийн дундаж өсөлт 3.7 хувьд хүрч 2016 оны эцэст 216.0 мянган өрх болов. Гэр хороололд суурьшсан 216.0 мянган өрхийн 104.2 мянга нь монгол гэрт, 111.6 мянга нь байшин сууцанд амьдарч байна.

Зураг 16. Орон гэргүй өрх, оршин суугаа байршлаар



2016 онд нийслэлийн нийт өрхөөс 246 (0.1%) өрхийн 577 хүн орон гэргүйн улмаас үрц овоохой, шатны хонгил зэрэг хүн амьдрах зориулалтын бус сууцанд амьдарч байна. Орон гэргүй нийт өрхөөс 210 (85.4%) өрхийн 511 хүн гэр хороололд байна.

2016 онд орон гэргүй, орон сууцны зориулалтын бус нөхцөлд амьдардаг 8 өрхийн 55 хүн гэр, байшин сууцтай болжээ.



ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний мэдээ, тайлан гаргах, судалгаа явуулах зорилгоор “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг Үндэсний Статистикийн Хорооны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар 2009 онд шинэчлэн баталснаар хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс тооцож байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүдийг 2009 он хүртэл аймаг, нийслэлийн засаг захиргааны анхан шатны нэгжээс мэдээлдэг “Хүн амын ажил эрхлэлтийн жилийн тайлан”-гийн дүнгээр гаргаж байв.

Монгол Улсад “Ажиллах хүчний судалгаа”-г 2002-2003 онд анх удаа олон улсын нийтлэг аргачлалын дагуу улирлаар явуулсан нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний суурь судалгаа болсон. Харин “Статистикийн тухай” хуульд 2004 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 2006 оноос эхлэн “Ажиллах хүчний судалгаа”-г улирлаар явуулж, үр дүнг нэгтгэн тархаадаг болсон.

Ажиллах хүчний судалгаанд нийслэлийн 9 дүүргээс түүврээр сонгогдсон өрхөөс мэдээллийг сар бүр цуглуулж, улирлаар нэгтгэж, үр дүнг гаргадаг.

Шинэчлэн батлагдсан аргачлалын дагуу ажиллах хүчний судалгааны дүнгээр тооцоход 2016 онд улсын хэмжээнд эдийн засгийн идэвхтэй хүн ам 1275.7 мянга байгаагийн 39.7 хувь, хөдөлмөр эрхэлж буй 1147.8 мянган ажиллагчид байгаагийн 40.5 хувь нь тус тус нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн амд (ажиллах хүч) тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулдаг. Эдийн засгийн идэвхтэй хүн амыг эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам гэж хоёр ангилдаг бөгөөд энд танилцуулж буй мэдээллийг эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн амаар гаргасан болно.

Хүснэгт 24. Нийслэлийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
15 ба түүнээс дээш насны хүн амын тоо	735 759	845 487	870 776	917 814	981 432
Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо	393 321	447 293	476 138	494 106	511 509
Үүнээс: Ажиллагчдын тоо	365 287	426 731	451 819	459 971	465 091
Ажилгүй иргэдийн тоо	28 034	20 562	24 319	34 135	46 418
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо	12 811	14 143	15 787	12 640	11 988
Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо	342 441	398 194	394 638	423 708	469 923
Ажиллах хүчний оролцооны түвшин	53.5	52.9	54.7	53.8	52.1
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	49.6	50.5	51.9	50.1	47.4
Ажилгүйдлийн түвшин	7.1	4.6	5.1	6.9	9.1

Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулсан дүнгээр илэрхийлэгддэг ажиллах хүчний оролцооны түвшин 52.1 хувьтай байна. Ажиллах хүчний судалгааны тооцоогоор 2016 онд эдийн засгийн идэвхтэй хүн ам 511.5 мянга байгаагаас 465.1 мянга (90.9%) нь ажиллагчид, 46.4 мянга (9.1%) нь ажилгүй иргэд байна.

Зураг 17. Хүн амын хөдөлмөр эрхлэлт



Эдийн засгийн үйл ажиллагааны бүх төрлийн салбарт ажиллагчдын тоо 2012 онд 365.3 мянга, 2013 онд 426.7 мянга, 2014 онд 451.8 мянга, 2015 онд 460.0 мянга, 2016 онд 465.1 мянга болж нэмэгджээ.


Ажиллагч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг хэв шинжид хамрагдаж буй иргэнийг ойлгоно.

Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн 7 хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ.

Хүснэгт 25. Ажиллагчдын тоо, дүүргээр

Дүүрэг	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	365 287	426 731	451 819	459 971	465 091
Багануур, Багахангай	10 691	9 627	10 034	10 303	9 240
Баянгол	60 585	76 371	76 121	71 626	72 082
Баянзүрх	87 698	107 637	103 001	109 583	125 044
Налайх	9 074	10 782	11 831	14 614	13 840
Сонгинохайрхан	71 335	87 092	103 318	107 105	104 512
Сүхбаатар	44 925	45 120	47 247	46 778	40 530
Хан-Уул	33 478	43 076	52 088	53 318	55 488
Чингэлтэй	47 501	47 026	48 179	46 644	44 355

Зураг 18. Ажиллагчид, дүүргээр



Ажиллах хүчний судалгааны дүнгээр нийт ажиллагчдын 125.0 мянга (26.9%) нь Баянзүрх, 104.5 мянга (22.5%) нь Сонгинохайрхан, 72.1 мянга (15.5%) нь Баянгол, 55.5 мянга (11.9%) нь Хан-Уул, 44.4 мянга (9.5%) нь Чингэлтэй, 40.5 мянга (8.7%) нь Сүхбаатар, 13.8 мянга (3.0%) нь Налайх, 9.2 мянга (2.0%) нь Багануур, Багахангай дүүрэгт байна.

Багахангай дүүргийн хувьд хүн амын тоо цөөн тул судалгааны түүвэрлэлт хийхдээ Багануур дүүрэгтэй хамтатган түүврийн нэг нэгж болгон, хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтийг нэгдсэн байдлаар гаргадаг болно.


Ажиллах хүчний судалгааны дүнгээр ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулан тооцсон ажилгүйдлийн түвшин 9.1 хувь болж, өмнөх оноос 2.2 пунктээр өссөн байна.

Хүснэгт 26. Ажилгүй иргэдийн² тоо, дүүргээр

Дүүрэг	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	28 034	20 562	24 319	34 135	46 418
Багануур, Багахангай	744	1 717	1 272	516	340
Баянгол	4 188	5 230	5 273	6 161	8 716
Баянзүрх	6 660	2 792	2 499	6 983	7 732
Налайх	887	154	114	2 309	1 531
Сонгинохайрхан	3 901	3 739	4 782	6 840	10 674
Сүхбаатар	3 216	1 333	3 604	2 084	4 159
Хан-Уул	3 170	1 397	3 070	3 680	5 757
Чингэлтэй	5 268	4 200	3 705	5 562	7 509

2016 онд ажиллах хүчний судалгааны дүнгээр тооцсон ажилгүйдлийн түвшин Орхон аймагт хамгийн өндөр (22.4%), Төв аймагт хамгийн бага (2.7%) байгаа бол нийслэлийн хэмжээнд 9.1 хувьтай байгаа нь улсын дунджаас 0.9 пунктээр доогуур байна.

Зураг 19. Ажилгүйдлийн түвшин, ажиллах хүчний судалгааны дүнгээр, 2016 он



Нийт ажиллагчдын 22.2 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 11.2 хувь нь барилгын, 10.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 8.6 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, 8.4 хувь нь боловсролын, 7.5 хувь нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалах салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад ажиллаж байна.


² Ажилгүй иргэн гэж тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

Хүснэгт 27. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2012	2013	2014	2015	2016	эмэгтэй
Ажиллагчид, бүгд	365 287	426 731	451 819	459 971	465 091	216 679
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	10 872	9 181	9 348	7 995	14 683	5 607
Уул уурхай, олборлолт	19 364	23 570	18 673	18 236	16 095	1 870
Боловсруулах үйлдвэрлэл	34 785	47 416	52 754	48 114	49 630	23 770
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	7 077	5 467	7 085	7 191	7 468	1 614
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	2 892	3 777	4 483	3 542	2 770	1 768
Барилга	37 571	48 396	57 825	60 682	51 916	10 210
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	72 893	89 275	95 526	99 031	103 422	56 657
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	30 816	36 929	39 233	42 213	40 215	9 217
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	18 872	17 807	22 927	22 390	19 325	13 850
Мэдээлэл, холбоо	10 556	12 815	13 803	12 205	14 262	5 778
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	9 649	12 456	14 305	13 263	12 983	8 089
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	905	616	885	733	767	367
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	5 998	8 164	7 566	8 581	8 234	3 788
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	9 896	11 401	9 048	12 952	12 287	4 770
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	26 388	27 208	30 049	31 024	34 774	14 886
Боловсрол	32 441	33 308	33 740	33 718	39 130	30 396
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	16 339	18 652	17 872	18 327	18 822	14 576
Урлаг, үзвэр, тоглоом наадам	3 203	5 032	4 610	7 281	5 870	2 924
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	11 418	13 009	10 535	10 951	11 317	6 244
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	526	635	355	430	393	73
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	2 826	1 617	1 197	1 112	728	225

Нийт ажиллагчдын 216.7 мянга (46.6%) нь эмэгтэй бөгөөд санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа, боловсролын салбарт эмэгтэйчүүд, эрэгтэй ажиллагчдаас илүү ажиллаж байгаа бол, уул уурхай, олборлолт, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, барилга, цахилгаан, хий, уур, агааржуулалт, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа зэрэг салбарт эмэгтэйчүүдийн оролцоо бага байна.

Зураг 20. Ажиллагчид, хүйс, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар



2016 онд уул уурхай, олборлолт, усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа, барилга, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, зочид буудал, байр, сүүц болон нийтийн хоолны үйлчилгээ, санхүү, даатгалын үйл ажиллагаа, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, урлаг, үзвэр, тоглоом наадам, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт ажиллагчдын тоо 2015 оноос буурч, бусад салбарт өсчээ.

Ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нь улсын дүнд харьцуулахад хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, агнуурын салбарт хамгийн бага буюу 4.2 хувь нь, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт ажиллагчид хамгийн их буюу 100 хувь нь нийслэл хотод тус тус ногдож байна.

Хүснэгт 28. Ажиллагчдын тоо, аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Ажиллагчид, бүгд	365 287	426 731	451 819	459 971	465 091
Компани	166 335	200 134	220 485	226 323	237 028
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	95 394	124 564	119 362	118 176	112 723
Төсөвт байгууллага	72 028	77 676	81 743	84 216	86 194
Улсын үйлдвэрийн газар	19 970	17 101	19 390	21 066	20 121
Нөхөрлөл	832	138	363	1 140	957
Хоршоо	954	798	1 701	1 449	1 514
Төрийн бус байгууллага	9 774	6 320	8 775	7 601	6 554

Нийслэлийн нийт ажил эрхлэгчдийг ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэрээр нь ангилбал, 237.0 мянга (51.0%) нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани, 112.7 мянга (24.3%) нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 86.2 мянга (18.5%) нь төсөвт, 20.1 мянга (4.3%) нь төрийн өмчит болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 1.0 мянга (0.2%) нь нөхөрлөл, 1.5 мянга (0.3%) нь хоршоо, 6.6 мянга (1.4%) нь төрийн бус байгууллагад тус тус ажиллаж байна.

Хүснэгт 29. Ажиллагчдын тоо, хөдөлмөр эрхлэлтийн статусаар

Хөдөлмөр эрхлэлтийн статус	2012	2013	2014	2015	2016
Ажиллагчид, бүгд	365 287	426 731	451 819	459 971	465 091
Цалин хөлстэй ажиллагч	265 045	295 211	312 161	321 407	340 286
Ажил олгогч	4 990	8 281	10 691	8 342	11 657
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	80 368	107 475	111 269	116 248	87 996
Мал аж ахуй эрхлэгч	5 213	4 923	6 164	4 694	9 994
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	8 987	10 715	11 008	9 158	15 074
Эдгээр статуст хамрагдах боломжгүй ажиллагч	684	126	526	122	84

2016 онд ажил эрхлэгчдийг хөдөлмөр эрхлэлтийн статусаар нь ангилбал, 340.3 мянга (73.2%) нь цалин хөлстэй ажиллагч, 11.7 мянга (2.5%) нь ажил олгогч, 88.0 мянга (18.9%) нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 10.0 мянга (2.2%) нь мал аж ахуй эрхлэгч, 15.1 мянга (3.2%) нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч байна.

Хүснэгт 30. Ажиллагчид, насны бүлгээр

Насны бүлэг	2012	2013	2014	2015	2016
Ажиллагчид, бүгд	365 287	426 731	451 819	459 971	465 091
15 - 19	5 358	3 604	4 664	4 497	2 728
20 - 24	35 937	44 225	43 964	41 718	35 379
25 - 29	63 763	72 058	75 178	71 374	76 432
30 - 34	57 426	65 987	67 981	73 906	75 951
35 - 39	60 244	64 245	81 020	78 806	76 068
40 - 44	49 566	63 267	62 684	65 961	65 672
45 - 49	44 813	54 842	53 957	58 064	59 176
50 - 54	31 222	38 392	41 488	42 530	46 965
55 - 59	11 955	16 843	14 749	18 001	19 838
60 - 64	2 650	2 824	3825	3 498	4 673
65 - 69	1 351	387	1 114	1 092	1 753
70 +	1 002	57	1 195	524	456

2016 онд ажил эрхлэгчдийг насны бүлгээр нь ангилбал, 38.1 мянга (8.2%) нь 15-24 насны, 152.4 мянга (32.8%) нь 25-34 насны, 141.7 мянга (30.5%) нь 35-44 насны, 106.1 мянга (22.8%) нь 45-54 насны, 26.7 мянга (5.7%) нь 55-аас дээш насны хүмүүс байна.

Хүснэгт 31. Ажиллагчид, боловсролын түвшнээр

Боловсролын түвшин	2012	2013	2014	2015	2016
Ажиллагчид, бүгд	365 287	426 731	451 819	459 971	465 091
Боловсролгүй	1 672	929	1 102	375	780
Бага	3 521	2 249	2 384	3 548	3 281
Суурь	21 566	21 491	14 527	16 390	13 177
Бүрэн дунд	115 478	96 598	54 709	58 157	57 158
Техникийн болон мэргэжлийн	31 404	81 344	143 832	144 350	154 769
Тусгай мэргэжлийн дунд	25 382	28 318	36 925	28 613	25 905
Дипломын дээд болон бакалавр	148 271	182 027	184 139	194 033	191 729
Магистр ба түүнээс дээш	17 993	13 775	14 202	14 505	18 292

2016 онд ажил эрхлэгчдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, 780 (0.2%) нь боловсролгүй, 3281 (0.7%) нь бага, 13.2 мянга (2.8%) нь суурь боловсролтой, 57.2 мянга (12.3%) нь бүрэн дунд, 154.8 мянга (33.3%) нь техникийн болон мэргэжлийн, 25.9 мянга (5.6%) нь тусгай дунд, 191.7 мянга (41.2%) нь дипломын дээд болон бакалавр, 18.3 мянга (3.9%) нь магистр ба түүнээс дээш боловсролтой иргэд байна.

2016 онд нийслэлийн хэмжээнд эдийн засгийн идэвхгүй хүн амын³ тоо 469.9 мянгад хүрчээ.

³ Эдийн засгийн идэвхгүй хүн амд хөдөлмөрийн нөхцөл, онцлогоос шалтгаалан тэтгэврийн наснаас өмнө тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон хүн ам, хөдөлмөрийн чадвараа 6 сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан иргэн, хөдөлмөрийн насны өдрөөр суралцагчид, хүндэтгэх ба хүндэтгэх бүс шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй болон хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн амыг хамруулна.

Хүснэгт 32. Эдийн засгийн идэвхгүй хүн ам, дүүргээр


Дүүрэг	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	342 441	398 194	394 638	423 708	469 923
Багануур, Багахангай	11 302	11 038	12 447	12 715	14 780
Баянгол	52 526	61 872	56 158	61 283	69 644
Баянзүрх	74 898	95 980	96 472	97 062	106 658
Налайх	10 221	12 646	11 422	9 256	10 592
Сонгинохайрхан	72 247	85 861	93 226	100 717	112 248
Сүхбаатар	43 429	43 123	40 303	44 303	47 700
Хан-Уул	33 765	42 862	38 187	45 918	53 410
Чингэлтэй	44 053	44 812	46 423	52 454	54 891

Эдийн засгийн идэвхгүй хүн амаас суралцдаг, сурахаар явах гэж байгаа, тэтгэврийн, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн нас хүрээгүй иргэдийг хасвал 161.4 мянган иргэн ямар нэг шалтгаанаар 2016 онд хөдөлмөр эрхлээгүй байна.

Хүснэгт 33. Эдийн засгийн идэвхгүй хүн ам

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	эмэгтэй
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, бүгд	342 441	398 194	394 638	423 708	469 923	289 494
Гэрийн ажилтай	34 642	32 640	32 977	30 523	33 490	25 882
Суралцдаг	112 807	130 050	130 353	132 504	135 782	71 180
Сурахаар явах гэж байгаа	1 659	1 630	2 372	2 759	3 843	1 188
Тэтгэвэрт	74 865	88 665	111 970	122 151	119 314	81 107
Өндөр настан	15 902	19 220	2 561	3 155	17 275	9 928
Хөгжлийн бэрхшээлтэй	22 578	26 155	28 442	30 632	32 078	13 696
Ажил хийхийг хүсээгүй	5 673	8 060	7 015	6 493	6 114	811
Хүүхэд асарсан	34 440	52 894	49 325	61 614	73 269	68 748
Өвчтэй байсан	8 271	8 542	7 199	6 640	10 207	4 275
Хөдөлмөрийн нас хүрээгүй	121	136	-	153	248	-
Өвчтөн, өндөр настан асарсан	4 100	4 409	4 186	5 643	6 476	4 225
Бусад	27 383	25 793	18 238	21 441	31 826	8 454

Зураг 21. Эдийн засгийн идэвхгүй хүн ам, 2016 он



Хөдөлмөр эрхлээгүй 161.4 мянган иргэний 20.8 хувь нь гэрийн ажилтай, 3.8 хувь нь ажил хийхийг хүсээгүй, 45.4 хувь нь хүүхэд асардаг, 6.3 хувь нь өөрөө өвчтэй, 4.0 хувь нь өвчтөн, өндөр настан асардаг, 19.7 хувь нь бусад шалтгааны улмаас хөдөлмөр эрхлээгүй байна.

Хүснэгт 34. Эдийн засгийн идэвхгүй хүн ам, мянган хүн, 2016 он

Үзүүлэлт	Нийслэлийн дүн	Үүнээс: дүүргээр							
		Багануур, Багахангай	Баянгол	Баянзүрх	Налайх	Сонгинохайрхан	Сүхбаатар	Хан-Уул	Чингэлтэй
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, бүгд	469.9	14.8	69.6	106.7	10.6	112.2	47.7	53.4	54.9
Гэрийн ажилтай	33.5	2.1	3.2	9.4	0.4	9.1	3.4	2.9	3.0
Суралцдаг	135.8	4.4	20.4	32.1	3.4	31.4	13.2	17.8	13.1
Сурахаар явах гэж байгаа	3.8	0.1	0.5	1.0	0.2	0.9	0.2	0.4	0.5
Тэтгэвэрт	119.3	3.3	20.5	23.6	2.4	26.2	12.3	13.8	17.2
Өндөр настан	17.3	0.3	2.6	2.0	0.4	4.9	3.6	1.3	2.2
Хөгжлийн бэрхшээлтэй	32.1	0.9	4.3	6.5	1.1	8.0	2.0	4.2	5.1
Ажил хийхийг хүсээгүй	6.1	-	1.2	1.7	0.1	0.6	0.7	1.1	0.7
Хүүхэд асарсан	73.3	1.5	12.0	19.5	1.8	17.2	7.2	7.8	6.3
Өвчтэй байсан	10.2	0.2	0.9	2.7	0.5	2.2	1.2	0.6	1.9
Хөдөлмөрийн нас хүрээгүй	0.2	-	-	0.1	-	-	0.1	-	-
Өвчтөн, өндөр настан асарсан	6.5	0.3	0.6	1.1	0.3	1.8	0.8	0.7	0.9
Бусад	31.8	1.7	3.4	7.0	-	9.9	3.0	2.8	4.0

Хүснэгт 35. Эдийн засгийн идэвхгүй хүн ам, насны бүлгээр

Насны бүлэг	2012	2013	2014	2015	2016
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, бүгд	342 441	398 194	394 638	423 708	469 923
Үүнээс:					
15 - 19	75 717	87 234	89 789	91 796	98 152
20 - 24	61 519	68 151	60 964	59 031	63 054
25 - 29	27 571	32 323	29 823	36 950	39 261
30 - 34	20 964	25 020	21 146	26 248	34 082
35 - 39	17 723	21 487	21 080	23 681	26 384
40 - 44	13 118	16 868	16 300	18 471	24 392
45 - 49	14 986	15 768	17 530	16 857	21 210
50 - 54	19 529	20 328	25 200	25 062	25 833
55 - 59	22 212	28 926	31 992	37 729	39 289
60 - 64	23 281	25 201	27 919	30 434	39 055
65 - 69	16 931	19 196	19 245	22 441	22 836
70 +	28 890	37 692	33 650	35 008	36 375

2016 оны эдийн засгийн идэвхгүй хүн амыг насны бүлгээр нь ангилбал, 161.2 мянга (34.3%) нь 15-24 насны, 73.3 мянга (15.6%) нь 25-34 насны, 50.8 мянга (10.8%) нь 35-44 насны, 47.0 мянга (10.0%) нь 45-54 насны, 137.6 мянга (29.3%) нь 55-аас дээш насны хүмүүс байна.

Хүснэгт 36. Эдийн засгийн идэвхгүй хүн ам, насны бүлэг, дүүргээр, мянган хүн, 2016 он

Насны бүлэг	Үүнээс: дүүргээр								
	Нийслэлийн дүн	Багануур, Багахангай	Баянгол	Баянзүрх	Налайх	Сонгинохайрхан	Сүхбаатар	Хан-Уул	Чингэлэй
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, бүгд	469.9	14.8	69.6	106.7	10.6	112.2	47.7	53.4	54.9
15 - 19	98.2	3.1	12.9	21.0	2.6	26.3	9.3	13.2	9.8
20 - 24	63.0	2.2	9.0	16.9	1.3	14.0	5.6	7.0	7.0
25 - 29	39.3	1.2	5.4	10.8	0.8	10.2	3.4	4.9	2.6
30 - 34	34.0	0.9	4.4	9.5	0.7	8.2	3.6	3.2	3.5
35 - 39	26.4	1.0	3.7	5.7	0.7	6.4	3.3	2.7	2.9
40 - 44	24.4	0.8	4.2	6.1	0.3	5.0	2.9	2.5	2.6
45 - 49	21.2	0.9	3.4	4.4	0.5	6.1	1.8	1.4	2.7
50 - 54	25.8	1.0	3.7	6.5	0.5	4.8	2.1	3.5	3.7
55 - 59	39.3	1.3	6.5	8.6	1.2	7.8	2.7	5.5	5.7
60 - 64	39.1	1.0	5.3	6.4	0.5	12.2	4.5	3.6	5.6
65 - 69	22.8	0.4	4.8	3.8	0.4	4.6	3.9	2.3	2.6
70 +	36.4	1.0	6.3	7.0	1.1	6.6	4.6	3.6	6.2

Хүснэгт 37. Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид⁴, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2016 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Үндсэн			Давхар		
	Эрэгтэй	Эмэгтэй			Эрэгтэй	Эмэгтэй
Ажиллагчид, бүгд	80 889	49 730	31 159	499	179	320
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	-	-	-	103	103	-
Уул уурхай, олборлолт	95	95	-	-	-	-
Боловсруулах үйлдвэрлэл	10 437	5 433	5 004	120	-	120
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	391	246	145	-	-	-
Барилга	3 424	2 298	1 126	276	76	200
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	37 516	19 178	18 338	-	-	-
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	18 639	17 773	866	-	-	-
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1 567	594	973	-	-	-
Мэдээлэл, холбоо	519	255	264	-	-	-
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	77	-	77	-	-	-
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	586	433	153	-	-	-
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	720	574	146	-	-	-
Боловсрол	110	-	110	-	-	-
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	269	-	269	-	-	-
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1 141	682	459	-	-	-
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5 202	2 047	3 155	-	-	-
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	196	123	73	-	-	-

Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийн 46.4 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 23.0 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, 12.9 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 6.4 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 4.2 хувь нь барилгын салбарт ажиллаж байна.

Нийт ажиллагчдын 31159 (38.5%) нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, боловсрол, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, үйлчилгээний бусад үйл ажиллагаа, мэдээлэл, холбооны салбарт эрэгтэй ажиллагчдаас эмэгтэйчүүд илүү олноор ажиллаж байгаа бол, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, урлаг, үзвэр, тоглоом наадам, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа, барилга, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, удирдлагын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт эмэгтэйчүүдийн ажиллах оролцоо бага байна.

⁴ Албан ёсны бүртгэл, нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдаагүй, аж ахуй эрхлэх зохион байгуулалтын хэлбэрт ороогүй, хөдөө аж ахуйн бүс бөгөөд хуулиар хориглоогүй ажил үйлчилгээ эрхэлж буй иргэдийг албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид гэнэ.

Хүснэгт 38. Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид, насны бүлэг, хүйсээр, 2016 он

Насны бүлэг	Үндсэн	Эрэгтэй	Эмэгтэй	Давхар	Эрэгтэй	Эмэгтэй
Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид, бүгд	80 889	49 730	31 159	499	179	320
15 - 19	154	154	-	-	-	-
20 - 24	3 219	2 142	1 077	76	76	-
25 - 29	7 824	5 659	2 165	120	-	120
30 - 34	9 844	6 328	3 516	-	-	-
35 - 39	13 921	9 207	4 714	200	-	200
40 - 44	17 569	9 941	7 628	-	-	-
45 - 49	13 418	7 277	6 141	-	-	-
50 - 54	10 130	5 927	4 203	103	103	-
55 - 59	4 006	2 700	1 306	-	-	-
60 - 64	502	395	107	-	-	-
65 - 69	205	-	205	-	-	-
70 +	97	-	97	-	-	-

2016 онд албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийг насны бүлгээр нь ангилбал, 3373 (4.2%) нь 15-24 насны, 17.7 мянга (21.8%) нь 25-34 насны, 31.5 мянга (38.9%) нь 35-44 насны, 23.5 мянга (29.1%) нь 45-54 насны, 4810 (6.0%) нь 55-аас дээш насны хүмүүс байна. 30-49 насны эрэгтэйчүүдийн хувьд албан бус хөдөлмөр эрхлэлт өндөр байгаа бол эмэгтэйчүүдийн хувьд 35-44 насныханд өндөр байна.

Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн бүртгэлтэй ажилгүй иргэдийн 11988 (34.8%) нь Улаанбаатар хотод амьдарч байна. Нийт ажилгүйчүүдийн 6062 (50.6%) нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 39. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлэг, боловсролын түвшнээр

Үзүүлэлт		2012	2013	2014	2015	2016	эмэгтэй
15-24		3 354	5 631	4 325	2 456	1 591	788
25-34		4 543	4 059	6 012	4 965	4 783	2 526
35-44		2 809	2 294	2 889	2 873	3 066	1 550
45+		2 105	2 159	2 561	2 346	2 548	1 198
Дээд боловсролтой		5 041	5 800	6 422	4 595	5 238	3143
Тусгай дунд боловсролтой		950	1 423	1 071	822	747	326
Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв төгссөн		918	750	851	611	583	210
Мэргэжилгүй		5 902	6 170	7 443	6 612	5 420	2383
Ажилгүй иргэд	Нийслэлийн дүн	12 811	14 143	15 787	12 640	11 988	6 062
	Улсын дүн	35 776	42 772	36 970	32 788	34 412	17 784
Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь		35.8	36.7	42.7	38.6	34.8	34.8


Боловсролын түвшнээр нь авч үзвэл, бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 5238 (43.7%) нь дээд, 747 (6.2%) нь тусгай дунд, 583 (4.9%) нь мэргэжлийн анхан шатны, 5375 (44.8%) нь ерөнхий боловсролтой, 45 (0.4%) нь мэргэжилгүй хүмүүс байна.

Хүснэгт 40. Бүртгэлтэй ажилгүй иргэд, дүүргээр

Дүүрэг	2012	2013	2014	2015	2016	эмэгтэй
Нийслэлийн дүн	12 811	14 143	15 787	12 640	11 988	6062
Багануур	357	311	418	589	579	307
Багахангай	173	77	126	112	134	71
Баянгол	1 854	2 426	2 489	1 807	1 532	836
Баянзүрх	1 446	2 670	3 290	2 068	2 443	1179
Налайх	1 395	1 266	1 093	642	706	374
Сонгинохайрхан	2 227	2 619	2 197	1 629	2 010	980
Сүхбаатар	2 729	1 635	1 925	1 844	1 378	751
Хан-Уул	919	1 027	1 964	1 247	1 509	733
Чингэлтэй	1 711	2 112	2 285	2 702	1 697	831

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 2443 (20.4%) нь Баянзүрх, 2010 (16.8%) нь Сонгинохайрхан, 1697 (14.1%) нь Чингэлтэй, 1532 (12.8%) нь Баянгол, 1509 (12.6%) нь Хан-Уул, 1378 (11.5%) нь Сүхбаатар, 706 (5.9%) нь Налайх, 579 (4.8%) нь Багануур, 134 (1.1%) нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

Зураг 22. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо





ӨРХИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН БҮТЭЦ

“Өрхийн орлого, зарлагын судалгаа”, “Амьжиргааны түвшний түүвэр судалгаа”-г нэгтгэн 2007 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-г зохион байгуулан явуулж байна.

Судалгаанд жил бүр нийслэлийн хэмжээнд 3600 өрхийг түүвэрлэн авч, нэг өрхөд ногдох дундаж үзүүлэлтийг жилийн турш уг судалгаанд хамрагдсан 3600 өрхийн дунджаар тооцдог.


“Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны дүнгээр нийслэлийн өрхийн сарын дундаж орлого 2016 онд өмнөх оноос 8.3 хувиар бүүрч 1073.1 мянган төгрөг болсон байна.

Хүснэгт 41. Нэг өрхийн сарын дундаж нийт орлого, төгрөг

Орлогын төрөл	2012	2013	2014	2015	2016
Нийт орлого, нийслэлийн дундаж	983 912	1 097 813	1 249 877	1 169 821	1 073 118
1. Мөнгөн орлого, бүгд	948 855	1 057 430	1 207 084	1 120 698	1 036 361
Цалин хөлс	534 713	630 724	744 295	719 515	652 244
Тэтгэвэр тэтгэмж	169 977	168 332	154 243	174 128	178 410
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	150 483	142 442	166 910	113 812	95 100
Бусад	93 682	115 932	141 636	113 243	110 607
2. Бусдаас үнэгүй авсан	31 699	36 361	39 278	46 166	35 081
3. Өөрийн хувийн аж ахуйгаас бэлтгэсэн хүнсний бүтээгдэхүүн	3 358	4 022	3 515	2 957	1 676
Нийт орлого, улсын дундаж	819 996	959 247	1 080 145	1 047 255	944 153
Нийслэл, улсын дунджийн зөрүү	163 916	138 566	169 732	122 566	128 965

2012 онд нэг өрхийн сарын дундаж орлого улсын дунджаас 163.9 мянган төгрөгөөр илүү байсан бол 2016 онд 129.0 мянган төгрөг болсон байна.

Зураг 23. Өрхийн мөнгөн орлогын бүтэц



2016 онд өрхийн мөнгөн орлогын 62.9 хувийг цалин хөлс, 17.2 хувийг тэтгэвэр, тэтгэмж, 9.2 хувийг өрхийн үйлдвэрлэл үйлчилгээний орлого, 10.7 хувийг бусад орлого бүрдүүлжээ. Өрхийн мөнгөн орлогын бүтцэд өрхийн бусад орлого, цалин хөлсний эзлэх хувийн жин улсын дунджаас 0.5-7.6 пунктээр дээгүүр байгаа бол тэтгэвэр тэтгэмж, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 2.0-6.1 пунктээр доогуур байна.


“Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны дүнгээр нийслэлийн нэг өрхийн сарын дундаж зарлагын хэмжээ улсын дунджаас 2012 онд 137.6 мянга, 2013 онд 80.8 мянга, 2014 онд 100.1 мянга, 2015 онд 33.1 мянга, 2016 онд 68.8 мянган төгрөгөөр тус тус өндөр байв.

Хүснэгт 42. Нэг өрхийн сарын дундаж зарлага

Зарлагын төрөл	2012	2013	2014	2015	2016
Нийт зарлага, нийслэлийн дундаж	957 902	1 042 471	1 176 705	1 097 902	1 034 986
1. Мөнгөн зарлага, бүгд	922 845	1 002 088	1 133 913	1 048 779	998 229
Хүнсний	279 951	308 910	332 780	307 887	267 146
Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага	642 895	693 178	801 133	740 892	731 083
2. Бусдаас үнэгүй авсан	31 699	36 361	39 278	46 166	35 081
3. Хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	3 358	4 022	3 515	2 957	1 676
Нийт зарлага, улсын дундаж	820 263	961 677	1 076 557	1 064 808	966 197
Нийслэл, улсын дунджийн зөрүү	137 639	80 794	100 148	33 094	68 789

Улсын дунджаар нэг өрхийн сарын дундаж зарлагын 91.6 хувийг мөнгөн зарлага эзэлж байхад нийслэлийн хувьд 96.4 хувийг эзэлж байна. Энэ нь өрхийн нийт зарлагын бүтцэд хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувийн жин хөдөө орон нутгийн айл өрхүүдтэй харьцуулахад нийслэлийн өрхүүдэд доогуур байгааг харуулж буй үзүүлэлт юм.

Зураг 24. Өрхийн мөнгөн зарлагын бүтэц



2016 онд өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 1035.0 мянган төгрөг болж 2012 оноос 8.1 хувиар өсч, өмнөх оноос 5.7 хувиар буурчээ. 2012 онд өрхийн мөнгөн зарлагын 69.7 хувийг хүнсний бус зарлага эзэлж байсан бол 2016 онд 73.2 хувийг эзлэх болжээ.

2000 оноос хувцас, гутал зэрэг таваарлаг бараа худалдан авах, орон сууц, тээвэр, холбооны зардал жил ирэх тутамд нэмэгдсээр байна. 2012 онд нийслэлийн нэг өрх сард дунджаар 279.9 мянган төгрөгийг хүнсний зүйл худалдан авахад зарцуулж байсан бол 2016 онд 267.1 мянга болж, 12805 төгрөгөөр (4.6%) буурсан байна.

2016 онд нийслэлийн нэг өрх сард дунджаар 998.2 мянган төгрөгийг хоол хүнс, хувцас гутал, байр орон сууц болон тээвэр, холбооны зардалд зарцуулж байна. Үүнээс, 267.1 (26.8%) мянган төгрөгийг зөвхөн хүнсний зүйл худалдан авахад зарцуулжээ.


Хүнсний хэрэглээ:

Нийслэлд амьдарч буй нэг хүний жилд хэрэглэсэн сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, будаа, ургамлын тосны хэрэглээ улсын дунджаас доогуур, харин өндөг, хүнсний ногоо, төмс, цөцгийн тосны жилийн дундаж хэрэглээ нь улсын дунджаас нэлээд дээгүүр байна. Тодруулбал, 2016 онд нэг хүний жилд хэрэглэсэн сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ 58.2 литрээр, мах, махан бүтээгдэхүүний хэмжээ 27.3 кг, гурил, гурилан бүтээгдэхүүний хэрэглээ 15.7 кг-аар улсын дунджаас доогуур байхад өндөгний хэрэглээ 36 ширхэг, хүнсний ногооны хэрэглээ 4.1 кг, төмсний хэрэглээ 3.3 кг, цөцгийн тосны хэрэглээ 0.7 кг-аар улсын дунджаас дээгүүр байна.

Хүснэгт 43. Хүнсний зарим бүтээгдэхүүний нэг хүний жилийн дундаж хэрэглээ, жишсэн хүнээр, кг

Нэр төрөл	2012		2013		2014		2015		2016	
	Улсын дундаж	Нийслэл	Улсын дундаж	Нийслэл	Улсын дундаж	Нийслэл	Улсын дундаж	Нийслэл	Улсын дундаж	Нийслэл
Мах, махан бүтээгдэхүүн	98.2	81.3	97.4	81.7	105.6	80.7	102.4	80.5	104.9	77.7
Сүү, сүүн бүтээгдэхүүн	160.7	92.7	161.1	94.9	162.9	91.4	165.6	88.0	133.1	74.9
Цөцгийн тос	3.7	5.1	3.7	4.6	3.6	4.5	3.7	4.8	3.0	3.7
Гурил, гурилан бүтээгдэхүүн	125.8	123.3	121.2	119.3	127.7	117.6	126.5	114.6	122.4	106.7
Будаа	21.4	21.8	21.7	21.7	22.6	21.5	21.3	20.7	22.2	19.7
Чихэр, сахарын зүйл	17.1	17.4	16.5	16.7	16.0	15.6	9.6	7.8	8.7	6.3
Өндөг /ширхэг/	38	81	43	87	43	84	49	91	47	83
Төмс	38.9	44.9	37.8	44.7	35.7	42.0	33.6	39.8	33.3	36.6
Хүнсний ногоо	23.5	33.3	24.4	34.6	24.9	32.4	24.0	30.3	22.4	26.6
Жимс, жимсгэнэ	8.3	9.3	8.7	9.4	9.7	9.4	8.5	8.4	7.1	7.5
Мал, ургамлын гаралтай тос	6.2	5.7	6.1	5.8	5.9	5.0	5.8	4.8	5.4	4.2

Зураг 25. Нэг хүнд сард ногдох хүнсний зарим бүтээгдэхүүний хэрэглээ, кг



Хүснэгт 44. Нэг хүнд сард ногдох хүнсний зарим бүтээгдэхүүний хэрэглээ, жишсэн хүнээр, кг


Нэр төрөл	2012	2013	2014	2015	2016
Мах, махан бүтээгдэхүүн	6.8	6.8	6.7	6.7	6.5
Сүү, сүүн бүтээгдэхүүн	7.7	7.9	7.6	7.3	6.2
Цөцгийн тос	0.4	0.4	0.4	0.4	0.3
Өндөг /ширхэг/	7	7	7	8	7
Гурил, гурилан бүтээгдэхүүн	10.3	9.9	9.8	9.6	8.9
Сахар, чихрийн зүйл	1.4	1.4	1.3	0.7	0.5
Будаа	1.8	1.8	1.8	1.7	1.6
Жимс, жимсгэнэ	0.8	0.8	0.8	0.7	0.6
Төмс	3.7	3.7	3.5	3.3	3.1
Хүнсний ногоо	2.8	2.9	2.7	2.5	2.2
Мал, ургамлын гаралтай тос	0.5	0.5	0.4	0.4	0.3

Ядуурлын түвшин:

Монгол Улсын “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” хуулийн тавдугаар зүйлд заасны дагуу 1998 оноос эхлэн “Хүн амын амьжиргааны доод түвшин”-г бүс нутгаар тодорхойлж байна. Тус хуулийн 3 дугаар зүйлд хүн амын амьжиргааны доод түвшин гэж хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг, хэрэглээний доод хэмжээ гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо, хэмжээг ойлгоно гэж заасан.

Нэг хүнд сард ногдох хүн амын амьжиргааны доод түвшинг жил бүр шинэчлэн тогтоож байгаа бөгөөд нийслэл хотод 2012 онд хүн амын амьжиргааны доод түвшин 126500 төгрөг байсан бол 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс 183700 төгрөг болсон.

Зураг 26. Ядуурлын гүнзгийрэлт



Ядуурлын хамралтын хүрээ буюу ядуурлын түвшин нь нийт хүн амд ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувийг харуулдаг. Ядуурлын хамралтын хүрээ нь ядуурлыг хэмжих хамгийн энгийн, өргөн хэрэглэгддэг үзүүлэлт юм.

2016 оны өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүнгээр нийслэлийн ядуурлын түвшин буюу ядуурлын хамралтын хүрээ 24.8 хувь болсон байна.

Өөрөөр хэлбэл, 100 хүн тутмын 25 нь зайлшгүй шаардлагатай хүнсний болон хүнсний бүс хэрэглээний зүйлсийг худалдан авах чадваргүй байна. Нийслэлийн хэмжээнд ядуурлын хамралтын хүрээ буюу ядуурлын түвшинг төв, хангай, баруун, зүүн бүс нутагтай харьцуулахад 2.0-19.1 пунктээр, улсын дунджаас 4.8 пунктээр тус тус доогуур байна.

Хүснэгт 45. Ядуурлын үндсэн үзүүлэлт⁵

Үзүүлэлт	Он	Ядуурлын хамралтын хүрээ		Ядуурлын гүнзгийрэлт		Ядуурлын мэдрэмж	
		Улсын дундаж	Нийслэлийн дундаж	Улсын дундаж	Нийслэлийн дундаж	Улсын дундаж	Нийслэлийн дундаж
Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа	2012	27.4	19.9	7.1	5.1	2.7	2.0
	2014	21.6	16.4	5.2	4.5	1.9	1.7
	2016	29.6	24.8	7.7	6.4	2.9	2.5

Ядуурлын дүр төрхийг илүү тодорхой болгох зорилгоор ядуурлын гүнзгийрэлт, ядуурлын мэдрэмж гэсэн хоёр үзүүлэлтийг нэмж тооцдог. Ядуурлын гүнзгийрэлт нь ядуу хүн амын хэрэглээний дундаж түвшин ядуурлын шугамаас хэдэн хувиар доогуур байгааг илэрхийлэх ба нийслэлийн ядуу хүн амын хэрэглээний дундаж түвшин нь ядуурлын шугамаас 6.4 хувиар доогуур байна. Харин бусад бүс нутгуудад ядуурлын гүнзгийрэлт 7.0-12.5 хувь буюу нийслэлийн дүнгээс 0.6-6.1 пунктээр илүү байгаа юм.

Ядуурлын мэдрэмж нь ядуу хүн амын дундах хэрэглээний тархалтыг харуулна. Тухайн өрхийн хэрэглээ нэмэгдсэн ч хэмжээ нь ядуурлын шугамаас доогуур байвал ядуурлын хамрах хүрээ, гүнзгийрэлт өөрчлөгдөхгүй харин ядуурлын мэдрэмж нь нэмэгдэнэ. 2016 онд энэхүү үзүүлэлт 2014 оноос 0.8 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

“Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны дүнгээр нийслэлийн ядуурлын түвшин улсын дунджаас доогуур хэвээр байж, ядуурлын түвшинг 2012-2014 онтой харьцуулахад 4.9-8.4 пунктээр өссөн байна.

⁵ Цаг хугацааны хувьд харьцуулах боломжийг ханган нэг суурьтай болгон тооцооллыг шинэчилсэн.



НИЙГМИЙН ДААТГАЛ

2016 онд нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээг давхардсан тоогоор 1893.3 мянган хүнд хүргэж, ажилласан байна. Нийт үйлчлүүлэгчдийн 27.7 хувийг нийгмийн даатгалын 5 төрлийн даатгалд даатгуулсан иргэд, 32.8 хувийг төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлсөн иргэд, 11.3 хувийг эмчилгээ үйлчилгээний зардал болон эмийн үнийн хөнгөлөлт эдэлсэн иргэд, үлдсэн 28.2 хувийг тэтгэвэр, тэтгэмж авагчид болон сайн дурын даатгуулагчид эзэлж байна.

Хүснэгт 46. Нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	3 553 419	1 757 769	2 044 822	2 030 240	1 893 228
Нийгмийн даатгалын 5 төрлийн даатгалд заавал даатгуулагчид	480 285	521 863	549 478	523 784	525 156
Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчид	48 288	70 326	88 672	95 072	95 273
Эрүүл мэндийн даатгалд заавал болон сайн дураар даатгуулагчид	135 549	141 757	150 023	149 331	161 328
Тэтгэвэр авагчид	123 728	125 912	139 769	147 816	155 513
Тэтгэмж, төлбөр авагчид	91 205	103 308	115 217	117 979	122 171
Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төр хариуцдаг иргэдийн тоо	574 217	617 357	806 477	790 703	620 591
Эмчилгээ үйлчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгосон иргэдийн тоо	2 100 147	177 246	195 186	205 555	213 196

Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд 2016 онд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 103.1 хувиар биелүүлж, нийгмийн даатгалын санд нийт 814.0 тэрбум төгрөг хуримтлуулсан байна.

Зураг 27. Даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөг



2016 онд нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 781.8 мянган хүн хамрагдаж, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлжээ. Нийт шимтгэл төлөгчдийн 67.2 хувийг нийгмийн даатгалын таван төрлийн даатгалд заавал даатгуулагчид, 32.8 хувийг эрүүл мэндийн даатгал болон сайн дурын даатгалд даатгуулсан иргэд эзэлж байна.

Хүснэгт 47. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц, дүүргээр, сая төгрөг

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	511 626.6	633 507.5	714 655.8	739 953.6	814 042.1
Багануур	8 032.5	10 143.8	10 695.0	12 046.7	12 293.4
Багахангай	689.3	979.2	1 055.1	1 188.9	1 482.6
Баянгол	92 660.4	117 806.4	134 268.8	137 736.4	152 053.0
Баянзүрх	60 417.8	78 100.9	92 135.1	99 744.9	108 614.0
Налайх	4 315.2	5 935.8	7 009.0	7 166.2	8 515.6
Сонгинохайрхан	29 421.3	41 640.7	49 288.8	51 660.3	58 763.3
Сүхбаатар	134 907.6	157 746.3	168 632.0	170 277.7	184 386.2
Хан-Уул	65 634.7	84 788.1	98 280.8	100 285.0	113 548.9
Чингэлтэй	112 957.1	136 249.9	153 246.0	159 847.5	174 385.1
Нийслэлийн НДГ	2590.7	116.4	45.2	0.0	0.0

Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас 2016 онд даатгуулагч, иргэдэд нийт 692.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээ, үйлчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгожээ.

Хүснэгт 48. Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая төгрөг

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	429 564.2	435 625.2	525 791.6	618 017.0	692 247.1
Тэтгэврийн даатгал	321 734.0	374 450.4	446 386.9	529 434.8	593 289.4
Тэтгэмжийн даатгал	24 916.7	35 412.2	48 202.3	53 635.9	57 237.9
Эрүүл мэндийн даатгал	66 917.5	4 245.9	5 443.4	5 778.6	6 459.1
Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал	11 684.3	12 972.0	13 307.3	13 519.0	13 469.6
Ажилгүйдлийн даатгал	4 311.7	8 544.7	1 2451.7	15 648.7	21 791.1

Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 85.7 хувийг тэтгэврийн, 0.9 хувийг эрүүл мэндийн, 1.9 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний, 8.3 хувийг тэтгэмжийн, 3.1 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас сард дунджаар 155.5 мянган хүнд тэтгэвэр олгосон бөгөөд олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 604.5 тэрбум төгрөгт хүрчээ. Олгосон нийт тэтгэврийн 73.8 хувийг өндөр насны, 11.7 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.5 хувийг тэжээгчээ алдсаны, 11.0 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.



БОЛОВСРОЛ

Сургуулийн өмнөх боловсрол: 2016-2017 оны хичээлийн жилд Монгол Улсын хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын 1354 байгууллага үйл ажиллагаа явуулж байснаас 623 (46.0%) нь нийслэлийн нутаг дэвсгэрт байрлаж байв. Үүнээс, 216 нь төрийн өмчийн, 407 нь

хувийн цэцэрлэг юм. Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад төрийн өмчийн цэцэрлэгийн тоо 2-оор, хувийн цэцэрлэгийн тоо 47-оор нэмэгджээ. Эдгээр цэцэрлэгүүдийн үндсэн бүлэгт 104353 хүүхэд, хувилбар сургалтад 732 хүүхэд, нийт 105085 хүүхэд хамрагдан хүмүүжсэн бөгөөд өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо 10.1 хувиар өсчээ.

Хүснэгт 49. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017*
СӨБ-ын байгууллагын тоо	351	437	503	574	623
Хамрагдагчдын тоо	67 432	76 785	83 575	95 466	105 085
Үндсэн багшийн тоо	2 177	2 450	2 515	2 828	3 184

Хүснэгт 50. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын зарим үзүүлэлт, дүүргээр


Үзүүлэлт	Бүгд	Үүнээс:								
		Баянгол	Баянзүрх	Сүхбаатар	Сонгинохайрхан	Чингэлтэй	Хан-Уул	Багануур	Налайх	Багахангай
Цэцэрлэгийн тоо	623	99	175	67	100	50	108	8	14	2
Өмчийн хэлбэр:										
Төрийн	216	33	38	32	43	25	28	8	7	2
Хувийн	407	66	137	35	57	25	80	-	7	-
Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчид, бүгд	105 085	18 650	23 949	12 187	20 987	10 121	14 048	2 302	2 516	325
Үүнээс:										
Төрийн цэцэрлэгт	77 706	14 957	14 407	9 991	16 373	8 216	9 009	2 302	2 126	325
Хувийн цэцэрлэгт	27 379	3 693	9 542	2 196	4 614	1 905	5 039	-	390	-
Үндсэн багш	3 184	566	727	364	620	249	497	85	64	12
Үүнээс:										
Төрийн цэцэрлэгт	1 999	389	332	254	450	189	235	85	53	12
Хувийн цэцэрлэгт	1 185	177	395	110	170	60	262	-	11	-
Туслах багш	2 834	509	632	324	550	234	441	74	58	12
Үүнээс:										
Төрийн цэцэрлэгт	1 816	361	296	225	412	172	218	74	46	12
Хувийн цэцэрлэгт	1 018	148	336	99	138	62	223	-	12	-

2016-2017 оны хичээлийн жилд 31948 хүүхэд цэцэрлэгт шинээр элсэн оржээ. Үүнээс, төрийн өмчийн цэцэрлэгт 18581, хувийн цэцэрлэгт 13367 хүүхэд элссэн байна. Нийслэлийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролд хамрагдвал зохих 2-5 насны нийт хүүхдийн 74.6 хувь нь хамрагджээ. Үндсэн бүлгийн нийт хүүхдээс ердийн цагийн хуваариар үйл ажиллагаагаа явуулж буй цэцэрлэгт 101438 хүүхэд, 24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэгт 2340 хүүхэд, тусгай сургалттай цэцэрлэгт 201 хүүхэд, сувиллын үйл ажиллагаатай цэцэрлэгт 374 хүүхэд хамрагдан хүмүүжсэн байна.

* Төмөр замын харьяа цэцэрлэгүүдийн тоо ороогүй болно.

Хувилбарт сургалтын бүлгийн нийт хүүхдээс 723 нь ээлжийн бүлэгт, 9 нь нүүдлийн гэр цэцэрлэгт хүмүүжсэн байна.

Зураг 28. Цэцэрлэгт хамрагдалтын хувь



Хүснэгт 51. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчид, насаар

Нас	2012-2013		2013-2014		2014-2015		2015-2016		2016-2017	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
2 хүртэлх	2 496	1 205	3 181	1 476	3 924	1 948	2 789	1 334	1 607	781
2	11 639	5 819	14 238	7 021	18 529	9 294	19 926	9 840	22 009	10 979
3	17 466	8 766	17 773	8 919	21 215	10 504	24 412	12 202	26 910	13 285
4	18 176	8 981	21 206	10 578	21 922	11 008	24 924	12 282	27 721	13 770
5	17 153	8 513	20 009	9 771	17 866	8 771	23 062	11 334	26 612	13 060
6	502	231	378	150	119	47	354	137	226	92

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажилласан 10893 ажилчдын 3184 (29.2%) нь үндсэн багш (эмэгтэй 3103), 2834 (26.0%) нь туслах багш (эрэгтэй багш 1), 4875 (44.8%) нь бусад ажилчид байна. Үндсэн нэг багшид дунджаар 33 хүүхэд ногдож байгаа нь улсын дундажтай харьцуулахад 0.9 хувиар доогуур байна. Чингэлтэй дүүрэгт хамгийн их буюу нэг багшид 41 хүүхэд ногдож байхад Багануур дүүрэгт хамгийн бага буюу нэг багшид 27 хүүхэд ногдож байна.

Хүснэгт 52. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчид

Үзүүлэлт	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017*	2016 – 2017 2015 – 2016 %
Хамрагдагчид, бүгд	67 432	76 785	83 575	95 466	105 085	110.1
Үүнээс: эмэгтэй	33 515	37 930	41 572	45 884	51 967	113.3
Үндсэн бүлэгт	66 206	75 819	82 879	94 581	104 353	110.3
Хувилбарт сургалтад	1 226	966	696	885	732	82.7
Үүнээс:						
Ээлжийн	1 172	937	675	871	723	83.0
Нүүдлийн	22	16	21	14	9	64.3
Явуулын багшийн	32	13	-	-	-	-

* Төмөр замын харьяа цэцэрлэгүүдийн тоо ороогүй болно.

Хүснэгт 53. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлгийн тоо

Үзүүлэлт	Бүгд	Үүнээс:							Хувилбарт сургалт	Ээлжийн	Нүүдлийн
		Үндсэн сургалт	Ясли	Бага	Дунд	Ахлах	Бэлтгэл	Холимог			
Бүлгийн тоо	3 068	3 036	35	747	709	743	636	166	32	31	1
Үүнээс:											
Төрийн цэцэрлэгт	1 745	1 714	14	344	416	439	480	21	31	30	1
Хувийн цэцэрлэгт	1 323	1 322	21	403	293	304	156	145	1	1	-

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг хэв шинжээр нь ангилбал, асрамжийн 1, сувиллын 6, ердийн үйл ажиллагаатай 616 байгууллага байна.

2016-2017 оны хичээлийн жилд нийслэлийн нийт 623 цэцэрлэг хичээлийн 677 байранд үйл ажиллагаа явуулсан байна. Үүнээс, төрийн өмчийн цэцэрлэг өөрийн 259, түрээсийн 2, хувийн цэцэрлэг өөрийн 344, түрээсийн 72 хичээлийн байранд үйл ажиллагаа явуулжээ. Эдгээр цэцэрлэгүүд байрны нийт хүчин чадлаасаа 1.6 дахин их хүүхэд хүлээн авч үйл ажиллагаагаа явуулсан нь нийслэлд цэцэрлэгийн барилгын тоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байгааг харуулж байна.

Бага, дунд боловсрол:

2016-2017 оны хичээлийн жилд Монгол Улсын хэмжээнд ерөнхий боловсролын 778 сургууль үйл ажиллагаа явуулснаас 225 (28.9%) нь нийслэлийн нутаг дэвсгэрт байрлаж байв. Эдгээрийн 94 (41.8%) нь төрийн бус өмчийн сургууль байна. Нийслэлийн ерөнхий боловсролын нийт сургуулийн 58.7 хувь нь Сүхбаатар, Баянгол, Баянзүрх дүүргүүдэд төвлөрч байна. Мөн төрийн бус өмчийн сургуулиудын олонх нь дээрх 3 дүүрэгт төвлөрч байгаа юм. Тухайлбал, төрийн бус өмчийн сургуулиудын 67.0 хувь нь дээрх дүүргүүдэд байршин үйл ажиллагаа явуулжээ.

Хүснэгт 54. Ерөнхий боловсролын сургуулийн зарим үзүүлэлт

Үзүүлэлт	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017
Сургуулийн тоо	207	203	213	214	225
Суралцагчдын тоо	186 822	192 324	202 510	221 320	233 545
Үндсэн багшийн тоо	9 521	9 845	10 119	10 530	11 084

Хүснэгт 55. Ерөнхий боловсролын сургуулийн тоо

Хичээлийн жил		2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017
Сургуулийн тоо		207	203	213	214	225
Төрийн өмчийн		111	114	119	123	131
Төрийн бус өмчийн		96	89	94	91	94
ЕБС-ийн ангилал	Бага сургууль	5	7	8	8	16
	төрийн бус өмчийн	4	6	7	6	7
	Дунд сургууль	8	3	11	4	3
	төрийн бус өмчийн	4	-	7	1	-
	Ахлах сургууль	178	177	174	182	186
	төрийн бус өмчийн	88	83	76	80	83
	Цогцолбор сургууль	16	16	20	20	20
	төрийн бус өмчийн	-	-	4	4	4

Улсын хэмжээнд нийт 552.0 мянган хүүхэд суралцаж байснаас нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудад 233.5 мянган хүүхэд (үүнээс 49.9 хувь буюу 116.5 мянга нь эмэгтэй) суралцаж байв. Төрийн бус өмчийн сургуульд нийт 24.5 мянган хүүхэд суралцсан нь өмнөх хичээлийн жилээс 3.5 хувиар өсчээ.

Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчдаас 127.2 мянган хүүхэд I-V ангид, 68.0 мянга нь VI-IX ангид, 38.3 мянган хүүхэд ахлах буюу X-XII ангид суралцжээ.

2016-2017 хичээлийн жилд улсын хэмжээнд суурь боловсролын хамран сургалтын бохир жин⁶ 98.4 хувь, бага боловсролынх 99.1 хувь, дунд боловсролынх 101.7 хувьтай байна. Нийслэлд суурь боловсролын хамран сургалтын бохир жин 98.9 хувь, бага боловсролынх 98.5 хувь, дунд боловсролын хамран сургалт 99.5 хувьтай байв. Энэ нь 2015-2016 оны хичээлийн жилтэй харьцуулахад бага боловсролын хамран сургалтын бохир жин 0.7 пунктээр, дунд боловсролын хамран сургалтын бохир жин 2.0 пунктээр буурч, суурь боловсролын хамран сургалтын бохир жин 0.5 пунктээр өссөн байна.

Ерөнхий боловсролын 12 сургуулийн нийт 15 дотуур байр (төрийн өмчийн 11, төрийн бус өмчийн 4) үйл ажиллагаа явуулсан байна. Дотуур байранд 1536 хүүхэд амьдрах хүсэлт гаргаж, 1279 хүүхэд (үүнээс 466 нь эмэгтэй) амьдарчээ. Дотуур байранд амьдарсан нийт хүүхдийн 50.1 хувийг 12-15 насныхан эзэлж байна.

Хүснэгт 56. Ерөнхий боловсролын сургуулийн тоо, дүүргээр

Дүүрэг	2012-2013		2013-2014		2014-2015		2015-2016		2016-2017	
	Бүгд	төрийн бус	Бүгд	төрийн бус	Бүгд	төрийн бус	Бүгд	төрийн бус	Бүгд	төрийн бус
Нийслэлийн дүн	207	96	203	89	213	94	214	91	225	94
Багахангай	1	-	1	-	1	-	1	-	1	-
Багануур	3	1	3	1	4	1	4	1	4	1
Налайх	6	2	7	2	7	2	7	2	7	2
Хан-Уул	24	8	19	3	22	5	29	11	32	13
Чингэлтэй	21	8	23	9	23	9	21	7	23	8
Сонгинохайрхан	22	8	24	8	24	8	24	8	26	7
Баянзүрх	36	16	36	15	39	18	38	17	43	19
Баянгол	42	25	40	23	44	25	40	21	43	24
Сүхбаатар	52	28	50	28	49	26	50	24	46	20

Хүснэгт 57. Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид, дүүргээр

Дүүрэг	2012-2013		2013-2014		2014-2015		2015-2016		2016-2017	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Нийслэлийн дүн	186 822	93 477	192 324	95 971	202 510	100 958	221 320	110 776	233 545	116 505
Багахангай	554	278	563	275	574	263	645	314	690	321
Багануур	5 231	2 629	5 149	2 599	5 259	2 659	5 496	2 782	5 553	2 792
Налайх	5 405	2 752	5 628	2 846	5 798	2 939	6 335	3 224	6 646	3 335
Хан-Уул	16 581	8 125	16 641	8 136	18 878	9 213	22 741	11 154	25 532	12 518
Чингэлтэй	21 959	11 091	22 607	11 353	23 739	11 944	25 265	12 737	26 212	13 178
Сонгинохайрхан	35 511	17 705	37 211	18 621	38 739	19 533	41 655	21 037	44 003	22 181
Баянзүрх	40 948	20 689	42 325	21 191	44 609	22 204	49 076	24 500	51 982	25 873
Баянгол	30 502	15 300	31 058	15 598	32 776	16 409	35 719	17 957	37 609	18 759
Сүхбаатар	30 131	14 908	31 142	15 352	32 138	15 794	34 388	17 071	35 318	17 548

⁶ Суралцаж буй хүүхдийн тоог тухайн шатанд суралцах насны хүн амд харьцуулж тооцсон үзүүлэлт.

Хүснэгт 58. Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид, улс, нийслэлээр, мянган хүн

Хичээлийн жил	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017
Нийт суралцагчид, улсын хэмжээнд	496.1	497	505.8	535.1	552.0
Үүнээс: эмэгтэй	249	249	253.5	269.4	277.0
Нийслэлд суралцагчид, бүгд	186.8	192.3	202.5	221.3	233.5
Үүнээс: эмэгтэй	93.5	96	101	110.8	116.5
Бүгдээс:					
Төрийн өмчийн сургуульд	165.9	171.2	180.3	197.6	209.0
Үүнээс: эмэгтэй	83.3	85.7	90.1	99.2	104.5
Төрийн бүс өмчийн сургуульд	20.9	21.1	22.2	23.7	24.5
Үүнээс: эмэгтэй	10.2	10.3	10.9	11.5	11.9

2016-2017 оны хичээлийн жилд Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулсан ерөнхий боловсролын нийт сургуулиудад 28.9 мянган үндсэн багш ажиллаж байснаас 11.1 мянга (эмэгтэй 83.5%) нь нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудад ажиллаж байв.

Нийслэлийн нийт багш нарын 8.5 хувь нь анхны жилдээ, 33.5 хувь нь 1-4 жил, 3.9 хувь нь 5 жил, 13.8 хувь нь 6-9 жил, 3.2 хувь нь 10 жил, 12.3 хувь нь 11-15 жил, 8.8 хувь нь 16-20 жил, 5.0 хувь нь 21-25 жил, 11.0 хувь нь 25 ба түүнээс дээш жил ажиллажээ.

Боловсролын түвшнээр нь ангилбал, 1490 (13.5%) нь дипломын, 7648 (69.0%) нь бакалавр, 1796 (16.2%) нь магистр, 134 (1.2%) нь бусад, 16 (0.1%) нь докторын зэрэгтэй багш нар байна.

Хүснэгт 59. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш, улс, нийслэлээр, мянган хүн


Хичээлийн жил	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017
Үндсэн багш, улсын хэмжээнд	26.9	27.2	27.4	28.5	28.9
Үүнээс: эмэгтэй	21.9	22.1	22.3	23.1	23.5
Үндсэн багш, нийслэлд	9.5	9.8	10.1	10.5	11.1
Үүнээс: эмэгтэй	8	8.2	8.5	8.8	9.3
Бүгдээс:					
Төрийн өмчийн сургуульд	7.9	8.2	8.4	8.8	9.3
Үүнээс: эмэгтэй	6.8	6.9	7.1	7.4	7.8
Төрийн бүс өмчийн сургуульд	1.6	1.6	1.7	1.7	1.8
Үүнээс: эмэгтэй	1.2	1.3	1.4	1.3	1.5

Мэргэжлийн зэргээр нь ангилбал, зөвлөх багш 44, тэргүүлэх зэргийн багш 1247, заах арга зүйч 3162 байна. Насны ангиллаар нь авч үзвэл, 32.5 хувь нь 30 хүртэлх настай, 29.4 хувь нь 30-39 настай, 24.2 хувь нь 40-49 настай, 12.7 хувь нь 50-59 настай, 1.2 хувь нь 60 ба түүнээс дээш настай байна. Сүүлийн хоёр хичээлийн жилд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн нэг багшид ногдох сурагчдын тоо 21 байв. Энэ нь улсын дундажтай харьцуулахад 7.7-9.9 хувиар илүү байгаа юм.

Хүснэгт 60. Ерөнхий боловсролын сургуулийн нэг багшид ногдох сурагчдын тоо, улс, нийслэлээр

Хичээлийн жил	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017
Улсын дундаж	18.5	18.3	18.4	19.5	19.1
Нийслэлийн дундаж	19.6	19.5	20	21	21

Зураг 29. ЕБС-ийн 1-р ангид шинээр элсэгчид




Нийслэлийн Боловсролын газрын албан ёсны мэдээгээр нийслэлийн хэмжээнд 2016-2017 оны хичээлийн жилд 1-р ангид 28447 хүүхэд элсэн орсон байна. Нийт элсэгчдийн 94.2 хувийг 6 настай элсэгчид эзэлж байна. Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад нэгдүгээр ангид элсэгчдийн тоо 629 (2.2%) хүүхдээр буурсан байна.

Ерөнхий боловсролын сургуульд суралцдаггүй 6-14 насны 21 хүүхэд (үүнээс, эмэгтэй 7) бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн эдгээр 21 хүүхдийн 16 (76.2%) нь сургуульд огт хамрагдаагүй, 5 (23.8%) нь сургуульд ороод завсардсан хүүхдүүд байна.

Сургуульд огт хамрагдаагүй нийт хүүхдээс 52.4 хувь нь өвчний улмаас сургуульд суралцаагүй байхад сургуульд ороод завсардсан нийт хүүхдийн тухайд авч үзвэл амьдралын гачигдлын улмаас 1, сурах дүргүйгээс 3, өвчний улмаас 1 хүүхэд завсардсан байна.

Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдаас гадна орой, эчнээ, дүйцсэн хөтөлбөрөөр нийслэлийн хэмжээнд нийт 1197 суралцагч сүрчээ. Эдгээрийн 432 (36.1%) нь эмэгтэй сурагчид юм.

Зураг 30. Орой, эчнээ, дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчид, насаар




Техникийн болон мэргэжлийн боловсрол:

2016-2017 оны хичээлийн жилд нийслэлийн нутаг дэвсгэрт 44 сургалтын байгууллага техникийн болон мэргэжлийн боловсрол олгох сургалт явуулж байв. Үүнд, бие даасан үйл ажиллагаатай 23 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөс гадна 21 их, дээд сургууль, коллеж техникийн болон мэргэжлийн боловсрол олгож байна.

Хүснэгт 61. Техникийн болон мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагын тоо

Хичээлийн жил	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017
Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв*	14	15	15	20	23
Үүнээс:					
Төрийн өмчийн	2	3	3	4	4
Төрийн бус өмчийн	12	12	12	16	19

Зураг 31. МСҮТ-д шинээр элсэгчдийн тоо



Улсын хэмжээнд мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 40.1 мянган суралцагч суралцаж байсны 19.8 мянга (49.3%) нь нийслэлийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцсан байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцагчдын 7.9 мянга (39.9%) нь эмэгтэйчүүд байна. Төгсөх ангид 6836 оюутан суралцсан байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд нийт 1993 (үүнээс, эмэгтэй 1271) ажилчид ажилласан бөгөөд

60.3 хувь буюу 1202 (үүнээс, эмэгтэй 790) нь үндсэн багш, 120 (үүнээс, эмэгтэй 72) нь цагийн багш байв.

Хүснэгт 62. Техникийн болон мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагад суралцагчид

Хичээлийн жил	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	$\frac{2016-2017}{2015-2016} \%$
Суралцагчдын тоо	19 000	18 182	18 404	20 111	19 823	98.6
Үүнээс:						
Төрийн өмчийн	10 067	10 023	9 754	10 261	10 231	99.7
Төрийн бус өмчийн	8 933	8 159	8 650	9 850	9 592	97.4

* Олгож буй боловсролын түвшнээс хамаарч зарим МСҮТ-ийн тоо их, дээд сургууль, коллежийн тоонд орсон болно.

Дээд боловсрол:

2016-2017 оны хичээлийн жилд улсын хэмжээнд нийт 95 их, дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулснаас нийслэлийн нутаг дэвсгэрт 87 нь байрлаж байв. Үүнээс төрийн өмчийн 14, төрийн бус өмчийн 69, гадаадын салбар 4 сургууль байна.

Хүснэгт 63. Дээд боловсрол олгох сургалтын байгууллага, төрлөөр

Хичээлийн жил	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017
Бүгд	90	91	92	91	87
Их сургууль	16	17	17	23	29
Төрийн өмчийн	9	9	9	11	11
Төрийн бус өмчийн	7	8	8	12	18
Дээд сургууль, коллеж	70	70	71	64	54
Төрийн өмчийн	3	4	4	3	3
Төрийн бус өмчийн	67	66	67	61	51
Гадаадын салбар сургууль	4	4	4	4	4

Улсын хэмжээнд их, дээд сургууль, коллежид нийт 157.1 мянган оюутан суралцаж байснаас 143.7 мянга (91.4%) нь нийслэлд суралцсан байна. Үүнээс 82.1 мянга (57.1%) нь эмэгтэй оюутан байна.

2016-2017 оны хичээлийн жилд дээд боловсрол олгох сургуульд суралцагчдын тоог өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад бакалаврын ангид суралцагчдын тоо 4.6 хувиар буурч, магистрантурт суралцагчид 5.2 хувь, докторантурт суралцагчид 15.7 хувиар тус тус өссөн байна. Бакалаврын ангид суралцагчдын 54.5 хувь нь төрийн өмчийн, 45.3 хувь нь төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллежид, 0.2 хувь нь гадаадын салбар сургуулиудад суралцсан байна.

Магистрантурт суралцагчдын 62.1 хувь нь төрийн өмчийн, 37.9 хувь нь төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллежид суралцжээ. Харин докторантурт суралцагчдын 84.2 хувь нь төрийн өмчийн, 15.8 хувь нь төрийн бус өмчийн сургууль, коллежид суралцсан байна.

Хүснэгт 64. Бакалаврын өдрийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээ, мянган төгрөг

Үзүүлэлт	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017
Төрийн өмчийн сургууль	921.4	1 149.8	1 490.1	1 688.0	1 913.0
Төрийн бус өмчийн сургууль	1 093.8	1 292.3	1 595.1	1 842.3	1 952.2
Төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн дундаж	1 007.6	1 221.1	1 542.6	1 765.1	1 932.6
Өмнөх онтой харьцуулсан өсөлтийн хувь (%)					
Төрийн өмчийн сургууль	12.6	24.8	29.6	13.3	13.3
Төрийн бус өмчийн сургууль	21.4	18.1	23.4	15.5	6.0

2016-2017 оны хичээлийн жилд бакалаврын өдрийн ангийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээ төрийн өмчийн сургуульд 1.9 сая төгрөг, төрийн бус өмчийн сургуульд 2.0 сая орчим төгрөг байна. Үүнийг өмнөх хичээлийн жилтэй харьцуулбал төрийн өмчийн сургуулийн сургалтын төлбөр 13.3 хувиар, төрийн бус өмчийн сургуулийнх 6.0 хувиар нэмэгдсэн байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулсан гадаадын салбар сургуулиудад нийт 265 оюутан суралцсан нь бүгд бакалаврын дээд боловсрол олгох өдрийн ангид суралцжээ.


Хүснэгт 65. Дээд боловсрол олгох сургалтын байгууллагад суралцагчид, сургуулийн төрлөөр

Хичээлийн жил	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	$\frac{2016/2017}{2015/2016} \%$
Бүгд	156 128	156 538	161 632	148077	143684	97.0
Их сургууль	114 019	112 547	116 113	111 307	122 131	109.7
Төрийн өмчийн	87 806	85 344	87 807	81 312	79 203	97.4
Төрийн бус өмчийн	26 213	27 203	28 306	29 995	42 928	143.1
Дээд сургууль, коллеж	41 762	43 581	45 182	36 472	21 288	58.4
Төрийн өмчийн	1 621	1 809	1 985	1 559	1 583	101.5
Төрийн бус өмчийн	40 141	41 772	43 197	34 872	19 705	56.5
Гадаадын салбар сургууль	347	410	337	298	265	88.9

2016-2017 оны хичээлийн жилд бакалаврын өдрийн ангид шинээр элссэн 33.2 мянган оюутан (үүнээс, 56.8 хувь нь эмэгтэй) байгаагаас 26.5 мянга (79.9%) нь тухайн жилд 12-р анги төгсөгчдөөс элссэн байна. Нийслэлийн их, дээд сургууль, коллежид суралцагчдын 69.5 мянга (48.4%) нь нийслэлийн харьяалалтай, 74.2 мянга (51.6%) нь хөдөө орон нутгийн харьяалалтай байна.

Дотуур байранд суухаар 12590 оюутан санал өгснөөс 12374 нь дотуур байранд амьдарсан байна. Сургуулийнхаа дотуур байранд 11198 (үүнээс, эмэгтэй 8238), бусад сургуулийн дотуур байранд 1176 (үүнээс, эмэгтэй 666) оюутан амьдарчээ. Дотуур байранд суугчдын тоог өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад санал өгөгчдийн тоо 850, дотуур байранд суугчдын тоо 1316 оюутнаар нэмэгджээ.

Зураг 32. Их, дээд сургууль, коллежид суралцагчдын тоо, насаар



Нийт суралцагчдыг сургалтын төлбөрийн хэлбэрээр нь ангилбал, 0.7 мянга (0.4%) нь төрийн сангийн хөнгөлөлттэй зээлээр, 5.1 мянга (3.3%) нь төрөөс үзүүлэх бүцэлтгүй тусламжаар, 1.8 мянга (1.2%) нь төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтын дагуу сургалтын төлбөр нь төлөгдсөн бол 1.0 мянга (0.7%) нь тухайн сургуулийн зардлаар, 144.8 мянга (92.1%) нь хувийн зардлаар, 3.7 мянга (2.3%) нь бусад хэлбэрийн зардлаар суралцжээ.

Хүснэгт 66. Дээд боловсрол олгох сургалтын байгууллагад суралцагчид, боловсролын зэргийн ангиллаар

Үүнээс:															
Нийт суралцагчид							Өдрөөр суралцагчид								
Хичээлийн жил	Бүгд	Дипломын дээд	Бакалаврын дээд	Магистрантур	Докторантур	Бүгд	Дипломын дээд	Бакалаврын дээд	Магистрантур	Докторантур	Бүгд	Дипломын дээд	Бакалаврын дээд	Магистрантур	Докторантур
2012-2013	156 128	-	137 508	15 483	3 137	140 647	-	125 856	12 351	2 440	15 481	-	11 652	3 132	697
2013-2014	156 538	-	136 149	17 117	3 272	140 956	-	124 130	14 259	2 567	15 582	-	12 019	2 858	705
2014-2015	161 632	-	140 296	17 977	3 359	144 293	-	126 495	15 155	2 643	17 339	-	13 801	2 822	716
2015-2016	148 077	-	127 591	17 226	3 260	131 598	-	113 931	15 057	2 610	16 479	-	13 660	2 169	650
2016-2017	143 684	-	121 778	18 131	3 775	128 175	-	109 426	15 730	3 019	15 509	-	12 352	2 401	756



ЭРҮҮЛ МЭНД


2016 онд нийслэлийн иргэдэд эрүүл мэндийн салбарын үйлчилгээг 1898 байгууллагын нийт 25.3 мянган мэргэжилтнүүд үзүүлсэн байна. Тухайлбал, 5986 их эмч, 1037 эм зүйч, 11012 дээд мэргэжлийн, 252 бага эмч, 513 лаборант, 376 гэрлийн техникч, 705 эм найруулагч, 5907 сувилагч, 288 эх баригч, 8336 дунд мэргэжлийн, бусад мэргэжлийн 5906 ажилчид ажиллаж, иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлжээ.

Хүснэгт 67. Эрүүл мэндийн байгууллагын тоо

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв	16	16	13	13	13
Дүүргийн нэгдсэн эмнэлэг	12	12	12	12	12
Амаржих газар	3	3	3	3	3
Өрхийн эмнэлэг	131	136	134	134	138
Хувийн эмнэлэг	675	631	751	778	850
Рашаан сувилал	66	45	73	89	71
Эмийн сан	477	373	469	461	515

Улсын хэмжээнд эрүүл мэндийн салбарт ажиллагчдын 25.3 мянга (52.4%) нь нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад ажилласан байна. Мөн их эмч нарын 59.9 хувь, эм зүйч нарын 65.4 хувь, эмнэлгийн дунд мэргэжлийн ажилтны 44.1 хувь нь тус тус нийслэл хотод ажиллажээ.

Зураг 33. Нэг их эмчид ногдох хүний тоо, аймаг, нийслэлээр



2016 онд нийслэлийн нэг их эмчид 231 хүн, нэг сувилагчид 234 хүн ногдож байгаа нь бусад бүс нутаг, аймгуудтай харьцуулахад хамгийн бага үзүүлэлттэй байна.

Хүснэгт 68. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын тоо

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Бүгд	22 399	23 160	23 923	24 994	25 254
Үүнээс: эмэгтэй	18 510	18 868	19 724	20 594	20 838
Их эмч, бүгд	5 359	5 510	5 793	5 834	5 986
Үүнээс: эмэгтэй	4 217	4 277	4 709	4 615	4 730
Дотрын	544	569	708	658	632
Мэс заслын ба гэмтлийн	384	398	421	428	448
Эх барих эмэгтэйчүүдийн	406	418	419	451	472
Хүүхдийн	321	318	317	337	341
Халдвартын	147	146	125	182	182
Хавдар судлалын	43	43	36	31	32
Нүдний	85	104	97	97	103
Чих, хамар, хоолойн	95	89	86	86	101
Сүрьеэгийн	60	57	60	48	54
Арьсны	85	95	97	92	66
Рентгений	237	263	290	320	324
Мэдрэл, сэтгэл мэдрэлийн	280	272	301	287	291
Физик эмчилгээний	87	106	95	92	109
Стоматологийн	561	538	701	760	772
Лабораторын	232	239	228	219	227
Бусад мэргэжлийн	1 792	1 855	1 812	1 746	1 832
Эм зүйчид	1 153	1 248	1 208	1 025	1 037

Хүснэгт 69. Эмнэлгийн дунд мэргэжилтний тоо

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Бүгд	7 563	7 826	8 075	8 362	8 336
Бага эмч	237	231	267	276	252
Эм найруулагч	1 291	1 396	829	769	705
Лаборант	431	451	466	501	513
Сувилагч	5 003	5 056	5 598	5 898	5 907
Рентгений техникч	114	129	336	381	376

2016 онд улсын хэмжээнд нийтдээ 853.9 мянган хүн хэвтэж эмчлүүлсний 450.2 мянга (52.7%) нь нийслэлийн эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлжээ. Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүмүүсийн 27.8 хувь нь дотрын, 7.7 хувь нь мэс заслын, 14.5 хувь нь төрөх, 3.6 хувь нь эмэгтэйчүүдийн, 14.0 хувь нь хүүхдийн тасгаар эмчлүүлсэн байна.

Хүснэгт 70. Эрүүл мэндийн салбарын зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Их эмчийн тоо	5 359	5 510	5 793	5 834	5 986
1 их эмчид ногдох хүний тоо	227	229	224	228	231
Эмнэлгийн орны тоо	9 456	9 685	10 614	11 485	11 835
1 оронд ногдох хүний тоо	129	129	122	116	115
Хэвтэж эмчлүүлсэн өвчтөний тоо	355 218	370 873	394 989	417 631	450 184
Нялхсын эндэгдэл	486	546	625	613	611
Эхийн эндэгдэл	16	21	15	12	17
Үр хөндөлт	13 895	10 385	11 900	13 164	13 805

Зураг 34. Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд



Нийслэлийн хэмжээнд 2016 онд нэг хүртэл насны хүүхдийн эндэгдэл 611, эхийн эндэгдэл 17 гарчээ. Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас нэг хүртэл насандаа эндсэн хүүхдийн тоо 15.0 болж өмнөх оноос 0.7 промилээр, 2012 оноос 0.8 промилээр өсчээ.

2016 онд эхийн эндэгдлийн 44.7 хувь, нэг хүртэл насандаа эндсэн хүүхдийн 46.5 хувь, халдварт өвчнөөр өвчилсөн тохиолдлын 57.7 хувь нь нийслэлийн хэмжээнд гарсан байна. Халдварт өвчнөөр өвчилсөн 40178 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 0.7 пунктээр буурсан буюу 283 тохиолдлоор, 2012 оноос 15050 (59.9%) тохиолдлоор тус тус нэмэгдсэн байна. Халдварт өвчний гаралт өмнөх онуудтай харьцуулахад эрс нэмэгдсэн бөгөөд 15962 тохиолдол буюу 39.7 хувийг улаан бүрхэн өвчний тохиолдол дангаараа эзэлсэн байна.

10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо өмнөх оноос 9.5 промилээр буурч, 2012 оноос 88.2 промилээр өсчээ.

Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 39.7 хувийг улаан бүрхэн, 11.2 хувийг гар хөл амны өвчин, 9.2 хувийг салхинцэцэг, 7.7 хувийг тэмбүү, 6.2 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 6.1 хувийг цусан суулга, 5.2 хувийг трихомониаз, 5.0 хувийг заг хүйтэн өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

Хүснэгт 71. Бүртгэгдсэн халдварт өвчин

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, бүгд	25 128	18 739	18 653	40 461	40 178
Үүнээс:					
Вируст гепатит	2 718	1 207	603	523	350
Менингит	14	17	5	6	5
Цусан суулга	1 726	1 573	1 921	2 336	2 448
Салхин цэцэг	1 578	2 552	2 305	3 329	3 696
Гахайн хавдар	6 968	1 487	188	159	249
Сальмонеллөз	78	49	72	105	164
Улаан эсэргэнэ	88	259	270	674	1 268
Хоолны хордлого	633	121	235	376	386
Ёлом	145	109	104	104	120
Улаанууд	204	9	1	26	16
Бруцеллөз	34	14	17	17	19
Гар хөл амны өвчин	377	1 262	1 614	1 205	4 520
Улаан бурхан	-	-	-	19 427	15 962
Тэмбүү	2 764	3 269	3 618	4 154	3 086
Заг хүйтэн	2 219	1 767	1 650	2 122	2 023
Трихомониаз	2 030	1 850	1 723	1 950	2 080
Шинээр илэрсэн сүрьеэ	2 261	2 401	2 544	2 537	2 469
ХДХВ/ДОХ	27	23	31	18	26
Улсын хэмжээнд бүртгэгдсэн халдварт өвчин	43 305	37 318	33 516	59 400	69 663
Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь	58.0	50.2	55.7	68.1	57.7

Зураг 35. Халдварт өвчнөөр өвчлөгсөд






СОЁЛ УРЛАГ, ЧӨЛӨӨТ ЦАГ, БИЕИЙН ТАМИР


Сонины тоо буурах хандлага 2012 оноос хойш тогтмол ажиглагдах болсон. 2016 онд нийслэлд 66 сонин дугаараа тогтмол гаргаж байсан нь өмнөх оноос зургаагаар цөөрсөн байна⁷. Энэ нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулсан нийт сонины 74.2 хувийг эзэлж байгаа юм. Өмнөх онтой харьцуулахад өдөр тутмын сонины тоо хэвээр байгаа боловч бусад бүх ангиллын сонины тоонд өөрчлөлт, бууралт гарчээ. Тухайлбал, 3-4 хоног тутмын “Таван цагираг” сонин 2016 онд үйл ажиллагаагаа зогсоож, тус ангилалд “Ардын эрх” сонин шинээр багтах болов.

Гаралтын давтамжийн хувьд дугаар гаргасан гурван сонин тутмын нэг нь 10-14 хоногийн, таван сонин тутмын нэг нь 7 хоног болон сар тутмынх байгаа бол 16.7 хувийг өдөр тутмын, 6.1 хувийг 3-4 хоног тутмын сонин түс түс эзэлж байна.

Зураг 36. Сонины тоо, гаралтын давтамжаар



Зураг 37. Сонины тоо, борлуулалтын хэмжээ



Сонины борлуулалтын хэмжээ сүүлийн таван жил дараалан буурч, 2016 онд 13.9 сая ширхэг болжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулахад сонины нийт борлуулалт 18.6 хувиар буюу бараг 3.2 сая тоо ширхэгээр буурсан үзүүлэлт юм. Сонины борлуулалтын зах зээлийн 74.8 хувийг өдөр тутмын сонин эзэлсэн хэвээр байна.

Хүснэгт 72. Сонины борлуулалт, мянган ширхэг

Гаралтын давтамж	2012	2013	2014	2015	2016
өдөр тутмын	18 636.0	16 395.2	13 384.0	13 055.2	10 438.4
3-4 хоног тутмын	1 699.2	1 584.0	1 420.8	1 401.6	1 084.8
7 хоног тутмын	2 283.6	2 162.4	1 833.6	1 248.0	1 234.8
10-14 хоног тутмын	1 796.0	1 928.2	1 303.6	1 122.8	857.2
сар тутмын	270.9	245.4	410.4	276.0	327.0
бусад	112.0	108.0	29.8	29.8	6.0
Нийт	24 797.7	22 423.2	18 382.2	17 133.4	13 948.2


⁷ Хэвлэлийн Хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр” судалгааны тайлан, 2017 он

МОНЦАМЭ агентлагаас дөрвөн хэлээр (англи, орос, хятад, япон) эрхлэн гаргадаг “The Mongol Messenger”, “Новости Монголии”, “Монголын мэдээ”, “Монгол Цушин” зэрэг сонинуудаас гадна “The UB Post” сонин англи хэл дээр гарсан байна.

2016 онд нийслэл хотод байршин үйл ажиллагаа явуулж байсан 18 сэтгүүл хаагдаж, 2 сэтгүүл цахим хэлбэрт шилжиж, 14 сэтгүүл шинээр гарах болсноор сэтгүүлийн тоо 80 болж өмнөх оноос зургаагаар буурав.

Нийт сэтгүүлийн дүнд улирал тутмын сэтгүүлийн тоо давамгайлж 42.5 хувийг эзлэх болсон нь өмнөх оноос 5.3 пунктээр өссөн үзүүлэлт юм. Гэхдээ 10-14 хоног тутмын болон 2 сар тутмын сэтгүүлээс бусад ангиллын сэтгүүлийн тоо 2016 онд буурсан байна.

Зураг 38. Сэтгүүлийн тоо, гаралтын давтамжаар



Зураг 39. Сэтгүүлийн тоо, борлуулалтын хэмжээ



2013 оноос эхлэн сэтгүүлийн борлуулалт тогтмол буурч байна. Энэ хандлага 2016 онд ч хэвээр үргэлжилж өмнөх оноос 40.0 хувиар буурчээ. Харин сар тутмын болон улирал тутмын, түүнчлэн бусад ангиллын сэтгүүлийн борлуулалт нэмэгдсэн байна. Дөрвөн сэтгүүл тутмын гурав нь нийт орон даяар түгээгдэж байна. Үүнд долоо хоног тутмын сэтгүүлийн тоо огцом буурсан нь илүүтэй нөлөөлсөн байна.

Хүснэгт 73. Сэтгүүлийн борлуулалт, мянган ширхэг

Гаралтын давтамж	2012	2013	2014	2015	2016
7 хоног тутмын	3 864.0	3 470.4	3 244.8	2 577.6	1 340.4
10-14 хоног тутмын	460.8	472.8	488.4	184.2	199.2
сар тутмын	931.0	900.0	741.3	831.0	514.6
2 сар тутмын	66.6	28.2	38.1	24.6	25.5
улирал тутмын	58.3	67.6	79.5	81.0	48.3
бусад	7.7	2.1	3.4	12.2	5.4
Нийт	5 388.4	4 941.1	4 595.5	3 710.6	2 223.4

2010 оноос эхлэн сэтгүүлийн нийт борлуулалтад долоо хоног тутмын сэтгүүл 70-80 орчим хувийг эзэлж байв. Энэ байдал сүүлийн хоёр жилд өөрчлөгдөж, 2016 онд 64.3 хувь боллоо буурсан нь өмнөх оноос 5.2 пунктээр, 2010 оноос 15.2 пунктээр тус тус доогуур байгаа юм.

2016 онд нийслэл хотод 3.1 сая гаруй ширхэг номын фондтой, нийт 1451 суудал бүхий уншлагын танхимтай 12 нийтийн номын сан ажилласан байна. Эдгээрийн 2 нь төрийн өмчийн, 10 нь орон нутгийн өмчийнх юм. Номын фондын тоогоор улсын дүнд Улаанбаатар хотын эзлэх хувь 49.8 байгаа бол нийт уншигчдын 18.6 хувь, фондоод шинээр нэмэгдсэн номын 28.1 хувь нь ногдож байна.

2016 онд нийтдээ 317.2 мянган хүнд 679.2 мянган ширхэг ном олгож үйлчилжээ. Уншигчдад олгосон нийт номын 87.3 хувийг нь уншлагын танхимд, 11.3 хувийг гэрээр, 1.4 хувийг зөөврөөр олгосон байна. Номын сангийн байнгын уншигчдын тоо 25.7 мянга болж өмнөх 2015 оноос 18.3 мянган хүнээр (41.6%) буурсан байна.

Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй 23 музейд дэлгэн тавьсан нийт үзмэрийн тоо 151.0 мянга болж, 219.7 мянган үзэгчдийн хүртээл болсон байна. Эдгээр музейн 16 нь төрийн өмчийнх байгаа бол орон нутгийн өмчийн 3, хувийн болон өмчийн бусад хэлбэрийн 4 музей байна. Музейн тоогоор улсын дүнд Улаанбаатар хотын эзлэх хувийн жин 6.7 байгаа бөгөөд музейн нийт үзмэрийн 53.7 хувь, үзэгчдийн 41.1 хувь, тухайн жилд шинээр нэмсэн үзмэрийн 63.5 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 74. Музейн үзмэр, үзэгчдийн тоо

Музейн нэр	Үзмэрийн тоо				Үзэгчид, мянган хүн			
	2013	2014	2015	2016	2013	2014	2015	2016
Бүгд	139 412	146 288	140 396	151 051	595.3	283.5	256.1	219.7
Үүнээс:								
Байгалийн түүхийн музей	7 803	7 804	10 357	11 347	22.0	-	-	-
Үндэсний түүхийн музей	50 831	55 572	56 597	58 554	87.4	81.1	62.7	67.7
Дүрслэх урлагийн музей	16 562	16 561	16 585	16 585	25.1	13.5	19.0	7.6
Богд хааны ордон музей	8 626	8 631	8 636	8 636	45.2	33.8	31.9	35.0
Чойжин ламын сүм музей	6 218	6 370	6 376	6 376	20.5	15.1	16.5	13.4
Монголын театрын музей	9 494	9 494	9 494	9 494	3.7	3.4	2.9	2.1
Уран зургийн галерей	3 588	3 772	3 772	4 135	4.7	2.7	10.0	4.6
Монгол цэргийн музей	8 262	9 507	9 752	9 300	13.1	8.9	6.9	8.7
Улсын хилийн музей	3 455	3 455	3 455	3 455	2.6	2.6	2.6	-
Монгол төрийн түүхийн музей	1 079	1 206	1 218	1 081	158.0	86.3	68.0	25.5
Үлэг гүрвэлийн музей	1	1	22	31	175.2	19.0	20.6	40.0
Олон улсын оюун ухааны музей	9 817	10 028	10 256	9 155	12.8	10.6	9.1	8.2
Улаанбаатар хотын музей	13 676	13 887	3 876	3 358	25.0	6.6	5.9	2.5

Үзмэрийн тоогоор Үндэсний түүхийн музей тэргүүлсэн хэвээр байна. 2016 онд тус музейд 758 үзмэр шинээр нэмэгдэж, нийтдээ 58.5 мянган үзмэртэй болжээ. Байгалийн түүхийн музей сүүлийн 3 жилд нийтэд үйлчлэх боломжгүй байгаа хэдий ч 990 үзмэрийг шинээр бий болгосон нь 2016 онд нэмэгдсэн нийт үзмэрийн 42.7 хувийг эзэлж байна.

2016 онд Үндэсний түүхийн музейг 67.7 мянган хүн (30.8%) үзэж сонирхсон нь улсын хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Музейн үзэгчдийн 55.2 мянга нь хүүхдүүд байв. Энэ нь музейд зочилсон дөрвөн хүн тутмын нэг нь хүүхдүүд байжээ гэсэн үг юм.

2016 онд манай оронд зочилсон гадаадын 95.5 мянган жуулчид нийслэлд байрлах музейнүүдийг үзэж сонирхсон нь өмнөх оноос 9.4 мянган жуулчдаар илүү буюу 10.9 хувиар өсчээ. Өөрөөр хэлбэл, музейн үзэгчдийн 43.5 хувийг гадаадын иргэд эзэлж байв.

Музейд зочилсон гадаадын иргэд, жуулчдын 40.5 мянга (42.5%) нь Үндэсний түүхийн музейг, 26.8 мянга (28.1%) гаруй нь Богд хааны ордон музейг, 9.5 мянга (9.9%) нь Чойжин ламын сүм музейг, 8.4 мянга (8.8%) нь Үлэг гүрвэлийн музейг үзжээ.

Хүснэгт 75. Мэргэжлийн урлагийн байгууллагын суудал, тоглолтын тоо, үзэгчид

Мэргэжлийн урлагийн байгууллагын нэр	Суудлын тоо	Тоглолтын тоо				Үзэгчид, мянган хүн			
		2013	2014	2015	2016	2013	2014	2015	2016
Бүгд	7 025	1 716	1 715	1 479	2 530	908.3	586.6	3511.0 ⁸	827.2
Үүнээс:									
Улсын дуурь бүжгийн эрдмийн театр	500	93	96	92	96	32.6	33.3	37.1	50.0
Улсын драмын эрдмийн театр	594	149	201	189	114	47.7	50.2	62.0	48.0
Үндэсний урлагийн их театр	565	190	134	139	304	31.3	37.6	38.2	24.5
Улсын филормони	260	149	76	46	133	80.4	57.6	17.4	58.8
Улсын хүүхэддэйн театр	166	113	82	80	92	44.9	22.8	25.6	11.0
Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулга	370	330	260	236	254	412.8	200.0	66.8	68.8
Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулга	340	183	240	154	197	45.1	25.1	21.0	23.0
АСА цирк	2 200	93	127	42	25	125.0	127.0	104.4	32.0
“Сарны чулуу” чуулга	-	-	-	-	9	-	-	-	0.1
“Түмэн-Эх” чуулга	180	340	329	300	304	15.8	15.8	23.0	24.5
“Улаанбаатар” чуулга	830	64	142	170	202	67.7	1.9	3 109.1	12.7
Төмөр замчдын дуу, бүжгийн чуулга	400	12	28	31	15	5.0	6.0	6.5	12.0

2016 онд мэргэжлийн урлагийн байгууллагуудаас нийт 2530 удаагийн тоглолт хийж, давхардсан тоогоор 827.2 мянган үзэгчдэд үйлчилжээ. Мэргэжлийн урлагийн байгууллагуудын нийт тоглолтын 39.7 хувийг хүүхдэд зориулсан тоглолт эзэлж, 140.4 мянган хүүхэд багачуудад урлагийн тоглолт, үзвэрээр үйлчилжээ. Хүүхдэд зориулсан нийт тоглолтын 45.8 хувийг Улсын Хүүхэддэйн Театр, 10.0 хувийг Улсын Драмын Эрдмийн Театр зохион байгуулсан байна. Мэргэжлийн урлагийн байгууллагуудын урын санд нийтдээ 4722 уран бүтээл бүртгэлтэй бөгөөд улсын дүнд эзлэх хувийн жин нь 64.0 байна.

2016 онд мэргэжлийн урлагийн байгууллагууд шинээр 127 уран бүтээл туурвисан нь улсын хэмжээнд туурвисан нийт шинэ уран бүтээлийн 48.8 хувийг эзэлж байгаа ажээ.

⁸ Олон улсын бүжгийн фестиваль, Морин хуурын фестиваль, Авъяаслаг Монголчууд зэрэг томоохон арга хэмжээнүүд 2015 онд зохион байгуулагдснаар мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчид өмнөх оноос нэмэгдсэн.

Зураг 40. Кино театр, үзэгчдийн тоо

2016 онд нийслэл хотод 5574 суудалтай 6 кино театр үйл ажиллагаа явуулж, нийтдээ 51290 удаагийн кино гаргалтаар 1040.1 мянган үзэгчдэд үйлчилж, 15.3 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Нийт орлогынх нь 43.7 хувийг кино үзвэрийн орлого бүрдүүлжээ.

Нийт үзэгчдийн 52.8 хувь нь Тэнгис кино театраар, 20.9 хувь нь Соёмбо, 12.5 хувь нь Хүннү молл кино театраар үйлчлүүлжээ.




2016 онд 14.5 мянга гаруй суудалтай 16 соёлын төв (ордон) нийслэлийн иргэд, оршин суугчдад жилийн турш үйлчилж, 3155 арга хэмжээ зохион байгуулсан байна. Эдгээр арга хэмжээний 29.5 хувийг соёл урлагийн, 45.7 хувийг нь дугуйлан эзэлж байгаа юм.

Зураг 41. Сүм хийдийн тоо

2016 онд нийслэлд буддын шашны 46 хийд, христийн 130, исламын 1 сүм, бусад төрлийн 8 шашны байгууллага тогтвортой үйл ажиллагаа явуулжээ.

Эдгээр сүм хийд нийтдээ 1774 ажиллагчидтай байгаагийн 61.0 хувь нь буддын, 37.1 хувь нь христын сүмүүдэд ажилласан байна.

Нийт ажиллагчдын 53.6 хувийг хурлын лам, санваартан болон христын номлогч нар эзэлж байгаа бөгөөд эдгээрийн 66.7 хувь нь буддын дацан хийдэд, 31.8 хувь нь христын сүмүүдэд харьяалагдаж байна.



Шашны сургууль, дацанд 41 хүүхэд, залуус шавилан суралцсны сацуу шашны ном сургаалийг 2490 хүүхэд гэрээр заалгаж судалсан байна.

2016 онд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулсан албан ёсны зөвшөөрөл бүхий нийт сүм хийдийн талаас илүү буюу 52.9 хувь, үүний дотор буддын дацан хийдийн 33.8 хувь, христийн сүмийн 71.0 хувь, исламын шашны 4.5 хувь, бусад төрлийн 4 шашны байгууллагын дийлэнх нь нийслэл хотод төвлөрөн ажиллажээ.

2016 онд нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа тогтвортой явуулсан, албан ёсны зөвшөөрөл, бүртгэлтэй дээрх шашны байгууллагуудын 70.3 хувийг христийн сүмүүд эзэлж байна. Эдгээр сүмийн 48.6 хувь нь протестант, 20.1 хувь нь эвангел урсгалыг, үлдэх хэсэг нь методист, баптист, адвентист, пентикост, морман гэх мэт христийн бусад урсгал чиглэлүүдийг төлөөлж байна.

Хүснэгт 76. Нийслэлд тогтмол үйл ажиллагаа явуулж буй албан ёсны зөвшөөрөл бүхий сүм хийд

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Сүм хийдийн тоо	167	158	169	182	185
Үүнээс: шашны төрлөөр					
Будда	43	43	44	41	46
Христ	108	103	111	122	124
Католик	5	6	6	6	6
Ислам	2	1	2	1	1
Бусад (бөө мөргөл, бахай, хиндү, шинто)	9	5	6	12	8
Шашны сургуульд суралцагчдын тоо	238	264	61	57	41
Үүнээс: шашны төрлөөр					
Будда	204	264	58	50	41
Христ	34	-	3	7	-
Гэрээр ном заалгадаг хүүхэд	3 872	3 413	2 974	2 414	2 490
Үүнээс: шашны төрлөөр					
Будда	50	-	6	7	-
Христ	728	711	763	427	485
Бусад	3 094	2 702	2 205	1 980	2 005*

Нийслэл хотод жилийн турш 259 спортын заал, танхим ажиллаж, нийслэл хотын аварга шалгаруулах тэмцээнийг 17 төрлөөр зохион байгуулж, 3.2 мянган тамирчид оролцсон байна.

Хүснэгт 77. Биеийн тамир, спортын зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Спортын заал, танхим, бүгд	249	256	257	265	259
Үүнээс: Спортын заал	156	194	166	218	212
Нийслэл хотын аварга шалгаруулах тэмцээн	52	50	24	23	17
Тэмцээнд оролцсон тамирчид, мянган хүн	25.8	20.5	46.3	4.1	3.2
Бүх нийтийг хамарсан өдөрлөг, аялал, чийрэгжилтийн арга хэмжээ	32	484	290	463	442
Үүнд хамрагдсан хүн, мянган хүн	181.3	650.7	588.1	607.1	673.5
Баяр ёслол, тэмдэглэлт ой, нэрэмжит тэмцээн	52	89	45	44	41

2016 онд бүх нийтийг хамарсан аялал, өдөрлөг, чийрэгжилтийн арга хэмжээг 442 удаа зохион байгуулж, түүнд давхардсан тоогоор 673.5 мянган хүн оролцжээ. Тухайлбал, нийслэлийн иргэдийн спортын наадмыг 7 төрөл /спорт явган аялал, ширээний шагай, хийн дасгал, аэробек, олс таталт, гар бөмбөг, сагсан бөмбөг/-өөр, хэсэг, хороо, бүс, дүүрэг, нийслэл гэсэн 5 үе шаттайгаар зохион байгуулж, нийт 87.2 мянган иргэд оролцсон байна. Мөн түүнчлэн “Улаанбаатар марафон-2016” олон улсын гүйлтийг 6 зайн төрөлд зохион байгуулж, 25.0 мянга гаруй хүн оролцсон байна.

* Дэлхийн хамгийн залуу шашин болох Бахай шүтлэгийн сургаал номлолд суралцагчид



БАЙГАЛЬ ОРЧИН

Байгаль орчны зөрчил:

2016 онд нийслэлийн байгаль орчин, ногоон бүсэд гарсан нийт зөрчлийн тоо 182 болж, өмнөх оноос 2.9 дахин буурчээ.

Илрүүлсэн нийт зөрчлийн 24.2 хувийг газрын зөрчил, 15.9 хувийг геодези зураг зүй, кадастрын зөрчил, 11.5 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 10.4 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 8.2 хувийг ургамал, хөрсний бохирдлын зөрчил, 5.5 хувийг ойн зөрчил, 4.4 хувийг ангийн зөрчил, 19.9 хувийг бусад зөрчлүүд эзэлж байна.

Илрүүлсэн зөрчилд нийт 79.2 сая төгрөгийн торгууль ногдуулж, ойн зөрчлөөс 2.4 сая төгрөг, ангийн зөрчлөөс 0.3 сая төгрөгийн хураагдсан эд зүйлсийг улсын орлого болгож, нийт 81.9 сая төгрөгийг нийслэлийн төсөвт оруулжээ.

Зураг 42. Байгаль орчны зөрчил, хувиар



2016 онд нийслэлийн төсөвт оруулсан орлогыг өмнөх онтой харьцуулахад 30.1 сая (26.9%) төгрөгөөр буурчээ.

Хүснэгт 78. Илрүүлсэн зөрчил, төрлөөр

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Үзлэг шалгалтын тоо	972	602	464	139	166
Ногдуулсан торгууль, сая төгрөг	58.9	78.2	94.8	96.0	79.2
Илрүүлсэн нийт зөрчлийн тоо	618	271	255	525	182
Үүнээс: зөрчлийн төрлөөр					
Газар	138	39	45	98	44
Газрын хэвлий түүний баялаг	10	6	70	34	19
Ой	164	108	24	37	10
Ургамал хөрсний бохирдол	150	63	16	11	15
Ан амьтан	4	6	5	21	8
Ус	52	8	2	1	-
Агаар дахь химийн хорт бодис	74	15	36	151	21
Геодези зураг зүй, кадастр	15	15	20	139	29
Бусад	11	11	37	33	36

Агаарын төлөв байдал:

Нийслэлийн хэмжээнд 2016 оны 124 өдөрт 301.7 мм хур тунадас орсон байна. Жилийн хамгийн халуун өдөр 8 дугаар сард +36.7°C хүрч халсан бол хамгийн хүйтэн өдөр 1 дүгээр сард тохиож, -32.0 °C хүрч хүйтэрсэн байна.

Хүснэгт 79. Цаг уурын үндсэн үзүүлэлт, 2012-2016 оны сар, улирлаар

Он	Сар	Өвөл			Хавар			Зун			Намар		
		XI	XII	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X
2012	Агаарын дундаж хэм (°C)	-12.3	-22.4	-25.5	-20.2	-8.0	2.7	11.5	15.2	18.0	15.9	11.6	0.2
2013		-8.0	-15.9	-20.8	-19.4	-6.3	0.2	11.6	15.8	17.9	15.5	9.3	1.0
2014		-8.2	-16.6	-18.5	-18.4	-4.7	6.9	8.2	15.4	17.9	16.3	9.9	3.7
2015		-10.9	-15.7	-15.6	-12.9	-6.2	4.1	9.0	16.7	20.3	18.8	10.7	2.9
2016		-13.7	-16.5	-23.9	-16.2	-4.7	3.5	9.1	15.6	20.7	17.6	10.6	-1.7
2012	Хур тунадас (мм)	7.8	6.2	0.6	1.4	0.9	6.5	9.6	70.1	106.8	56.7	17.5	3.9
2013		4.1	1.4	1.4	1.8	11.1	13.6	26.8	36.8	37.1	75.4	15.8	34.5
2014		0.9	3.2	0.9	1.9	2.0	6.8	40.0	62.9	100.0	55.1	19.1	2.0
2015		5.1	4.5	1.3	0.7	20.5	23.0	12.3	9.2	125.8	30.8	22.6	14.2
2016		18.4	1.1	1.2	1.4	10.9	3.2	33.2	68.4	80.5	45.2	24.5	13.7
2012	Салхины хурд (м/сек)	13	13	10	13	17	20	19	20	17	20	8	14
2013		14	15	12	14	18	15	22	18	15	11	16	19
2014		17	12	12	12	18	24	19	23	19	20	21	17
2015		11	12	12	14	14	20	19	19	18	22	18	19
2016		12	11	11	14	20	18	21	15	20	14	13	23

Хүснэгт 80. Цаг уурын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2012	2013	2014	2015	2016
Агаарын дундаж хэм	градус	-1.1	0.1	1.0	1.7	0.0
Олон жилийн дундажтай харьцуулсан хэм	градус	-0.9	0.4	1.3	2.0	-0.6
Хамгийн өндөр хэм	градус	32.7	30.0	32.6	34.0	36.7
Хамгийн нам хэм	градус	-37.0	-33.2	-31.6	-30.4	-32.0
Хур тунадасны нийлбэр	миллиметр	287.4	258.3	294.2	268.5	301.7
Хур тунадастай өдрийн тоо	тоо	182	131	119	123	124
Шороон болон цасан шуургатай өдрийн тоо	тоо	18	8	16	19	11
Салхины дундаж хурд	метр секунд	15	16	18	17	16



НИЙСЛЭЛ ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

2016 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 65.9 хувь нь нийслэл хотод бүртгэгдэж, өмнөх оноос 1.3 пунктээр, 2012 оноос 7.5 пунктээр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн улмаас 325 хүн нас барж, 6847 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 117.2 тэрбум төгрөгийн хохирол учирчээ. Нийт хохирлоос 24.5 тэрбум төгрөгийг (20.9%) нөхөн төлүүлсэн байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 71.9 хувь, гэмтэж бэртсэн хүний 60.8 хувь, нас барсан хүний 36.9 хувь нь нийслэл хотод ногдож байна.

Хүснэгт 81. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, дүүргээр


Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	12 910	15 419	17 205	17 939	17 909
Багануур	278	278	236	311	293
Багахангай	20	31	25	21	23
Баянгол	2 372	2 521	2 813	2 951	3 137
Баянзүрх	2 739	3 742	4 267	4 272	4 218
Налайх	290	302	339	423	489
Сонгинохайрхан	2 127	2 778	3 042	3 232	2 811
Сүхбаатар	2 102	2 416	2 594	3 085	2 962
Хан-Уул	1 175	1 236	1 496	1 390	1 639
Чингэлтэй	1 807	2 115	2 393	2 254	2 337
Улсын дүн	22 089	25 362	27 318	27 757	27 167
Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь	58.4	60.8	63.0	64.6	65.9

Зураг 43. Бүртгэгдсэн нийт болон 18-аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэргийн тоо



2016 онд нийслэлийн хэмжээнд 17909 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 30 (0.2%) хэргээр буурч, 2012 оноос 4999 (38.7%) хэргээр өсчээ. 18-аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэргийн тоо 2012 онд 152, 2013 онд 182, 2014 онд 189, 2015 онд 201, 2016 онд 194 болжээ.

Зураг 44. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь, илрээгүй гэмт хэргийн тоо



Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн илрүүлэлтийг тооцоход 2004 онд 82.4 хувь, 2005 онд 86.0 хувь, 2006 онд 87.0 хувьтай байв. 2007 оноос эхлэн сэжигтэн тодорхойгүй хэргээс илрүүлэлтийг тооцож, гэм буруутай этгээдийг яллагдагчаар татагдсаны дараа тухайн хэргийг илрүүлсэнд тооцдог болсноор гэмт хэргийн илрүүлэлтийн хувьд зохих нөлөө үзүүлсэн. Тухайлбал, 2008 онд 32.1 хувь, 2009 онд 50.1 хувь, 2010 онд 53.5 хувь, 2011 онд 58.8 хувь, 2012 онд 51.7 хувь, 2013 онд 56.5 хувь, 2014 онд 55.4 хувь, 2015 онд 58.9 хувьд хүрч, 2016 онд 61.5 хувь болж өссөн байна. Хэдий тийм ч нийслэлд гарсан гэмт хэргийн илрүүлэлтийн хувь 2016 онд улсын дунджаас 2.5 пунктээр доогуур байв.

Хүснэгт 82. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь, дүүргээр

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	51.7	56.5	55.4	58.9	61.5
Багануур	67.2	63.6	71.4	71.7	73.0
Багахангай	0.0	-	71.4	100.0	60.0
Баянгол	64.7	62.5	63.8	67.1	66.3
Баянзүрх	39.6	51.8	48.2	53.8	54.7
Налайх	65.8	60.5	76.4	73.5	72.0
Сонгинохайрхан	58.9	60.3	58.5	59.9	67.6
Сүхбаатар	46.0	53.6	55.2	57.0	60.0
Хан-Уул	58.4	56.0	59.5	63.0	65.4
Чингэлтэй	55.1	57.8	54.8	58.6	59.5

2016 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн 81.7 хувь, аж ахуйн эсрэг гэмт хэргийн 78.4 хувь, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 71.5 хувь, захиргааны журмын эсрэг гэмт хэргийн 67.9 хувь, хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 63.9 хувь, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 59.7 хувь, тээврийн хэрэгслийн аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 51.1 хувь, албан тушаалын эсрэг гэмт хэргийн 49.6 хувь, хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргийн 49.5 хувь нь нийслэл хотод бүртгэгджээ.

2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 34.1 хувийг хулгайн, 27.7 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 10.7 хувийг залилан, 6.7 хувийг танхайн, 5.1 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг, 2.3 хувийг дээрмийн хэрэг түс түс эзэлж байна.

Хүснэгт 83. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр

Төрөл	2012	2013	2014	2015	2016
Гэмт хэрэг, бүгд	12 910	15 419	17 205	17 939	17 909
Хүний амь	120	104	114	113	91
Хүчин	155	182	153	133	132
Дээрэм	442	530	591	446	404
Хулгай	3 385	4 638	5 211	5 899	6 098
Булаалт	145	187	206	183	158
Залилан	920	1 014	1 562	1 788	1 908
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	3 662	4 353	4 795	4 784	4 958
Хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих	1 105	1 211	1 062	1 068	915
Бусдыг амиа хорлоход хүргэх	184	178	174	94	107
Ашиглах	146	193	180	201	193
Танхайрах	1 245	1 448	1 337	1 253	1 204
Бусад	1 401	1 381	1 820	1 977	1 741

2016 онд гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 14482 болж, өмнөх оноос 29 хүнээр (0.2%) бүүрсан бол 2012 оноос 3953 хүнээр (37.5%) өссөн байна. Сэжигтэн, яллагдагчийн 670 (4.6%) нь хүүхэд, 2576 (17.8%) нь эмэгтэйчүүд байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 1847 (12.8%) нь гэмт хэргийг бүлэглэн үйлдэж, 2457 (17.0%) нь согтуугаар үйлдсэн байхад 989 (6.8%) нь урьд нь ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ.

Хүснэгт 84. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо, дүүргээр

Дүүрэг	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	10 529	12 361	13 378	14 511	14 482
Багануур	308	302	262	338	318
Багахангай	23	33	24	24	26
Баянгол	1 937	2 077	2 283	2 488	2 619
Баянзүрх	1 830	2 673	2 911	3 216	3 146
Налайх	292	304	343	422	472
Сонгинохайрхан	1 819	2 253	2 444	2 661	2 320
Сүхбаатар	1 697	1 848	1 995	2 417	2 244
Хан-Уул	1 033	1 115	1 284	1 253	1 462
Чингэлтэй	1 590	1 756	1 832	1 692	1 875

Гэмт хэрэгт бүрэн дунд, дээд болон суурь боловсролтой хүмүүс хамгийн ихээр холбогдсон байна. 2016 онд гэмт хэрэг үйлдсэн иргэдийн 7228 (49.9%) нь бүрэн дунд боловсролтой, 3264 (22.6%) нь дээд боловсролтой, 2364 (16.3%) нь суурь боловсролтой, 691 (4.8%) нь бага боловсролтой, 524 (3.6%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой бол 411 (2.8%) нь ямар нэгэн боловсрол эзэмшээгүй хүмүүс байжээ.

Хүснэгт 85. Гэмт хэрэг үйлдэгсэд, боловсролын түвшин, дүүргээр, 2016 он

Дүүрэг	Бүгд	Боловсролын түвшнээр					
		Дээд	Мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловс- ролгүй
Нийслэлийн дүн	14 482	3 264	524	7 228	2 364	691	411
Багануур	318	51	17	135	87	16	12
Багахангай	26	2	1	16	5	1	1
Баянгол	2 619	603	143	1 371	304	99	99
Баянзүрх	3 146	655	113	1 615	517	160	86
Налайх	472	62	5	251	90	49	15
Сонгинохайрхан	2 320	333	86	1 149	505	145	102
Сүхбаатар	2 244	680	57	1 041	334	90	42
Хан-Уул	1 462	463	49	703	183	50	14
Чингэлтэй	1 875	415	53	947	339	81	40


Гэмт хэрэг үйлдсэн иргэдийг нийгмийн байдлаар нь авч үзвэл 8227 (56.8%) нь ажилгүй, 4888 (33.8%) нь ажиллагсад, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, 819 (5.7%) нь оюутан сурагч, 350 (2.4%) нь төрийн албан хаагч, 162 (1.1%) нь хугацаат цэргийн албан хаагч, сургууль завсардсан хүүхэд, тэнэмэл иргэд, 36 (0.2%) нь хоригдол хүмүүс байв.

Хүснэгт 86. Гэмт хэрэг үйлдэгсэд, нийгмийн байдал, дүүргээр, 2016 он

Дүүрэг	Бүгд	Үүнээс: нийгмийн байдлаар					
		Хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажиллагсад, малчин	Төрийн албан хаагч	Оюутан сурагч	Хугацаат цэргийн албан хаагч, сургууль завсардсан хүүхэд, тэнэмэл иргэн	Хоригдол	Ажилгүй
Нийслэлийн дүн	14 482	4 888	350	819	162	36	8 227
Багануур	318	82	21	14	5	1	195
Багахангай	26	2	2	-	-	1	21
Баянгол	2 619	749	45	139	50	5	1 631
Баянзүрх	3 146	1 042	85	210	34	10	1 765
Налайх	472	88	28	17	1	-	338
Сонгинохайрхан	2 320	839	43	91	9	9	1 329
Сүхбаатар	2 244	886	33	153	29	7	1 136
Хан-Уул	1 462	560	50	97	5	-	750
Чингэлтэй	1 875	640	43	98	29	3	1 062

Гэмт хэргийн 5893 (32.9%) нь гэр, орон сууцанд, 4060 (22.7%) нь гудамж талбайд, 3123 (17.4%) нь олон нийтийн газарт, 1998 (11.2%) нь аж ахуйн нэгж, байгууллагад, 903 (5.0%) нь авто зам дээр, 215 (1.2%) нь нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж байх үед, 188 (1.0%) нь төрийн байгууллагад, 159 (0.9%) нь төрийн бус байгууллагад, 1370 (7.7%) нь бусад газруудад гарчээ.

Зураг 45. 18-аас дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, 2016 он



2016 онд нийслэлийн хэмжээнд 18-аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэргийн тоо 194 байгаа нь бусад аймгуудтай харьцуулахад хамгийн их бөгөөд улсын дунджаас 59 хэргээр олон байна. Энэ үзүүлэлт Баян-Өлгий аймагт хамгийн бага (48) байна.


2016 онд 48669 согтуу иргэдийг эрүүлжүүлсэн нь өмнөх оноос 7393 (13.2%) хүнээр, 2012 оноос 10860 (22.3%) хүнээр тус тус буурчээ. 2012-2016 оны хооронд нийслэлийн хэмжээнд архидах донтой нийт 2166 хүн, үүнээс 2016 онд 379 хүнийг албадан эмчилсэн байна.



НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ

Нийслэлийн төсвийн нийт орлого (үрсгал орлого болон тусламжийн орлого) 2016 онд 872.9 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 14.6 тэрбум төгрөгөөр (1.6%) дутуу бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2015 оноос 3.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 46. Төсвийн орлого, зарлага, тэрбум төгрөг



Төсвийн орлогын гүйцэтгэлийг бүтцээр нь задлан авч үзвэл 553.8 тэрбум төгрөг (63.4%) нь хууль тогтоомжийн дагуу нийслэлийн төсөвт төвлөрөх татварын болон татварын бус орлогын эх үүсвэрээс, 319.1 тэрбум төгрөг (36.6%) нь тусламжийн орлого буюу улсын төсвөөс нийслэлд хуваарилах тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийн орлогоос тус тус бүрдсэн байна.

Хүснэгт 87. Нийслэлийн төсвийн нийт орлого, орлогын биелэлтийн хувь, дүүргээр, сая төгрөг

Дүүрэг	Үүнээс:							
	Нийт орлого	Хувь	Татварын орлого	Хувь	Татварын бус орлого	Хувь	Тусламжийн орлого	Хувь
Нийслэлийн дүн	872 888.8	98.4	506 601.6	100.5	47 220.6	72.4	319 066.6	100.2
Багануур	11 621.3	100.5	722.5	113.1	356.8	93.4	10 542.0	100.0
Багахангай	2 975.4	99.4	76.3	91.2	114.9	94.7	2 784.2	100.0
Баянгол	61 585.1	96.6	13 214.6	86.9	860.7	80.8	47 509.8	100.0
Баянзүрх	78 991.7	98.0	15 923.3	91.8	108.6	35.5	62 959.8	100.0
Налайх	14 306.1	100.3	740.6	89.1	324.2	166.8	13 241.3	100.0
Сонгинохайрхан	67 517.0	99.6	5 363.6	90.4	944.3	148.0	61 209.1	100.0
Сүхбаатар	75 230.1	102.0	25 859.9	102.1	910.1	159.8	48 460.1	101.3
Хан-Уул	52 661.2	99.4	17 455.5	104.1	1 283.7	55.3	33 922.0	100.1
Чингэлтэй	66 703.2	114.4	33 099.9	131.7	944.6	180.8	32 658.7	100.1
Хотын шууд	441 297.7	95.6	394 145.4	99.4	41 372.7	70.0	5 779.6	99.8

Хүснэгт 88. Нийслэлийн төсвийн нийт орлого, сая төгрөг, 2016 он

Төсвийн орлогын нэр, төрөл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Биелэлт	Зөрүү
I. Нийт орлого ба тусламжийн дүн	887 514.8	872 888.8	98.4	-14 626.0
II. Орон нутгийн төсвийн нийт орлого	887 514.8	872 888.8	98.4	-14 626.0
III. Урсгал орлого	569 125.6	553 822.2	97.3	-15 303.4
IV. Татварын орлогын дүн	503 940.2	506 601.6	100.5	2 661.4
Орлогын албан татвар	352 363.6	351 900.5	99.9	-463.1
Хүн амын орлогын албан татвар	352 363.6	351 900.5	99.9	-463.1
Хувь хүний орлогын албан татвар /ХХОАТ/	311 209.5	313 539.5	100.7	2 330.0
ХХОАТ-ын буцаан олголт	-25 415.0	-25 408.5	100.0	6.5
Үйл ажиллагааны орлогын татвар	28 554.4	25 157.0	88.1	-3 397.4
Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогын татвар	8 287.9	4 583.1	55.3	-3 704.8
Хөрөнгө борлуулсны орлогын татвар	6 865.3	6 255.9	91.1	-609.4
Бусад орлого	22 861.5	27 773.5	121.5	4 912.0
Өмчийн татвар	39 295.6	44 466.8	113.2	5 171.2
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	38 962.9	44 126.3	113.3	5 163.4
Бүүны албан татвар	332.7	340.5	102.3	7.8
Бараа ба үйлчилгээний татвар	25 000.0	21 836.8	87.3	-3 163.2
Авто тээврийн ба өөрөө явагч хэрэгслийн	25 000.0	21 836.8	87.3	-3 163.2
Бараа үйлчилгээний бусад татвар	110.7	105.7	95.5	-5.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	110.7	105.7	95.5	-5.0
Бусад татвар, хураамж, төлбөр	87 170.3	88 291.9	101.3	1 121.6
Улсын тэмдэгтийн хураамж	27 521.4	35 877.6	130.4	8 356.2
Газар ашигласны төлбөр	39 800.0	34 393.1	86.4	-5 406.9
Ус ашигласны төлбөр	3 541.0	2 189.4	61.8	-1 351.6
Хэрэглээний мод, түлээ ашигласны төлбөр	34.8	46.9	134.7	12.1
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	12 673.1	12 319.6	97.2	-353.5
Нийслэл хотын татвар	3 600.0	3 465.3	96.3	-134.7
V. Татварын бус орлогын дүн	65 185.4	47 220.6	72.4	-17 964.8
ААНБ-ын хувьцааны ногдол ашиг	1 351.0	735.2	54.4	-615.8
Түрээсийн орлого	1 507.1	1 645.2	109.2	138.1
Төсөвт байгууллагын өөрийн орлого	10 097.6	9 554.3	94.6	-543.3
Хүү, торгуулийн орлого	27 239.6	21 580.8	79.2	-5 658.8
Бусад нэр заагдаагүй орлого	1 211.2	3 498.9	288.9	2 287.7
Авто зам ашигласны төлбөр	11 478.9	10 007.9	87.2	-1 471.0
Өмч хувьчлалын орлого	12 300.0	198.3	1.6	-12 101.7
VI. Тусламжийн орлого	318 389.2	319 066.6	100.2	677.4
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	14 393.6	14 393.6	100.0	-
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	294 799.7	294 799.7	100.0	-
Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын өөрийн орлого	9 195.9	9 873.3	107.4	677.4

Татварын орлогын хэмжээ 2016 онд 506.6 тэрбум төгрөг болж, орлогын төлөвлөгөө төлөвлөснөөс 2.7 тэрбум төгрөгөөр (0.5%) илүү биелсэн бөгөөд орлогын төрлүүдээр авч үзвэл 69.5 хувийг хүн амын орлогын албан татвар, 8.8 хувийг өмчийн татвар, 4.3 хувийг бараа ба үйлчилгээний татвар, 0.1 хувийг бараа үйлчилгээний бусад татвар, 17.3 хувийг бусад татвар, хураамж, төлбөр (улсын тэмдэгтийн хураамж, газар, ус, хэрэглээний мод түлээ ашигласны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж) эзэлж байна.

2016 онд 65.2 тэрбум төгрөгийн татварын бус орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 47.2 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж, орлогын төлөвлөгөө 17.9 тэрбум төгрөгөөр (27.6%) тасарсан дүнтэй байна. Татварын бус орлогын 45.7 хувийг хүү, торгуулийн орлого, 20.2 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 0.4 хувийг өмч хувьчлалын орлого, 21.2 хувийг авто зам ашигласны төлбөр, үлдсэн 12.5 хувийг ААНБ-ын хувьцааны ногдол ашиг болон бусад нэр заагдаагүй орлогоос бүрдүүлжээ.

Хүснэгт 89. Нийслэлийн төсвийн үрсгал орлогын 2016 оны гүйцэтгэл, дүүргээр, сая төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
Нийслэлийн дүн	569 125.5	553 822.2	-15 303.3	97.3
Багахангай	209.6	191.2	-18.4	91.2
Баянгол	16 265.0	14 075.3	-2 189.7	86.5
Баянзүрх	17 647.6	16 031.9	-1 615.7	90.8
Налайх	1 025.1	1 064.8	39.7	103.9
Сонгинохайрхан	6 569.7	6 307.8	-261.9	96.0
Сүхбаатар	25 885.7	26 770.1	884.4	103.4
Хан-Уул	19 088.8	18 739.1	-349.7	98.2
Чингэлтэй	25 654.3	34 044.5	8 390.2	132.7
Хотын шууд	455 758.9	435 518.1	-20 240.8	95.6

Улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас нийслэлд хуваарилж байгаа шилжүүлгийн орлого 100.0 хувь төсөвт төвлөрч, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжиж байгаа төсөвт байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө 677.3 сая төгрөгөөр (7.4%) давж биелсэн дүнтэй байна. Тусламжийн орлогын 92.4 хувийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 4.5 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийн орлогоос, 3.1 хувийг тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын өөрийн орлогоос бүрдүүлжээ.

Хүснэгт 90. Нийслэлийн төсвийн тусламжийн орлогын 2016 оны гүйцэтгэл, сая төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
Нийслэлийн дүн	318 389.3	319 066.6	-15 303.3	97.3
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	14 393.7	14 393.7	0.0	100.0
Тусгай зориулалтын шилжүүлэг	294 799.7	294 799.7	0.0	100.0
Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын өөрийн орлого	9 195.9	9 873.2	677.3	107.4

Нийслэлийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2016 онд 989.7 тэрбум төгрөгөөр төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 961.6 тэрбум төгрөг зарцуулжээ. Төсвийн нийт зарлагын 68.8 хувийг орон нутгийн төсвийн зарлага, 31.2 хувийг тусгай шилжүүлгийн зарлага эзэлж байна.

Зураг 47. Төсвийн зарлагын бүтэц, хувиар



Нийслэлийн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийн 22.5 хувийг цалин хөлс болон нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 23.8 хувийг бараа үйлчилгээний урсгал зардал, 24.4 хувийг татаас болон урсгал шилжүүлгүүд, 29.3 хувийг хөрөнгө оруулалтын зардал тус тус эзэлж байна.

Нийслэлийн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг 2015 онтой харьцуулахад 77.8 тэрбум төгрөгөөр (8.8%) нэмэгджээ.

Хүснэгт 91. Нийслэлийн төсвийн нийт зарлага, биелэлтийн хувь, дүүргээр, сая төгрөг

Дүүрэг	Төсвийн нийт зарлага	хувь	Үүнээс:			
			Орон нутгийн төсвийн зарлага	хувь	Тусгай шилжүүлгийн зарлага	хувь
Нийслэлийн дүн	961 563.6	97.2	661 805.7	96.5	299 757.9	98.6
Багануур	14 747.1	99.8	5 357.3	99.6	9 389.8	99.9
Багахангай	5 336.1	95.7	3 670.2	94.0	1 665.9	99.4
Баянгол	62 048.9	98.1	16 248.3	93.4	45 800.6	100.0
Баянзүрх	76 504.9	95.0	17 652.4	87.7	58 852.5	97.5
Налайх	17 350.1	96.1	5 569.7	93.2	11 780.4	97.5
Сонгинохайрхан	72 656.2	98.9	14 000.1	95.0	58 656.1	99.9
Сүхбаатар	66 326.0	92.1	21 787.1	85.3	44 538.9	95.8
Хан-Уул	47 496.3	94.9	15 051.2	86.1	32 445.1	99.5
Чингэлтэй	59 889.2	99.1	28 872.8	98.3	31 016.4	99.9
Хотын шууд	539 208.8	97.7	533 596.6	97.8	5 612.2	96.9

Төсвийн хөрөнгө оруулалт:

2016 онд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 149.3 тэрбум төгрөг, 2015-2016 онд дамжин хэрэгжүүлэхээр 62.2 тэрбум төгрөг, нийт 211.5 тэрбум төгрөгийн, 781 нэр төрлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 185.9 тэрбум төгрөгийн (87.9%) санхүүжилтыг олгосон байна.

Хүснэгт 92. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын 2016 оны гүйцэтгэл, тэрбум төгрөг

Үзүүлэлт	Гүйцэтгэсэн ажил	2016 онд санхүүжих	Олгосон санхүүжилт	Биелэлтийн хувь
Нийслэлийн дүн	781.0	211.5	185.9	87.9
Нийслэлийн төсөв	449.0	149.3	129.0	86.4
Он дамжин (2015-2016) хэрэгжих төсөв	332.0	62.2	56.9	91.5

2016 онд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас (ОНХНС) нийслэлийн 9 дүүргийн орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэхээр төлөвлөгдөж батлагдсан төсвийн дагуу орлогын шилжүүлэг 100 хувь хийгдсэн байна.

Хүснэгт 93. ОНХНС-гаас дүүргүүдэд олгосон санхүүжилт, сая төгрөг

Үзүүлэлт	2016 онд санхүүжих	ОНХНС-гаас шилжиж ирсэн	Олгосон санхүүжилт	Биелэлтийн хувь
Нийслэлийн дүн	14 393.7	14 393.7	14 393.7	100.0
Багахангай	1 140.5	1 140.5	1 140.5	100.0
Баянгол	1 108.8	1 108.8	1 108.8	100.0
Баянзүрх	1 672.9	1 672.9	1 672.9	100.0
Налайх	2 559.3	2 559.3	2 559.3	100.0
Сонгинохайрхан	1 159.2	1 159.2	1 159.2	100.0
Сүхбаатар	2 505.2	2 505.2	2 505.2	100.0
Хан-Уул	1 353.8	1 353.8	1 353.8	100.0
Чингэлтэй	1 305.9	1 305.9	1 305.9	100.0
Хотын шууд	1 588.0	1 588.0	1 588.0	100.0

Тайлант хугацаанд улсын төсвийн хөрөнгөөр нийслэлийн хэмжээнд 7.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн бол нийслэлийн замын сангаас 32.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилт хийгджээ.

Хүснэгт 94. Улс, нийслэлийн төсвөөр хийгдсэн нийт хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	907.1	653.5	215.1	223.5	208.1
Улсын төсвийн хөрөнгөөр	725.9	413.9	17.3	7.9	7.8
Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	181.2	239.6	197.8	215.6	200.3
Нийслэлийн төсөв	168.3	134.5	87.8	112.1	96.7
Нийслэлийн замын сан	12.9	15.5	24.1	21.2	32.3
Он дамжиж хийгдсэн хөрөнгө оруулалт	-	61.8	53.8	61.4	56.9
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан	-	27.8	32.1	20.9	14.4



НИЙСЛЭЛИЙН ӨМЧ

Нийслэлийн өмч хөрөнгө 2016 онд өмнөх оноос 482.3 тэрбум төгрөгөөр хорогдож, хуримтлагдсан элэгдлийг хасаж тооцсон дүнгээр 1796.1 тэрбум төгрөг болжээ. Нийт хөрөнгийн 22.5 хувийг эргэлтийн хөрөнгө, 77.5 хувийг эргэлтийн бус хөрөнгийн дүн эзэлж байна.

Хүснэгт 95. Нийслэлийн өмч, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	1 034.2	1 673.2	1 827.7	2 278.4	1 796.1
I. Эргэлтийн хөрөнгө	250.2	92.5	117.1	157.1	403.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	29.5	19.2	20.3	32.6	67.0
Богино хугацаат хөрөнгө оруулалт	9.4	0.0	0.6	1.0	0.0
Авлага	166.5	15.1	19.2	30.5	59.9
Бараа материал, нөөц	44.8	48.3	69.4	87.1	98.5
Бусад эргэлтийн хөрөнгө	0.0	9.8	7.5	5.9	178.4
II. Эргэлтийн бус хөрөнгө	784.0	1 580.7	1 710.6	2 121.3	1 392.3
Газар	-	-	-	-	1.5
Барилга	398.0	809.5	885.4	949.2	625.2
Тоног төхөөрөмж	116.6	240.3	244.5	331.7	164.4
Тээврийн хэрэгсэл	43.0	106.7	97.6	146.9	70.5
Тавилга, эд хогшил	19.6	43.3	48.7	59.9	32.1
Түүх соёлын дурсгалт зүйлс	0.0	0.1	22.0	0.5	0.5
Номын фонд	4.9	4.9	5.2	5.4	5.3
Дуусаагүй барилга	35.5	55.6	33.1	29.4	14.5
Бусад үндсэн хөрөнгө	159.4	308.7	341.3	510.4	382.1
Биет бус хөрөнгө	4.7	7.5	15.4	87.4	95.6
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	2.3	3.8	17.4	0.5	0.5

2016 онд Нийслэлийн Өмчийн харилцааны газар 4 барилга байгууламж, объектыг дуудлага худалдаанд оруулан хувчилж, нийт 225 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлснээс нийслэлийн төсөвт 198.5 сая төгрөгийг өмч хувьчлалын орлого болгон шилжүүлжээ.

Хүснэгт 96. Нийслэлийн хувьчлагдсан өмч хөрөнгө, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн өмч	1 034.2	1 673.2	1 827.7	2 278.4	1 796.1
Үүнээс: Тухайн онд хувьчлагдсан	0.6	1.9	11.0	37.5	0.2

Хүснэгт 97. Нийслэлийн өмчийн бүтэц, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	1 034.2	1 673.2	1 827.7	2 278.4	1 796.1
Төсөвт байгууллага	563.2	1 104.3	1 282.3	1 404.9	1 071.9
Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар	241.2	480.4	460.5	757.5	633.1
Нийслэлийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газар	222	77.0	72.8	103.3	84.5
Өрхийн эмнэлэг	7.8	11.5	12.1	12.7	6.6

Хүснэгт 98. Нийслэлийн өмчийн бүтэц, тоо

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	659	711	720	733	770
Төсөвт байгууллага	450	514	539	537	571
Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар	74	64	46	61	61
Нийслэлийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газар	8	7	5	6	6
Өрхийн эмнэлэг	127	126	130	129	132

Нийслэлийн өмчийг байршлаар авч үзвэл, нийт өмчийн 20.7 хувь нь Баянзүрх, 15.8 хувь нь Сүхбаатар, 31.0 хувь нь Чингэлтэй, 7.2 хувь нь Сонгинохайрхан, 8.7 хувь нь Баянгол, 11 хувь нь Хан-Уул, үлдсэн 5.6 хувь нь Багануур, Багахангай, Налайх дүүргүүдэд тус тус байршиж байна.

Хүснэгт 99. Нийслэлийн өмч, дүүргээр, тэрбум төгрөг


Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	1 034.2	1 673.2	1 827.7	2 278.4	1 796.1
Багануур	35.2	69.2	70.9	80.3	52.1
Багахангай	11.3	17.2	18.6	20.9	13.0
Баянгол	106.0	186.8	163.7	181.2	156.4
Баянзүрх	220.9	453.8	499.7	627.4	371.8
Налайх	19.0	54.3	59.4	65.0	36.0
Сонгинохайрхан	107.9	199.1	170.7	208.9	129.6
Сүхбаатар	157.2	291.6	269.4	377.8	284.0
Хан-Уул	82.9	147.1	204.1	249.1	197.4
Чингэлтэй	293.8	254.1	371.2	467.8	556.0



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Нийслэлийн хэрэглээний үнийн индекс 2016 оны эцэст 0.5 хувь болж, өмнөх оноос 0.6 пунктээр буурчээ. Хэрэглээний үнийн индекс 2012 онд 3.1 пунктээр өсч 14.2 хувь, 2013 онд 1.9 пунктээр буурч 12.3 хувь, 2014 онд 1.6 пунктээр буурч 10.7 хувь, 2015 онд 9.6 пунктээр буурч 1.1 хувьд хүрч байжээ. 2016 оны эцэст хэрэглээний сагсанд сонгогдсон 329 нэр төрлийн бараа, үйлчилгээний 39.5 хувийнх нь үнэ өсч, 36.8 хувийнх нь үнэ буурч, 23.7 хувийн бараа үйлчилгээний үнэ тогтвортой байв.

Зураг 48. Хэрэглээний үнийн өөрчлөлт



2016 онд хэрэглээний үнийн сарын дундаж өсөлт тогтвортой байв. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 0.1 пунктээр буурсан үзүүлэлт юм.


Улаанбаатар хотод хэрэглээний үнийн сарын индекс 2016 оны 4 дүгээр сард 1.5 хувиар өссөн нь хамгийн өндөр өсөлт байв. Судалгаанд сонгогдсон хүнсний 93 нэрийн барааны 48 (51.6%) нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Нийслэлд хэрэглээний үнийн ерөнхий индекс 2016 оны эцэст өмнөх оноос 0.5 хувиар өссөний дотор хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 1.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 2.8 хувь, тээврийн бүлгийн үнэ 1.0 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 0.8 хувиар буурч, харин хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 1.4 хувиар, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 4.0 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 0.8 хувиар, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 7.8 хувиар, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.7 хувиар, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 2.6 хувиар, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 1.2 хувиар, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2.2 хувиар түс түс өсчээ.

Хүснэгт 100. Хэрэглээний үнийн индекс

Үзүүлэлт	2012-XII 2011-XII	2013-XII 2012-XII	2014-XII 2013-XII	2015-XII 2014-XII	2016-XII 2015-XII
Ерөнхий индекс	114.2	112.3	110.7	101.1	100.5
Хүнсний бараа, ундаа, ус	119.9	114.0	106.9	92.8	101.4
Согтууруулах ундаа, тамхи	154.6	111.7	110.4	100.6	104.0
Хувцас, бөс бараа, гутал	113.0	113.4	109.2	102.1	98.6
Орон сууц, ус, цахилгаан, түлш	108.7	108.4	122.1	103.1	97.2
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	104.5	120.7	108.5	105.4	100.8
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	111.7	121.7	111.4	104.4	107.8
Тээвэр	107.5	101.6	110.3	100.7	99.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	98.8	99.8	100.7	99.3	100.7
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	103.8	98.0	109.7	100.9	99.2
Боловсролын үйлчилгээ	116.1	128.4	117.7	123.6	102.6
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	121.8	117.5	105.1	103.5	101.2
Бусад бараа, үйлчилгээ	106.0	121.0	109.1	105.8	102.2

Зураг 49. Хэрэглээний үнийн өөрчлөлт



Хүснэгт 101. Нийслэлийн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн 2016 оны индекс
нөлөөлсөн бараа, үйлчилгээний өөрчлөлт

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, ундаа, ус	1.4	Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөд мах, махан бүтээгдэхүүн 5.2 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн 0.5 хувь, талх, гурил, будааны үнэ 1.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.
Согтууруулах ундаа, тамхи	4.0	Энэ бүлгийн үнийн өсөлтөд дарс 0.4 хувиар өссөн нь нөлөөлөв.
Хувцас, бөс бараа, гутал	-1.4	Хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн бууралтад бүх төрлийн хувцас 1.4 хувь, жижиг эдлэл хэрэгсэл 3.3 хувь, бүх төрлийн гутлын үнэ 1.7 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.
Орон сууц, ус, цахилгаан, түлш	-2.8	Орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн бууралтад сууц хөлслөгчдийн төлсөн бодит түрээс 7.0 хувь, орон сууцны засвар, үйлчилгээ 3.0 хувь, хатуу түлшний үнэ 12.8 хувиар тус тус буурсан нь нөлөөлөв.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	0.8	Энэ бүлгийн үнийн өсөлтөд гэр ахуйн оёмол, нэхмэл эдлэл 0.2 хувь, гэр ахуйн удаан эдэлгээт цахилгаан, бусад бараа 5.1 хувь, цахилгаан хэрэгслийн засвар 25.0 хувь, шилэн эдлэл, сав суулга 1.3 хувь, жижиг багаж хэрэгслийн үнэ 0.5 хувиар өссөн нь нөлөөлжээ.
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	7.8	Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөд эм, тарианы үнэ 7.1 хувь, амбулаторийн үйлчилгээ 18.5 хувь, шүдний эмнэлгийн үйлчилгээ 20.0 хувь, эмнэлгийн туслах үйлчилгээ 12.1 хувь, эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх үйлчилгээний төлбөр 3.0 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Тээвэр	-1.0	Энэ бүлгийн үнийн бууралтад хувийн тээврийн хэрэгслийн шатах, тослох материалын үнэ 7.1 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.7	Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөд телефон утас, факсын үйлчилгээ 0.7 хувиар өссөн нь нөлөөлжээ.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	-0.8	Энэ бүлгийн үнийн бууралтад тоглоом, наадам, хобби 0.3 хувь, чөлөөт цагийн үйлчилгээ 0.8 хувь, бичгийн болон зургийн хэрэгсэл 7.9 хувь, амралт, аялал, жуулчлал 12.1 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.
Боловсролын үйлчилгээ	2.6	Энэ бүлгийн үнийн өсөлтөд дээд боловсролын сургалтын төлбөр 2.6 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	1.2	Энэ бүлгийн үнийн өсөлтөд гуанз, цайны газрын үйлчилгээний үнэ 1.8 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.
Бусад бараа, үйлчилгээ	2.2	Бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлтөд гоо сайхны хэрэгцээнд зориулсан бусад эд зүйлсийн үнэ 3.6 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөв.

Хүснэгт 102. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын индекс


Бүлэг, дэд бүлэг	2016-XII 2015-XII	2016-XII 2016-XI
Ерөнхий индекс	100.5	100.9
Хүнсний бараа, ундаа, ус	101.4	103.0
01.1 Хүнсний бараа	101.3	103.2
01.2 Согтууруулах бүс ундаа	104.5	98.6
Согтууруулах ундаа, тамхи	104.0	99.8
02.1 Согтууруулах ундаа	99.5	100.0
02.2 Тамхи	108.2	99.5
Хувцас, бөс бараа, гутал	98.6	100.0
03.1 Хувцас, бөс бараа	98.6	100.3
03.2 Гутал	98.5	99.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	97.2	100.0
04.1 Орон сууцны бодит түрээс	93.0	100.0
04.2 Орон сууцны техникийн болон засварын үйлчилгээ	108.1	100.1
04.3 Усан хангамж болон орон сууцны бусад үйлчилгээ	100.0	100.0
04.4 Цахилгаан, хийн болон бусад түлш	91.8	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	100.8	100.2
05.1 Тавилга, хэрэгсэл, хивс болон бусад дэвсгэр	99.2	100.0
05.2 Оёмол, нэхмэл эдлэл	100.2	100.0
05.3 Цахилгаан бараа	105.0	100.2
05.4 Шилэн эдлэл, сав суулга	101.3	101.0
05.5 Цэцэрлэгийн зориулалттай хөдөлмөрийн багаж	100.5	100.7
05.6 Цэвэрлэгээний болон бусад жижиг бараа	99.4	100.3
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	107.8	100.1
06.1 Эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл	107.1	100.8
06.2 Амбулаторийн үйлчилгээ	113.9	99.1
06.3 Эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх үйлчилгээ	103.0	100.0
Тээвэр	99.0	100.6
07.1 Тээврийн хэрэгслийн худалдан авалт	100.1	99.9
07.2 Хувийн тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ	95.1	100.4
07.3 Тээврийн үйлчилгээ	102.5	101.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.7	100.0
08.1 Холбоо, шуудангийн үйлчилгээ	100.7	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	99.2	101.0
09.1 Дуу, дурс, гэрэл зураг, бусад тоног төхөөрөмж	99.7	100.0
09.2 Чөлөөт цагт зориулсан бусад хэрэгсэл	102.0	100.0
09.3 Чөлөөт цаг, соёлын үйлчилгээ	99.8	100.0
09.4 Ном, сонин, бичгийн хэрэгсэл	101.2	102.8
09.5 Амралт, аялал, жуулчлал	87.9	100.0
Боловсролын үйлчилгээ	102.6	100.0
10.1 Боловсролын үйлчилгээ	102.6	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	101.2	100.0
11.1 Нийтийн хоолны үйлчилгээ	101.2	100.0
11.2 Зочид буудал, дотуур байрны үйлчилгээ	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	102.2	101.2
12.1 Хувь хүнд хандсан үйлчилгээ	102.5	101.4
12.2 Хувь хүний эд зүйл, хэрэглэл	99.1	100.0
12.3 Санхүүгийн үйлчилгээ	100.0	100.0
12.4 Бусад үйлчилгээ	100.0	100.0

2016 оны жилийн эцсийн дүнг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад хэрэглээний бараа, үйлчилгээний индекс бүх аймагт 0.2-6.1 хүртэл хувиар өссөн байна.


Хүснэгт 103. Хэрэглээний үнийн индекс, аймгаар, (Суурь үнэ 2010-XII=100%)

Бүс, аймаг	2012	2013	2014	2015	2016
Баруун бүс					
Баян-Өлгий	124.6	143.3	159.4	153.4	156.1
Говь-Алтай	122.4	133.5	146.3	149.6	155.0
Завхан	132.4	152.5	167.8	174.7	176.8
Увс	123.7	134.6	155.0	159.9	161.5
Ховд	124.4	136.0	154.6	153.4	153.8
Хангайн бүс					
Архангай	128.2	139.3	163.2	182.6	193.7
Баянхонгор	127.5	146.0	163.9	174.4	175.5
Булган	118.5	144.0	159.0	161.6	164.4
Орхон	127.5	146.9	165.6	166.5	169.0
Өвөрхангай	118.8	138.5	156.4	167.5	168.9
Хөвсгөл	125.2	136.4	152.4	155.9	157.9
Төвийн бүс					
Говьсүмбэр	131.6	151.7	164.4	174.2	179.5
Дархан-Уул	118.1	130.8	141.9	141.9	145.1
Дорноговь	123.7	146.7	161.7	158.0	161.1
Дундговь	120.1	137.4	152.8	158.9	167.7
Өмнөговь	123.0	142.8	157.0	159.2	159.9
Сэлэнгэ	120.4	130.1	143.9	147.4	149.4
Төв	122.9	138.6	151.6	160.9	165.6
Зүүн бүс					
Дорнод	128.8	142.6	157.8	166.2	169.0
Сүхбаатар	122.1	134.5	149.7	156.3	158.8
Хэнтий	118.0	131.2	146.8	147.1	149.3
Нийслэл	124.9	140.3	153.8	155.5	156.3

Зураг 50. Хэрэглээний үнийн индекс, аймаг, хотоор (Суурь үнэ 2010-XII=100%)



Зураг 51. 2016 оны хэрэглээний үнийн индекс, аймаг, хотоор



Нийслэлийн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн 2016 оны 1-12 сар хүртэлх индексийг 2010 оны суурь үетэй харьцуулахад 53.8-60.5 хүртэл хувиар өссөн байв. Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн индекс 2012 онд өмнөх оноос 19.9 хувь, 2013 онд 14.0 хувь, 2014 онд 6.9 хувиар тус тус өссөн байна. Харин 2015 онд 7.2 хувиар буурсан боловч 2016 онд 1.4 хувиар нэмэгджээ.

2011 онд мах, махан бүтээгдэхүүний бүлгийн үнэ өмнөх оноос 19.9 хувь, 2012 онд 43.7 хувь, 2013 онд 10.5 хувиар тус тус өсч байсан бол 2014 онд 0.5 хувиар, 2015 онд 23.4 хувиар буурч байжээ. Харин 2016 онд 5.2 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 104. Нэг кг махны дундаж үнэ, төгрөг


Үхрийн мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2012	5 430	6 651	7 363	7 631	7 751	8 177	8 068	7 848	7 397	7 022	6 982	7 170
2013*	7 335	8 025	7 895	8 330	8 380	8 275	8 225	7 710	7 825	7 245	7 115	7 280
2014*	7 980	7 775	8 425	8 370	8 685	8 730	7 955	7 590	7 635	7 550	7 495	7 465
2015*	7 415	7 565	7 810	8 080	8 145	8 445	7 985	7 230	7 005	5 975	5 620	5 520
2016*	6 165	6 875	7 105	8 170	8 495	7 930	6 950	6 865	6 120	5 235	5 495	5 580

Хонины мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2012	4 986	5 906	7 025	7 016	7 188	7 174	7 600	7 198	6 912	6 232	6 133	6 247
2013*	6 480	7 095	7 060	7 420	7 490	7 470	7 415	6 710	6 540	6 215	6 085	6 245
2014*	6 855	6 675	7 040	7 630	7 800	7 685	7 030	6 585	6 395	5 965	5 835	5 940
2015*	5 860	6 140	6 735	7 460	7 555	7 455	6 830	6 050	5 540	4 510	4 200	3 930
2016*	4 625	5 495	5 970	6 935	6 945	6 525	5 780	5 605	4 940	4 250	3 945	4 390


* Махны дундаж үнийг хүнсний захуудын махны борлуулалтын хувийн жинд үндэслэн жигнэсэн дундаж аргаар тооцов.

2016 онд нийслэлийн хүнсний захуудаар худалдаж байсан хонины ястай махны үнэ дунджаар 5450 төгрөг, үхрийн ястай махны үнэ дунджаар 6750 төгрөг байв. Хонины ястай мах 11-р сард хамгийн хямд буюу 3945 төгрөг, 5-р сард хамгийн үнэтэй буюу 6945 төгрөг байсан бол үхрийн ястай мах 10-р сард хамгийн хямд буюу 5235 төгрөг, 5-р сард хамгийн үнэтэй буюу 8495 төгрөгөөр худалдаалагдаж байв.


Зураг 52. Хонины нэг килограмм махны дундаж үнэ, төгрөг




Зураг 53. Үхрийн нэг килограмм махны дундаж үнэ, төгрөг




Зураг 54. Нэг кг монгол төмсний үнэ, төгрөг




Зураг 55. Нэг кг монгол луувангийн үнэ, төгрөг



Зураг 56. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, төгрөг




Зураг 57. Нэг кг дээд гурилын дундаж үнэ, төгрөг



2016 онд "Алтан тариа" дээд, 1, 2-р зэргийн гурилын үнэ тогтвортой худалдаалагдаж байв. "Алтан тариа" дээд зэргийн 1 кг гурил 1270 төгрөг, 1-р зэргийн гурил 1093 төгрөг, 2-р зэргийн гурил 836 төгрөгийн үнэтэй байлаа. Харин импортоор орж ирдэг орос дээд зэргийн нэг кг гурилын үнэ 2012 онд 870 төгрөг, 2013 онд 1350 төгрөг, 2014 онд 1320 төгрөг, 2015 онд 1315 төгрөг, 2016 онд 1308 төгрөгийн дундаж үнэтэй байжээ.


Зураг 58. Нэг кг савласан гурилын дундаж үнэ, төгрөг



Зураг 59. Нэг кг будааны үнэ, төгрөг




Зураг 60. Нэг кг элсэн чихрийн үнэ, төгрөг




2016 оны эхний хагас жилд цагаан будааны дундаж үнэ 2377 төгрөг байснаа сүүлийн хагас жилд 2418 төгрөг болж, 41 төгрөгөөр (2.0%) өссөн бол шар будаа 1697 төгрөг байснаа 1679 төгрөг болж, 18 төгрөгөөр (1.0%) бүүрчээ.

Зураг 61. Хэрэглээний үнийн индекс, сараар



Зураг 62. Валютын сарын дундаж ханш, төгрөг



Хүснэгт 105. Гол нэрийн зарим барааны жилийн дундаж үнэ, бүс, аймгаар


Бүс, аймаг	Хонины мах, кг	Үхрийн мах, кг	Гурил, кг	Цагаан будaa, кг	Шингэн сүү, л	Элсэн чихэр, кг	Бензин Аи-80, л
Баруун бүс							
Баян-Өлгий	4 739	4 150	874	2 467	1 739	1 975	1 423
Говь-Алтай	4 617	5 792	1 300	2 289	1 967	1 939	1 522
Завхан	5 153	5 556	1 178	2 361	1 875	1 917	1 567
Увс	5 269	5 358	1 050	2 272	1 536	2 039	1 544
Ховд	5 542	5 542	1 438	2 512	1 767	2 142	1 539
Хангайн бүс							
Архангай	5 683	6 367	1 250	2 696	1 717	1 921	1 483
Баянхонгор	4 839	4 917	1 267	2 300	1 983	2 069	1 500
Булган	5 375	6 250	1 290	2 461	1 417	2 006	1 465
Орхон	5 794	6 531	958	2 381	1 294	1 872	1 481
Өвөрхангай	4 908	5 578	1 224	2 336	1 700	1 881	1 468
Хөвсгөл	5 646	6 479	1 246	2 508	1 367	1 964	1 578
Төвийн бүс							
Говьсүмбэр	5 406	6 556	1 120	2 078	1 388	1 689	1 482
Дархан-Уул	5 879	6 404	1 099	2 356	1 181	2 017	1 460
Дорноговь	5 294	6 917	1 092	2 094	1 942	1 781	1 471
Дундговь	4 825	-	1 232	2 226	2 069	1 840	1 497
Өмнөговь	5 286	-	1 200	2 250	2 608	1 969	1 542
Сэлэнгэ	5 553	6 700	1 039	2 308	1 078	1 917	1 486
Төв	5 868	6 896	1 186	2 310	1 440	1 922	1 457
Зүүн бүс							
Дорнод	5 653	6 764	959	2 148	1 186	1 946	1 543
Сүхбаатар	5 333	6 417	1 173	2 043	1 561	1 824	1 580
Хэнтий	5 469	6 833	1 167	2 283	1 304	1 753	1 557
Нийслэл	5459	6758	1120	2539	1280	1991	1458

Хүснэгт 106. Нийслэлийн зарим бараа, үйлчилгээний жилийн дундаж үнэ

Бараа, үйлчилгээ	2012	2013	2014	2015	2016
Гурил, 1-р зэрэг, кг	696	728	905	1 094	1 120
"Атар" талх	662	805	918	1 106	1 156
Цагаан будаа, кг	1 699	1 862	2 343	2 410	2 539
Сүү, литр	1 095	1 140	1 375	1 283	1 280
Элсэн чихэр, кг	1 702	1 684	1 704	1 753	1 991
Ногоон цай, 2кг	4 252	4 332	4 765	5 299	5 672
Алим, кг	3 571	3 615	3 979	4 108	4 083
Төмс, кг	1 033	938	988	1 263	969
Байцаа, кг	1 103	1 287	1 206	1 428	1 455
Лууван, кг	1 184	1 241	1 318	1 532	1 693
Манжин, кг	1 161	1 460	1 413	1 775	1 966
Сонгино, кг	1 027	1 323	1 244	1 236	1 285
Ургамлын тос, литр	2 740	2 841	3 154	3 283	3 423
Өндөг, ширхэг	266	311	370	314	284
Архи, 0.5 литр	5 280	6 819	7 372	7 600	7 606
Халаалт, м2	375	409	484	587	643
Цэвэр усны үнэ, сард, 1 хүний	3 202	3 202	3954	4 706	4 706
Цахилгаан, 1 кВт.ц	86.9	95.0	110.0	128.0	130.0
Автобусны тасалбар	400	400	500	500	500
Телевизийн сарын хураамж	1 100	1 100	1 100	1 100	1 100
Сурагчийн дэвтэр	160	190	200	215	227


2016 онд шатахуун импортлогч томоохон компаниуд Аи-80, Аи-92 бензин болон дизель түлшний үнийг 100-150 төгрөгөөр бууруулсан байна. Ингэхдээ Аи-80 бензин 1463 төгрөг, Аи-92 бензин 1555 төгрөг, дизель түлш 1666 төгрөгийн дундаж үнэтэй байв.

Зураг 63. Аи-80 автобензины үнэ, төгрөг




2016 онд Аи-80 бензиний үнэ Баян-Өлгий аймагт хамгийн хямд буюу 1423 төгрөг байсан бол Сүхбаатар аймагт хамгийн үнэтэй буюу 1580 төгрөгийн ханштай байв.

Зураг 64. Аи-92 автобензины үнэ, төгрөг



Зураг 65. Дизель түлшний үнэ, төг






ХӨДӨӨ АЖ АХУЙ

Мал, тэжээвэр амьтдын тоо:

Нийслэлийн мал, тэжээвэр амьтдын 2016 оны тооллогоор нийт 438329 толгой мал тоологдсон нь 2015 оноос 34674 (8.6%) толгой малаар өсчээ. Улсын хэмжээнд 2016 онд 61549.2 мянган толгой мал тоологдсон бөгөөд нийслэлийн мал 0.7 хувийг эзэлж

байна.

Зураг 66. Нийслэлийн малын тоо, улсын дүнтэй харьцуулснаар, мянган толгой



Малын таван төрлөөр өмнөх онтой харьцуулахад тэмээ 14 толгой (6.0%), адуу 8442 толгой (23.0%), үхэр 3794 толгой (4.4%), хонь 14491 толгой (8.9%), ямаа 7933 толгойгоор (6.7%) тус тус өсчээ.

Иргэдийн хувийн мал 428369 толгой, аж ахуйн нэгж, байгууллагын мал 9960 толгой болж өмнөх оноос иргэдийн мал 8.6 хувиар, аж ахуйн нэгж, байгууллагын мал 8.6 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 107. Малын тоо, төрлөөр

Малын төрөл	2012	2013	2014	2015	2016	Өсөлт, бууралт	
						тоо	хувь
Малын тоо, бүгд	308 460	329 089	385 364	403 655	438 329	34 674	108.6
Тэмээ	177	120	154	233	247	14	106.0
Адуу	25 803	30 202	33 864	36 735	45 177	8 442	123.0
Үхэр	60 598	64 611	76 570	86 006	89 800	3 794	104.4
Хонь	124 732	134 616	158 853	162 322	176 813	14 491	108.9
Ямаа	97 150	99 540	115 923	118 359	126 292	7 933	106.7
Хонин толгойд шилжүүлснээр ⁹	757 261	823 882	960 422	1 043 191	1 146 750	103 559	109.9

⁹ Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ: 5 хонь, 1 адуу: 7 хонь, 1 үхэр: 6 хонь, 1 хонь: 1 хонь, 1 ямаа: 0.9 хонь

Амины малын тоо:

Иргэдийн хувийн өмчийн малын тоо 2016 онд 428369 толгой болж, нийт малын 97.7 хувийг эзэлж байна. Тоологдсон тэмээний 99.6 хувь, адууны 98.0 хувь, үхрийн 98.4 хувь, хонины 96.6 хувь, ямааны 98.7 хувийг хувийн аж ахуйн мал эзэлж байна.

Хүснэгт 108. Малтай өрхийн тоо, малын бүлэглэлтээр, 2016 он

Малын бүлэглэлт	Малтай өрхийн тоо	Ам бүлийн тоо	Амины малын тоо	Үүнээс :				
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Малын тоо, бүгд	5 270	17 633	428 369	246	44 291	88 328	170 880	124 624
10 хүртэлх	1 637	5 284	9 184	5	594	8 413	66	106
11-30	1 487	4 713	27 628	2	3 149	21 901	1 085	1 491
31-50	549	1 884	21 765	2	4 094	13 274	2 039	2 356
51-100	587	2 106	42 415	3	7 664	16 131	9 205	9 412
101-200	418	1 438	59 972	7	8 156	9 784	22 573	19 452
201-500	438	1 614	138 199	19	11 562	11 367	64 848	50 403
501-999	118	453	77 576	39	5 788	4 671	41 996	25 082
1000-1499	22	83	25 193	115	1 263	1 241	13 559	9 015
1500-2000	9	40	14 493	0	1 090	605	9 115	3 683
2001-с дээш	5	18	11 944	54	931	941	6 394	3 624

Нийслэлийн малтай нэг өрхөд 79 толгой мал, хонин толгойд шилжүүлснээр 203 толгой мал ногдож байгаа бөгөөд малтай өрхийн ам бүлийн нэг хүнд 24 толгой мал, хонин толгойд шилжүүлснээр 62 мал ногдож байна. Малтай нэг өрхөд ногдох малын тоогоор Багануур дүүрэг (нэг өрхөд 230 толгой мал) тэргүүлж байна.

2016 онд малын тоо өмнөх оноос Чингэлтэй дүүрэгт 10.9 хувиар, Сүхбаатар дүүрэгт 9.4 хувиар, Сонгинохайрхан дүүрэгт 0.3 хувиар буурч, бусад дүүргүүдэд 3.6-15.4 хувиар тус тус өссөн байна.

Тоологдсон нийт малын тоогоор Багануур дүүрэг 178774 толгой малаар тэргүүлж, өмнөх оноос 23791 толгой малаар өсөв. Үхрийн тоогоор Сонгинохайрхан дүүрэг, бусад малын төрлөөр Багануур дүүрэг тэргүүлж байна.

Хүснэгт 109. Малын тоо, дүүргээр, 2016 он

Дүүрэг	Малын тоо	Үүнээс :					Өсөлт, бууралт
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
Нийслэлийн дүн	438 329	247	45 177	89 800	176 813	126 292	8.6
Багануур	178 774	209	14 043	14 198	91 271	59 053	15.4
Багахангай	31 608	7	3 934	3 046	12 760	11 861	4.9
Баянзүрх	55 319	2	5 515	18 464	17 401	13 937	10.4
Налайх	55 804	22	6 803	12 366	21 765	14 848	6.9
Сонгинохайрхан	73 576	-	7 099	26 731	23 088	16 658	-0.3
Сүхбаатар	3 051	-	146	2 188	339	378	-9.4
Хан-Уул	38 860	7	7 451	12 274	9 958	9 170	3.6
Чингэлтэй	1 337	-	186	533	231	387	-10.9

Мал төллөлт, төл бойжилт:

2016 онд 170318 хээлтэгч мал төллөж, 170542 төл гарсны 166173 төл (97.4%) бойжсон байна. Бойжсон төлийн тоо өмнөх оноос 657 толгойгоор (0.4%) бүүрчээ. Бойжуулсан нийт төлийн 0.02 хувийг ботго, 5.9 хувийг унага, 19.1 хувийг тугал, 43.8 хувийг хурга, 31.2 хувийг ишиг эзэлж байна. 2016 онд Сүхбаатар дүүргийн 15-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 21, 32-р хорооны 3 өрхөд тус бүр ихэр тугал гарчээ.

Хүснэгт 110. Төл бойжилт, төрлөөр

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Гарсан төл	129 534	132 307	141 592	169 438	170 542
Бойжсон төл	127 866	129 713	139 223	166 830	166 173
Хорогдсон төл	1 668	2 594	2 369	2 608	4 369
Бойжилтын хувь	98.7	98.0	98.3	98.5	97.4

Том малын зүй бүс хорогдол:

Оны эхний малын 1.6 хувьтай тэнцэх 6413 толгой том мал зүй бусаар хорогдож, өмнөх оноос 2.3 дахин өсчээ. Хорогдсон нийт малын 1.4 хувийг адуу, 19.1 хувийг үхэр, 54.8 хувийг хонь, 24.7 хувийг ямаа эзэлж байна. Том малын зүй бүс хорогдлын 16.7 хувь буюу 1070 толгой мал өвчнөөр хорогджээ.

Хүснэгт 111. Том малын зүй бүс хорогдол, дүүргээр

Дүүрэг	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	2 549	3 629	2 128	2 738	6 413
Багануур	1 288	1 686	1 106	1 023	882
Багахангай	79	137	38	116	463
Баянгол	1	1	1	6	-
Баянзүрх	127	428	308	377	1 678
Налайх	560	455	101	301	1 397
Сонгинохайрхан	332	640	232	309	1 129
Сүхбаатар	49	42	32	36	96
Хан-Уул	103	231	293	552	751
Чингэлтэй	10	9	17	18	17

Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн мал:

2016 онд мал эрхлэхийг хориглох нийслэлийн бүсэд 16704 толгой мал тоологдож, өмнөх оноос 1705 толгой малаар (11.4%) өссөн байна. Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсэд байгаа малын 7.4 хувийг адуу, 53.5 хувийг үхэр, 19.6 хувийг хонь, 19.5 хувийг ямаа эзэлж байсан байна.

Хориглох бүсийн малын тоог өмнөх онтой харьцуулахад Сонгинохайрхан дүүрэгт 32.9 хувиар, Баянзүрх дүүрэгт 31.1 хувиар өсч, Чингэлтэй дүүрэгт 10.9 хувиар, Сүхбаатар дүүрэгт 9.4 хувиар, Хан-Уул дүүрэгт 7.6 хувиар тус тус бүүрчээ.

Хүснэгт 112. Мал аж ахуй эрхлэхийг хориглох нийслэлийн бүсэд байгаа малын тоо, дүүргээр

Дүүрэг	2012	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	17 478	15 017	15 367	14 999	16 704
Баянгол	17	13	12	-	-
Сүхбаатар	3 626	3 312	2 953	3 367	3 051
Чингэлтэй	1 528	1 364	1 840	1 500	1 337
Баянзүрх (11,20-р хороо ороогүй)	3 016	3 067	1 898	2 376	3 114
Сонгинохайрхан (21,32-р хороо ороогүй)	6 458	4 769	6 422	5 024	6 677
Хан-Уул (12,13,14-р хороо ороогүй)	2 833	2 492	2 242	2 732	2 525

Тэжээвэр амьтад:

Мал, тэжээвэр амьтдын 2016 оны тооллогоор 123 өрх, 12 аж ахуйн нэгжийн 20226 гахай, 275 өрх, 12 аж ахуйн нэгжийн 417739 шувуу (үүнээс 415540 тахиа), 3 илжиг, 326 туулай, 31 минж, 80 бүл зөгий тоологдсон байна. Өмнөх оноос шувуу болон тахианы тоо 10.7 хувиар, гахайн тоо 14.7 хувиар тус тус өсөв.

Хүснэгт 113. Тэжээвэр амьтдын тоо, дүүргээр, 2016 он

Дүүрэг	Гахай	Шувуу	тахиа	Илжиг	Туулай	Минж	Зөгий
Нийслэлийн дүн	20 226	417 739	415 540	3	326	31	80
Багануур	166	218	166	-	-	-	10
Багахангай	23	82	82	-	-	-	-
Баянгол	36	22	20	-	-	-	-
Баянзүрх	202	412	256	-	7	31	-
Налайх	828	92 133	92 052	1	21	-	-
Сонгинохайрхан	13 949	880	748	-	19	-	26
Сүхбаатар	5	675	403	-	9	-	33
Хан-Уул	5 007	322 527	321 340	-	243	-	11
Чингэлтэй	10	790	473	2	27	-	-



ГАЗАР ТАРИАЛАН

Нийслэлийн хэмжээнд 2016 онд 351.3 га талбайд төмс, 496.6 га талбайд хүнсний ногоо, 256.5 га талбайд тэжээлийн ургамал тариалсан байна. Тариалалт хийсэн нийт талбайн 716.5 га (64.9%) нь усалгаатай талбай, 66.0 га (6.0%) нь хүлэмжийн талбай байна.


Хүснэгт 114. Тариалсан талбай, төрлөөр, га, 2016 он

Төрөл	Тариалсан талбай	Усалгаатай талбай	Хүлэмж
Төмс	351.3	203.2	-
Хүнсний ногоо	496.6	479.4	66.0
Үүнээс:			
байцаа	129.7	129.6	0.1
лууван	82.1	82.1	-
шар манжин	70.7	70.7	-
улаан манжин	45.1	44.9	-
сонгино	26.5	26.3	0.1
сармис	2.8	2.8	-
өргөст хэмх	55.9	48.2	42.1
улаан лооль	31.8	27.7	20.2
тарвас	6.1	6.1	0.1
хулуу	0.7	0.6	0.1
чинжүү	2.7	2.5	1.6
бусад	42.5	37.9	1.7
Тэжээлийн ургамал	256.5	33.9	-

Нийслэлийн хэмжээнд 2016 онд 2846.6 тонн төмс, 5434.0 тонн хүнсний ногоо, 1698.2 тонн тэжээлийн ургамал хураан авч, 16941.7 тонн өвс хадлан, 3239.5 тонн гар тэжээл бэлтгэсэн байна.

Хурааж авсан нийт ургацын 11.7 хувь нь аж ахуйн нэгж байгууллагуудад, 88.3 хувь нь иргэдэд ногдож байна. Өмнөх онтой харьцуулахад төмс 255.3 тонноор (8.2%) буурч, хүнсний ногоо 1676.0 тонн (44.6%), өвс хадлан 4441.7 тонноор (35.5%) түс түс өсчээ.

Зураг 67. Ургац хураалт, тонн



Нийслэлийн хэмжээнд хураан авсан нийт ургацын 41.8 хувийг Сонгинохайрхан дүүрэг, 14.1 хувийг Хан-Уул дүүрэг, 14.0 хувийг Багануур дүүрэг, 12.0 хувийг Налайх дүүрэг, 11.3 хувийг Баянзүрх дүүрэг, 6.8 хувийг бусад дүүргүүд түс түс эзэлж байна.

Хүснэгт 115. Хураасан нийт ургац, ургамлын төрөл, дүүргээр


Дүүрэг	Төмс				
	2012	2013	2014	2015	2016
	тонн				
Нийслэлийн дүн	5 182.7	4 060.5	4 334.6	3 101.9	2 846.6
Багануур	798.0	510.6	644.6	324.9	315.2
Багахангай	66.1	37.4	4.2	10.5	6.4
Баянгол	60.5	65.4	261.1	98.3	250.4
Баянзүрх	240.7	208.7	156.9	275.2	83.3
Налайх	102.8	413.4	277.4	318.7	85.5
Сонгинохайрхан	3 246.2	2 144.7	2 551.9	1 810.0	1 699.0
Сүхбаатар	92.0	33.1	46.1	26.2	10.5
Хан-Уул	565.3	636.4	389.5	199.6	300.6
Чингэлтэй	11.1	10.8	2.9	38.5	95.7
Дүүрэг	Хүнсний ногоо				
	2012	2013	2014	2015	2016
	тонн				
Нийслэлийн дүн	3 137.2	3 028.6	5 527.5	3 758.0	5 434.0
Багануур	157.0	173.3	293.5	106.4	81.5
Багахангай	7.0	6.9	9.2	6.2	3.1
Баянгол	345.7	447.8	510.1	454.3	440.5
Баянзүрх	329.4	394.0	237.9	260.1	151.1
Налайх	40.5	131.6	148.1	170.5	107.7
Сонгинохайрхан	935.9	610.1	3 154.0	1 726.3	2 164.1
Сүхбаатар	25.5	23.6	36.5	29.6	34.6
Хан-Уул	1 264.6	1 209.2	1 134.7	956.7	2 404.6
Чингэлтэй	31.6	32.1	3.5	47.9	46.8



АЖ ҮЙЛДВЭР

2016 онд аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа эрхлэн явуулсан нийслэлийн аж ахуйн нэгжүүд оны үнээр 6927.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2015 онтой харьцуулбал 15.7 хувиар өсчээ.

Зураг 68. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, тэрбум төгрөг



2016 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг 2015 онтой харьцуулбал нүүрс олборлолт, төмрийн хүдэр олборлолтын нийт үйлдвэрлэлт, мөн түүнчлэн мах загас ногоо, тос боловсруулалт, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, үр тарианы гурил, малын тэжээлийн үйлдвэрлэлт, ундаа үйлдвэрлэлт, хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, нэхмэлийн үйлдвэрлэлт, хувцас үйлдвэрлэлт, мод, модон эдлэл үйлдвэрлэлт, цаас цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, төмөрлөг бүс эдлэлийн үйлдвэрлэлт, бичиг хэрэг тооцоолох техник үйлдвэрлэлт, эмнэлгийн багаж, хэмжүүр үйлдвэрлэлт, цахилгаан, дулаан уур үйлдвэрлэлт 1.8 хувиас 16.3 дахин өссөн байна.

Зураг 69. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлтийн салбарын бүтэц, оны үнэ, хувиар



Хүснэгт 116. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, өссөн дүн, сая төгрөг

Үзүүлэлт	Нийт бүтээгдэхүүн				
	2012	2013	2014	2015	2016
Нийт дүн	3 103 864.5	5 127 369.6	6 104 575.0	5 987 315.5	6 927 222.0
Уул уурхай олборлох үйлдвэр	1 615 282.2	3 149 974.1	3 875 465.0	3 768 137.6	4 534 498.6
Нүүрс олборлолт	692 165.0	487 394.9	342 118.5	320 246.5	526 797.8
Газрын тос, шатдаг хий олборлолт	467 096.8	770 940.1	1 241 570.5	833 695.5	746 165.7
Төмрийн хүдэр олборлолт	385 612.7	1 840 874.2	2 229 043.3	2 547 360.1	3 194 715.1
Бусад ашигт малтмал олборлолт	70 407.7	50 764.9	62 732.7	66 835.5	66 820.0
Боловсруулах үйлдвэр	1 080 045.1	1 511 863.2	1 670 427.3	1 536 251.1	1 616 441.2
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	532 773.5	626 482.4	749 518.2	805 633.2	887 384.2
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	67 318.5	105 140.9	95 163.5	65 366.5	73 419.2
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	39 041.6	42 068.0	51 104.6	49 550.1	62 192.9
Үр тарианы гүрил, малын тэжээл	57 299.0	84 514.6	126 712.2	132 274.0	141 259.2
Хүнсний бусад бүтээгдэхүүн	60 333.8	77 509.2	92 699.6	98 052.6	102 995.8
Ундаа үйлдвэрлэл	308 780.6	317 249.7	383 838.3	460 390.0	507 517.1
Тамхи үйлдвэрлэл	51 264.4	74 779.1	91 039.1	72 663.9	22 265.3
Нэхмэлийн үйлдвэрлэл	169 981.3	234 790.1	306 036.5	280 249.2	411 714.3
Хувцас үйлдвэрлэл	7 204.1	19 954.6	8 195.7	7 943.1	9 566.3
Арьс шир боловсруулах үйлдвэрлэл	7 853.0	8 254.5	11 913.9	19 593.3	12 317.5
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	9 013.9	8 941.9	3 348.9	3 023.2	7 706.4
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	11 768.8	9 894.9	8 241.3	8 480.3	8 782.2
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	26 601.1	26 629.9	24 084.7	26 207.7	26 671.4
Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш	102 270.9	311 301.4	320 066.0	187 515.3	112 886.1
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	54 549.1	49 359.6	40 560.4	44 155.8	47 113.7
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	10 146.7	12 061.0	37 640.5	34 918.2	21 487.3
Төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл	61 925.0	92 882.2	31 406.6	23 312.9	33 201.0
Төмрийн үйлдвэрлэл	1 842.3	4 040.8	1 830.0	0.0	2 184.9
Машин, төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	20 247.7	19 907.4	23 968.1	9 611.5	2 550.9
Машин тоног төхөөрөмж үйлдвэрлэл	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бичиг хэрэг, тооцоолох техник үйлдвэрлэл	3 860.0	3 343.0	850.7	8.5	138.5
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	2 370.4	4.0	137.4	0.0	0.0
Эмнэлгийн багаж, хэмжүүр үйлдвэрлэл	77.0	119.6	508.0	1 054.8	1 083.1
Тээврийн бусад үйлдвэрлэл	3 533.0	2 872.8	2 650.8	2 833.7	2 719.1
Мебель болон бусад үйлдвэрлэл	2 762.9	6 244.0	8 430.5	9 046.5	6 669.0
Цахилгаан, дулаан, усан хангамж	408 537.2	465 532.3	558 682.7	682 926.8	776 282.2
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэлт	381 990.5	438 185.2	523 527.8	638 683.8	731 773.1
Ус ариутгал, усан хангамж	26 546.7	27 347.1	35 154.9	44 243.0	44 509.1

2015, 2016 онд аж үйлдвэрийн гол нэрийн зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл тухайлбал, цахилгаан эрчим хүч, дулааны эрчим хүч, алт, самнасан ноолуур, улаан тоосго, сонин, гүрил, өлөн гэдэс, гоймон, пүнтүүз, амтат ус ундааны үйлдвэрлэл 3.3 хувиас 3.5 дахин өссөн байна.

Хүснэгт 117. Аж үйлдвэрийн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2012	2013	2014	2015	2016
Цахилгаан эрчим хүч	сая квт.цаг	4 093.7	4 313.9	4 631.6	4 772.1	4 938.3
Дулааны эрчим хүч	мянган гкал	6 959.8	7 022.4	7 241.6	7 576.5	7 824.2
Түгээсэн цэвэр ус	мянган м³	43 279.3	45 025.1	45 346.5	45 437.5	44 838.1
Нүүрс	мянган тонн	17 358.0	15 466.6	12 542.6	10 129.3	12 364.5
Алт	кг	5 579.4	8 129.8	9 173.6	10 782.3	16 338.1
Хайлуур жоншны баяжмал	мянган тонн	143.4	66.6	36.1	47.3	34.1
Улаан тоосго	сая ширхэг	45.5	47.6	8.7	4.0	14.1
Хивс	мянган м²	40.6	40.8	44.0	41.8	41.8
Сүлжмэл эдлэл	мянган ширхэг	768.1	933.3	955.2	830.2	830.3
Эсгий	мянган метр	39.5	47.2	37.5	31.9	32.0
Самнасан ноолуур	тонн	394.0	521.8	619.7	498.7	778.0
Тэмээний ноосон хөнжил	мянган метр	8.2	3.0	3.0	8.9	2.8
Сонин	сая х.д.х	69.1	55.8	32.8	35.5	35.2
Ном, сэтгүүл	сая х.д.х	64.4	61.1	69.2	87.9	62.4
Гурил	мянган тонн	100.1	134.4	153.8	138.0	155.8
Хүнсний давс	тонн	2 415.0	2 164.0	1 827.0	0.0	0.0
Малын мах	мянган тонн	12.3	16.4	14.2	8.4	6.2
Өлөн гэдэс	мянган гогцоо	746.8	515.1	207.8	289.5	592.6
Хиамны зүйл	мянган тонн	1.9	2.0	3.0	3.0	4.3
Талх	мянган тонн	19.3	18.8	22.2	20.3	19.0
Нарийн боов	мянган тонн	9.6	13.4	13.7	12.9	12.3
Боловсруулсан шингэн сүү	сая литр	24.6	25.9	27.5	26.5	29.1
Гоймон пүнтүүз	тонн	3 185.2	1 479.0	2 665.8	2 011.9	4 028.4
Архи, дарс	сая литр	23.2	21.5	17.8	13.7	16.8
Амтат ус, ундаа	мянган литр	74 423.9	78 704.7	92 434.5	112 366.8	128 615.5

2016 онд аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтэд цахилгаан, дулаан эрчим хүч, усан хангамжийн эзлэх хувь өмнөх оноос 0.2 пунктээр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын хувь 2.3 пунктээр бүүрч, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн эзлэх хувь 2.5 пунктээр өссөн байна.


Нийслэлийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлтийн 65.5 хувийг уул, уурхайн салбар эзэлж байна. Уул уурхайн олборлох салбарын гол нэрийн бүтээгдэхүүн болох нүүрс олборлолт 2016 онд 12364.5 мянган тонн болсон нь өмнөх оноос 22.1 хувиар өссөн байна. Нийслэл хотод бүртгэлтэй олборлох аж ахуйн нэгж, байгууллагууд 2016 онд нийт 16338.1 кг алт олборлосон нь өмнөх онтой харьцуулахад 51.5 хувиар өссөн байна.

Нийслэлийн хэмжээнд 4938.3 сая квт.цаг цахилгаан, 7.8 сая гкал дулаан, 44.8 сая метр куб ус түгээсэн байна. 2016 онд оны үнээр 776.3 тэрбум төгрөгийн цахилгаан, дулаан, ус үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 13.7 хувиар өсчээ.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлтэд боловсруулах салбарын бүтээгдэхүүн оны үнээр 2012 онд 34.8 хувь, 2013 онд 31.1 хувь, 2014 онд 27.4 хувь, 2015 онд 25.6 хувь, 2016 онд 23.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 2.3 пунктээр буурчээ. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт 2016 онд 5.2 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтөд мах, загас, ногоо, тос үйлдвэрлэл, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үр тариа, ундаа, хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, хувцас үйлдвэрлэл, мод, модон эдлэл үйлдвэрлэл, цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хэвлэл болон дуу бичлэгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, бичиг хэрэг, тооцоолох техник үйлдвэрлэл, эмнэлгийн багаж, хэмжүүр үйлдвэрлэл зэрэг салбарын үйлдвэрлэлтийн өсөлт нөлөөлсөн байна.

Нийслэлийн аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалт 2016 онд 7692.6 тэрбум төгрөгт хүрсэн нь 2015 оны нийт борлуулалттай харьцуулбал 6.8 хувиар өссөн байна.

Зураг 70. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, тэрбум төгрөг



Нийслэлийн аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний борлуулалтын 3460.2 тэрбум төгрөгийг дотоодод, 4232.4 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна.

Хүснэгт 118. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт, борлуулалт, оны үнээр

Он	Нийт үйлдвэрлэлт (сая төгрөг)	Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт (сая төгрөг)	Үүнээс:		Ажиллагчид
			Дотоод борлуулалт	Гадаад борлуулалт	
2012	3 103 864.5	3 546 631.1	1 706 193.9	1 840 437.2	34 867
2013	5 127 369.6	4 283 816.9	2 023 004.4	2 260 812.5	45 355
2014	6 104 575.0	8 038 445.0	2 539 561.4	5 498 883.6	42 362
2015	5 987 315.5	7 203 894.3	2 632 000.9	4 571 893.6	40 660
2016	6 927 222.0	7 692 580.9	3 460 176.5	4 232 404.4	41 096

Хүснэгт 119. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, өссөн дүн, сая төгрөг

Үзүүлэлт	Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт				
	2012	2013	2014	2015	2016
Нийт дүн	3 546 631.1	4 283 816.9	8 038 445.0	7 203 894.3	7 692 580.9
Уул уурхай олборлох үйлдвэр	1 489 403.7	2 053 789.9	5 472 188.9	5 034 789.9	5 128 743.5
Нүүрс олборлолт	523 319.1	318 261.9	271 876.8	244 315.8	496 325.4
Газрын тос, шатдаг хий олборлолт	456 283.9	776 149.8	1 153 813.6	784 395.2	732 108.5
Төмрийн хүдэр олборлолт	489 839.4	905 112.1	3 985 949.1	3 953 878.4	3 838 905.5
Бусад ашигт малтмал олборлолт	19 961.3	54 266.1	60 549.4	52 200.5	61 404.1
Боловсруулах үйлдвэр	1 654 530.0	1 764 494.7	2 007 573.4	1 486 177.6	1 787 555.2
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	657 694.7	718 139.0	902 283.6	870 379.2	951 188.0
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	59 191.3	90 460.4	144 072.7	110 565.5	83 976.1
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	38 570.4	42 694.0	51 346.6	49 659.5	68 087.1
Үр тарианы гурил, малын тэжээл	52 410.3	80 422.4	139 905.8	132 509.1	143 235.3
Хүнсний бусад бүтээгдэхүүн	60 280.5	77 422.9	95 585.9	97 024.3	107 438.6
Ундаа үйлдвэрлэл	447 242.2	427 139.3	471 372.6	480 620.8	548 450.9
Тамхи үйлдвэрлэл	45 211.7	66 445.9	77 466.5	68 683.0	75 656.7
Нэхмэлийн үйлдвэрлэл	146 546.2	197 400.0	266 089.2	235 529.5	360 717.5
Хувцас үйлдвэрлэл	6 989.9	11 400.3	8 847.0	8 667.2	10 853.0
Арьс шир боловсруулах үйлдвэрлэл	7 343.1	6 383.4	11 252.5	18 579.8	12 524.5
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	9 987.2	8 957.8	3 231.4	2 878.2	8 777.5
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	11 750.4	9 882.5	8 773.1	8 331.8	8 815.1
Хэвлэл болон дүү бичлэгийн үйл ажиллагаа	27 643.8	26 853.7	25 546.5	27 499.3	29 380.7
Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш	567 369.9	524 012.3	551 995.1	119 352.0	200 813.2
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	54 525.1	50 924.2	44 695.3	45 224.5	53 315.7
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	12 986.4	11 849.8	41 740.8	36 964.8	21 495.5
Төмөрлөг бүс эдлэлийн үйлдвэрлэл	69 033.2	98 088.7	35 816.5	23 865.2	36 020.9
Төмрийн үйлдвэрлэл	23 334.0	4 098.8	96.1	0.0	2 184.9
Машин, төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	1 026.9	17 445.5	17 126.0	7 178.4	4 859.9
Машин тоног төхөөрөмж үйлдвэрлэл	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бичиг хэрэг, тооцоолох техник үйлдвэрлэл	3 841.5	3 152.3	995.0	318.8	106.2
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	2 327.3	203.0	135.3	0.0	0.0
Эмнэлгийн багаж, хэмжүүр үйлдвэрлэл	176.5	128.1	508.0	1 075.7	1 108.7
Тээврийн бусад үйлдвэрлэл	3 498.6	2 880.9	2 653.0	2 799.6	2 865.4
Мебель болон бусад үйлдвэрлэл	3 243.6	6 248.5	8 322.5	8 850.6	6 871.8
Цахилгаан, дулаан, усан хангамж	402 697.4	465 532.3	558 682.7	682 926.8	776 282.2
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэлт	376 150.7	438 185.2	523 527.8	638 683.8	731 773.1
Ус ариутгал, усан хангамж	26 546.7	27 347.1	35 154.9	44 243.0	44 509.1



ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТО МАШИН

Техникийн хяналтын улсын үзлэгийн дүнд үндэслэн тооцоход сүүлийн 5 жилд нийслэлийн автомашины жилийн дундаж өсөлт 10.1 хувьтай байна. Тухайн жилийн өсөлтөөр нь авч үзвэл 2012 онд 9.1, 2013 онд 12.5, 2014 онд 15.3 хувьтай байсан өсөлт 2015 онд 11.6 хувьд хүрч буурч байв. 2016 онд нийслэлийн автомашины жилийн дундаж өсөлт 2.4 хувь болж, өмнөх оноос 9.2 пунктээр буурсан байна.

Хүснэгт 120. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашины тоо

Дүүрэг	2012	2013	2014	2015	2016	Үүнээс: үндсэн төрлөөр			
						суудлын	ачааны	автобус	тусгай
Нийслэлийн дүн	228 952	257 498	297 008	331 564	339 626	262 341	61 452	9 951	5 882
Багануур	1 670	1 622	2 314	2 436	2 688	1 952	585	120	31
Багахангай	275	290	435	435	548	409	112	22	5
Баянгол	48 913	57 291	63 918	65 522	67 658	52 488	12 024	1 848	1 298
Баянзүрх	56 394	64 655	77 148	87 240	91 023	70 952	16 204	2 337	1 530
Налайх	2 082	1 946	2 419	3 073	3 184	2 264	805	95	20
Сонгинохайрхан	40 402	45 198	51 477	56 065	56 851	43 185	11 097	1 858	711
Сүхбаатар	33 340	35 815	39 780	47 746	46 906	36 025	8 285	1 551	1 045
Хан-Уул	20 698	22 208	27 036	32 344	34 444	26 838	5 702	1 162	742
Чингэлтэй	25 178	28 473	32 481	36 703	36 324	28 228	6 638	958	500

2016 оны техникийн хяналтын үзлэгт нийслэлийн дүнгээр нийтдээ 339.6 мянган автомашин хамрагдсан нь бүртгэлтэй нийт автомашины 74.0 хувийг эзэлж байна. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт автомашины 77.2 хувийг суудлын автомашин эзэлж байгаа бол 18.1 хувь нь ачааны, 3.0 хувь нь автобус, 1.7 хувь нь тусгай зориулалтын автомашин байна.

Хүснэгт 121. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан амины автомашины тоо

Дүүрэг	2012	2013	2014	2015	2016	Үүнээс: үндсэн төрлөөр			
						суудлын	ачааны	автобус	тусгай
Нийслэлийн дүн	177 522	203 573	238 183	265 352	275 084	224 640	43 561	5 359	1 524
Багануур	1 430	1 365	2 026	2 068	2 293	1 723	499	61	10
Багахангай	248	249	382	376	472	352	105	12	3
Баянгол	39 228	46 413	52 305	53 116	55 137	46 083	7 858	885	311
Баянзүрх	42 973	51 340	61 793	69 667	74 032	60 175	12 168	1 345	344
Налайх	1 971	1 855	2 334	2 916	3 066	2 195	775	85	11
Сонгинохайрхан	36 643	40 853	47 065	51 366	52 491	41 354	9 393	1 370	374
Сүхбаатар	20 307	22 576	25 686	30 711	30 962	25 955	4 374	499	134
Хан-Уул	15 224	16 526	20 910	25 451	27 316	23 128	3 469	518	201
Чингэлтэй	19 498	22 396	25 682	29 681	29 315	23 675	4 920	584	136


Хувь хүмүүс, иргэдийн эзэмшилд бүртгэлтэй амины автомашины тоо 275.1 мянгад хүрсэн бөгөөд үзлэгт хамрагдсан нийт автомашины 81.0 хувийг эзэлж байна. Амины нийт автомашины 1060 нь нийслэл хотод ажиллаж, амьдарч байгаа гадаадын харьяат иргэдийн эзэмшлийнх ажээ.

Хүснэгт 122. Автомашины тоо, өмчлөлийн хэлбэрээр, 2016 он

Үзүүлэлт		Бүгд	Үүнээс: үндсэн төрлөөр			
			суудлын	ачааны	автобус	тусгай зориулалт
Нийслэлийн дүн		339 626	262 341	61 452	9 951	5 882
Аж ахуйн нэгжийн автомашин	төрийн болон орон нутгийн өмчийн	3 839	2 124	546	778	391
	дипломат, олон улсын байгууллагын	518	437	31	44	6
	төрийн бус байгууллагын	3 342	1 617	1 284	185	256
	компани, хоршоо, нөхөрлөлийн	56 843	33 523	16 030	3 585	3 705
Амины автомашин		275 084	224 640	43 561	5 359	1 524
Үүнээс: гадаадын иргэдийн		1 060	943	88	27	2

2016 оны техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийслэлийн нийт автомашины 19.0 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд байгаагийн 1.1 хувийг төрийн болон орон нутгийн өмчийн, 0.2 хувийг дипломат болон олон улсын байгууллагын, 1.0 хувийг төрийн бус байгууллагын, 16.7 хувийг компани, хоршоо, нөхөрлөлийн автомашин тус тус эзэлж байна.

Зураг 71. Суудлын автомашин, маркаар, 2016 он



Нийслэлийн авто замын хөдөлгөөнд идэвхтэй оролцож буй суудлын нийт автомашины тоог маркаар нь ангилж, зурагт харуулав. Эндээс үзвэл хамгийн олон буюу 164.3 мянга орчим нь “Toyota” маркийн автомашин байна. Удаад нь “Hyundai” (28.5 мянга), гуравт “Nissan” (18.2 мянга), дөрөвт “Honda” (8.9 мянга), тавд “Mitsubishi” (7.5 мянга) маркийн автомашин багтжээ.

Улмаар эхний аравд Lexus, Subaru, Mercedes-Benz, Kia, Suzuki маркийн автомашинууд орж, эдгээр нь “бусад” гэсэн ангилалд оруулсан 34.9 мянга гаруй автомашины 51.7 хувийг эзэлж байв.

Хүснэгт 123. Автомашины тоо, ашиглалтын хугацаа, дүүргээр

Дүүрэг	Бүгд	2015			Бүгд	2016		
		0 - 3 жил	4 - 9 жил	10-аас дээш		0 - 3 жил	4 - 9 жил	10-аас дээш
Нийслэлийн дүн	331 564	12 306	78 560	240 698	339 626	9 104	74 891	255 631
Багануур	2 436	30	318	2 088	2 688	28	348	2 312
Багахангай	435	10	48	377	548	3	110	435
Баянгол	65 522	2 397	17 356	45 769	67 658	1 576	16 844	49 238
Баянзүрх	87 240	2 526	20 124	64 590	91 023	1 708	19 386	69 929
Налайх	3 073	31	339	2 703	3 184	27	339	2 818
Сонгинохайрхан	56 065	778	10 619	44 668	56 851	513	9 803	46 535
Сүхбаатар	47 746	2 804	13 090	31 852	46 906	2 213	12 035	32 658
Хан-Уул	32 344	2 587	8 530	21 227	34 444	2 336	8 986	23 122
Чингэлтэй	36 703	1 143	8 136	27 424	36 324	700	7 040	28 584

Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийслэлийн харьяалал бүхий нийт автомашины ихэнх буюу 75.3 хувийг арав ба түүнээс дээш жилээр ашиглаж, хуучирсан тээврийн хэрэгслүүд эзэлж байна. Энэ ангилалд харьяалагдаж буй 255.6 мянган автомашины 64.8 хувь нь нийслэлийн Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүрэгт ногдож байгаагийн дотор 27.4 хувь буюу хамгийн олон нь Баянзүрх дүүрэгт байна.


Үйлдвэрлэж гарсан хугацаанаас хойш 0-3 жил ашиглаж байгаа шинэ автомашины нийслэлийн нийт автомашины дүнд эзлэх хувийн жин 2.7 байгаа нь өмнөх оноос 1.0 пунктээр буурсан байна. Уг ангилалд бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн дийлэнх буюу 86.0 хувь нь нийслэлийн Хан-Уул (25.7%), Сүхбаатар (24.3%), Баянзүрх (18.8%), Баянгол (17.3%) дүүрэгт тус тус бүртгэлтэй байна.

Хүснэгт 124. Автомашины тоо, хөдөлгүүрийн шатахууны төрлөөр

Үзүүлэлт	Үүнээс: автомашины үндсэн төрлөөр									
	Бүгд		суудлын		ачааны		автобус		тусгай зориулалт	
	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
Нийт дүн	331 564	339 626	252 582	262 341	61 783	61 452	11 516	9 951	5 683	5 882
Бензин	172 429	164 168	165 755	157 990	4 519	4 258	1 704	1 487	451	433
Дизель	89 322	88 945	17 961	18 259	56 555	56 887	9 618	8 373	5 188	5 426
Хосолсон	57 439	74 532	57 256	74 437	100	40	79	53	4	2
Газ	12 374	11 981	11 610	11 655	609	267	115	38	40	21


Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийслэлийн 339.6 мянган автомашиныг хөдөлгүүрийнх нь шатахууны төрлөөр ангилж үзэхэд 48.3 хувийг нь “бензин хөдөлгүүр”-тэй автомашин эзэлж, энэ төрлийн автомашины тоо 2015 оноос 4.8 хувиар цөөрчээ. Газ болон хосолсон хөдөлгүүртэй автомашины тоо нэмэгдэх төлөв хандлага сүүлийн жилүүдэд ажиглагдах болсон. 2016 онд дизель хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн эзлэх хувийн жин 26.2 болж, өмнөх онтой харьцуулахад 0.7 пунктээр доогуур байна.

Зураг 72. Автомашины тоо, хөдөлгүүрийн багтаамжаар, 2016 он



Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийслэлийн 339.6 мянган автомашиныг хөдөлгүүрийнх нь багтаамжаар авч үзэхэд 36.9 хувь нь 1500 см³ хүртэл багтаамжтай автомашин зонхилж, тус ангилалд бүртгэлтэй байгаа нийт автомашины 77.9 хувь нь 2016 оны техникийн хяналтын үзлэгт хамрагдсан бол 36.7 хувийг нь 1501-2500 см³ багтаамж бүхий хөдөлгүүртэй автомашин эзэлж байв. Тус ангилалд бүртгэлтэй нийт автомашины 75.9 хувь нь техникийн хяналтын үзлэгт хамрагджээ.

Зураг 73. Автомашины тоо, хүрдний байрлалаар, 2016 он



Жолооны хүрд нь баруун талдаа буюу “буруу талдаа” байрлалтай 209.3 мянга гаруй автомашин техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нь нийт автомашины 61.6 хувийг эзлэх болж, өмнөх оноос 9.7 мянган автомашинаар цөөрсөн байна. Эдгээрийн дийлэнх буюу 95.0 хувийг “суудлын автомашин” дангаараа эзэлж байгаа юм.

Суудлын нийт автомашины 75.8 хувь нь баруун талдаа, 24.2 хувь нь зүүн талдаа хүрдний байрлалтай байна.


Зүүн талдаа буюу бидний хэлж заншснаар “зөв талдаа” хүрдний байрлалтай автомашинуудын хувьд суудлын автомашинаас бусад төрлийн тээврийн хэрэгслийн тоо хэмжээ баруун талдаа хүрдний байрлалтай тээврийн хэрэгслээс илүү олон байгаа юм. Тухайлбал, ачааны нийт автомашины 84.8 хувь, автобусны 93.3 хувь, тусгай зориулалтын автомашины 91.4 хувь нь зөв талдаа байрласан жолооны хүрдтэй байна. Өөрөөр хэлбэл, замын хөдөлгөөний дүрэмдээ баруун гарын дүрэм (зөв талдаа буюу жолооны хүрд нь зүүн талдаа байрлалтай тээврийн хэрэгсэл ашиглах) баримталдаг манай улс, нийслэлийн хувьд энэ нь эерэг үзүүлэлт юм.

Зураг 74. Автомашины тоо, марк үүсгэсэн улс, хувиар

2016 оны техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийслэлийн нийт автомашиныг марк үүсгэсэн улс орноор нь ангилж үзэхэд Япон болон БНСУ-д тухайн автомашины марк үүсгэгдсэн 310.9 мянга орчим тээврийн хэрэгсэл байгаа нь нийт автомашины дийлэнх олонх буюу 91.6 хувийг эзэлжээ.

Хятад (11.8 мянга), Герман (5.8 мянга), ОХУ (4.7 мянга) улсад марк нь үүсгэгдсэн тээврийн хэрэгслүүд эхний тавд орсон нь нийт автомашины 6.6 хувьтай тэнцэж байна.

Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт автомашины 1.2 хувийг эзэлж буй 4165 тээврийн хэрэгслийн марк үүсгэсэн улс нь Америкийн Нэгдсэн Улс бөгөөд жагсаалтын зургаад орж байна.



Хүснэгт 125. Авто тээврийн үндсэн үзүүлэлт

Он	Тээсэн ачаа (мянган тонн)		Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь	Тээвэрлэсэн зорчигч (сая хүн)		Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь
	Монгол Улсад	Нийслэл хотод		Монгол Улсад	Нийслэл хотод	
2016	20 406.2	1 347.9	6.6	260.7	244.3	93.7
2015	16 682.2	1 628.7	9.8	256.5	238.3	92.9
2014	23 514.2	2 914.0	12.4	340.1	284.9	83.8
2013	21 321.9	2 582.2	12.1	303.4	262.8	86.6
2012	30 195.1	3 211.4	10.6	313.2	236.0	75.4

2016 онд авто тээврээр улсын хэмжээнд тээвэрлэсэн нийт зорчигчдын 93.7 хувь, тээсэн нийт ачааны 6.6 хувь нь нийслэл хотод тус тус ногдож байна. Тээсэн ачааны улсын дүнд нийслэлийн эзлэх хувь өмнөх оноос 3.2 пунктээр буурав. Харин авто тээврээр тээвэрлэсэн зорчигчийн улсын дүнд нийслэлийн эзлэх хувийн жин өмнөх оноос 0.8 пунктээр өссөн нь сүүлийн таван жилд гарч буй хамгийн өндөр үзүүлэлт юм.




НИЙТИЙН ТЭЭВЭР

2016 онд Нийслэлийн Тээврийн газраас Улаанбаатар хотын дотор болон хот орчимд 3.9 мянган км урттай, 137 чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулжээ.

Нийтийн тээврийн үйлчилгээнд хөлс төлөлтийг цахим системд шилжүүлж, хотын гудамж, замын хөдөлгөөний ачаалал, түгжрэлийг бууруулах, чиглэлүүдийн давхцыг арилгах зорилгоор нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээний шинэчилсэн төлөвлөлтийг хэрэгжүүлж байна.

Зураг 75. Зорчигч тээврийн чиглэлийн тоо



Зураг 76. Зорчигч тээврийн чиглэлийн урт



Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний голлох ачааллыг их багтаамжийн автобусаар хүргэж байна. Тухайлбал, “үндсэн чиглэл”-ийн 27.8 хувь нь төрийн өмчийн, 66.7 хувь нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд ногдож байна. Харин хот орчмын чиглэлд угсраа автобус болон цахилгаан тээврээр хүргэдэг үйлчилгээнээс бусад чиглэлийн үйлчилгээг үзүүлж байна.


Хүснэгт 126. Үйлчилгээний чиглэлийн тоо, өмчийн хэлбэрээр

Үзүүлэлт		Үндсэн чиглэл		Хот орчмын чиглэл		Нийт	
		2015	2016	2015	2016	2015	2016
Төрийн өмчийн	их багтаамжийн автобус	19	20	2	2	21	22
	угсраа автобус	1	1	-	-	1	1
	дунд багтаамжийн автобус	-	-	7	7	7	7
	троллейбус	2	2	-	-	2	2
Хувийн хэвшлийн	их багтаамжийн автобус	45	48	4	4	49	52
	бага багтаамжийн автобус	-	-	2	1	2	1
	троллейбус	1	1	-	-	1	1
Бүгд		68	72	15	14	83	86

2016 онд Улаанбаатар хотын хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээг 41 аж ахуйн нэгж эрхлэн явуулсан нь өмнөх оноос 12 аж ахуйн нэгжээр цөөрсөн байна. Тухайлбал, их багтаамжийн автобусаар үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын тоо 5.3 хувиар, бага, дунд багтаамжийн автобусаар үйлчлэгч аж ахуйн нэгжийн тоо 40 хувиар, такси үйлчилгээ эрхлэгчдийн тоо 29.4 хувиар буурчээ.

Нийслэлийн зорчигч тээврийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгжийн дийлэнх хэсгийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд эзэлсэн хэвээр байна.

Зураг 77. Зорчигч тээврийн аж ахуйн нэгжийн тоо, 2016 он



Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүд 2016 онд 830.6 сая хүн километрийн ажил үйлчилгээг гүйцэтгэн, давхардсан тоогоор нийтдээ 244.3 сая хүн тээвэрлэж, 76.4 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Зорчигчдын тоо өмнөх оноос 6.0 сая хүнээр (2.5%) өсч, харин үйлчилгээний орлого 13.4 тэрбум төгрөгөөр (14.9%) бүүрчээ. Энэ нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна.

Үүнд:


- Хөлс төлөлтийн цахим хэлбэрт шилжиж, зорчих тасалбар таслахгүйгээр кондукторгүй үйлчилгээг нэвтрүүлснээр зорчигчдын хөлс төлөлтөнд тавих хяналт суларсан.
- Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг нийслэлийн төсвөөс олгох болсноор үйлчилгээ эрхлэгчдийн хувьд шугамын орлогыг нэмэгдүүлэх, зорчигчдыг суулгах сонирхол буурч, үр ашиг багатай зорчилт хийх болсон.
- Чиглэл маршрутын шинэчилсэн төлөвлөлтийн хүрээнд зүүн гарын эргэлт болон чиглэлийн давхцалыг бууруулах үүднээс зарим чиглэлийг богино эргэлтээр эргүүлэх болж, мөн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор шаардлагатай хэсгийн хүн урсгалын төвлөрөл, цэгүүдэд зогсоол буудлыг шийдэж өгөөгүйгээс иргэдийн нийтийн тээврийн үйлчилгээгээр зорчих эрэлтийг бүрэн дүүрэн хангаж чадахгүй байгаа нь зорчигч үйлчилгээний орлого буурахад голлон нөлөөлжээ.

Хүснэгт 127. Нийтийн тээврийн үйлчилгээ, төлбөрийн хэлбэрээр, 2016 он

Тээврийн хэрэгсэл, төрөл, өмчлөлөөр	Аж ахуйн нэгж (тоо)	Орлого (тэрбум төгрөг)				Зорчигч (сая хүн)	Төлбөр (төгрөг)			
		карт	бэлэн мөнгө	нөхөн олго-вор	нөхөн олго-вор		карт	бэлэн мөнгө	нөхөн олго-вор	нөхөн олго-вор
Зорчигч тээврийн нэгтгэл (ОНӨААТУГ)	1	29.0	5.6	12.5	10.9	90.2	30.0	32.8	27.4	
Автобус (хувийн)	18	43.5	10.5	16.9	16.1	143.4	60.2	42.8	40.4	
Троллейбус (хувийн)	1	2.6	0.09	0.16	2.4	7.1	0.54	0.60	5.94	
Бага багтаамжийн автобус	9	1.3	-	1.3	-	3.6	-	3.6	-	
Дүн	29	76.4	16.1	30.8	29.5	244.3	90.8	79.8	73.7	


Төлбөрийн цахим хэлбэрт шилжиж байгаатай холбогдуулан Нийслэлийн Тээврийн газар нь UB смарт ХХК-тай хамтарсан гэрээ байгуулан ажиллаж, троллейбус, их, дунд багтаамжийн нийт 1200 орчим тээврийн хэрэгсэлд карт унших төхөөрөмжийг суурилуулан, картаар зорчих нөхцлийг бүрдүүлэн ажилласан байна.

Зураг 78. Үндсэн үзүүлэлт, тээврийн төрлөөр



Нийтийн тээврийн үйлчилгээний үндсэн үзүүлэлт болох тээсэн зорчигч, үйлчилгээний орлогын зонхилох хэсэг нь их, дунд багтаамжийн автобусны үйлчилгээнд ногдож байна. Тухайлбал, 2016 онд нийт зорчигчдын 89.8 хувь нь их, дунд багтаамжийн автобусаар зорчиж, үйлчилгээний нийт орлогын 89.0 хувийг бүрдүүлжээ. Цахилгаан тээврийн хувьд зорчигчдын 8.8 хувь, тээврийн орлогын 9.3 хувь нь тус тус ногдож байна.

Зураг 79. Зорчигчдын тоо, сая хүн, хөлс төлөлтийн хэлбэр, хувиар




2016 онд бүрдүүлсэн үйлчилгээний нийт орлогын 21.1 хувийг картын орлого, 40.3 хувийг бэлэн мөнгө, 38.6 хувийг "нөхөн олговор"-ын орлого эзэлж байна. Нийтийн тээврээр зорчсон гурван хүн тутмын нэгээс илүү нь буюу 37.2 хувь нь картаар үйлчлүүлсэн байхад 32.6 хувь нь бэлэн мөнгө төлж, 30.2 хувь нь нөхөн олговрын хөнгөлөлтөөр зорчжээ. Төлбөрийн цахим хэлбэр болох карт ашиглан зорчигчдын тоо нэмэгдэх хандлагатай болж давхардсан тоогоор 90.8 саяд хүрсэн бол 79.8 сая хүн бэлэн мөнгө төлж зорчжээ.


2016 онд нийтийн тээврийн хэрэгслээр давхардсан тоогоор 73.7 сая зорчигч үнэ төлбөргүй үйлчлүүлж, эдгээр хүмүүсийн үйлчилгээний төлбөрт төрөөс 29.5 тэрбум төгрөгийг тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд нөхөн олговор хэлбэрээр шилжүүлсэн байна. Нөхөн олговрын хөнгөлөлт эдэлж, нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон арван хүн тутмын нэг нь "хөгжлийн бэрхшээлтэй иргэд" байгаа бол 53.0 хувийг оюутнууд, 37.0 хувийг нь ахмад настууд эзэлж байна.

Түүнчлэн “бэлэн мөнгө төлж” зорчсон зорчигчдын 63.8 мянга (80%) нь насанд хүрэгчид, тавны нэг нь хүүхдүүд байна. Мөн цахим “карт”-аар зорчигчдын дийлэнхийг насанд хүрэгчид эзэлж байгаа бол 20.0 хувь нь хүүхдүүд байна.

Зураг 80. Зорчигчдын тоо, сая хүн, тээврийн хэрэгслийн төрлөөр



Зураг 81. Үйлчилгээний орлого, тэрбум төгрөг, тээврийн хэрэгслийн төрлөөр



Хүснэгт 128. Нийтийн тээврийн хөдлөх бүрэлдэхүүн

Үзүүлэлт		2015	2016
Бүгд		2 314	1 830
Их багтаамжийн автобус	төрийн өмч	320	312
	хувийн өмч	993	891
Бага, дунд багтаамжийн автобус (хувийн)	туслах чиглэл	153	29
	бүүхиа чиглэл	199	13
Троллейбус	төрийн	48	48
	хувийн	8	8
Такси		593	529


2016 онд нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ нь зориулалтын 1830 хөдлөх бүрэлдэхүүнтэй ажилласан байна. Эдгээрийн 65.7 хувь нь их багтаамжийн автобус, 2.3 хувь нь бага, дунд багтаамжийн автобус, 28.9 хувь нь такси байна.

2016 оны түрш өдөрт дунджаар их, дунд багтаамжийн 805 автобус, 16 угсраа автобус, 33 троллейбус, бага багтаамжийн 246 автобус, 529 такси ажиллажээ. Шугаманд өдөрт ажилласан нийт тээврийн хэрэгслийн 80.3 хувийг хувийн хэвшлийн тээврийн хэрэгсэл эзэлж байна.


2016 онд нийтийн тээврийн парк шинэчлэлтээр их багтаамжийн 136 автобус, дунд багтаамжийн 2 автобус, 120 такси үйлчилгээнд шинээр нэмэгдэж, стандартын шаардлага хангахгүй болж 12-оос дээш жилээр ашиглагдаж хуучирсан 699 тээврийн хэрэгсэл (их багтаамжийн хувийн 161 автобус, бага багтаамжийн 276 автобус, 262 такси) үйлчилгээнээс хасагдсан байна.

Зогсоолд ирэх автобус хоорондын зай буюу нийтийн тээврийн хүлээлтийн дундаж хугацаанд зарим өөрчлөлтүүд гарч, өмнөх онтой харьцуулахад цахилгаан тээврийнх 0.7 минутаар, их багтаамжийн автобусных 1.7 минутаар, угсраа автобусных 0.9 минутаар тус тус нэмэгдэж, бага багтаамжийн автобусны хүлээлтийн хугацаа 29.0 хувиар буурсан байна. Мөн хот орчмын үйлчилгээний дунд багтаамжийн автобусны хүлээлтийн хугацаа эрс буурч, 72 минутаас 35.8 минут болжээ.

Зураг 82. Өдөрт ажилласан тээврийн хэрэгсэл, тоо



Зураг 83. Хүлээлтийн хугацаа, минут



Нийслэлийн Тээврийн газраас аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан “Нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгүүлэх тухай гэрээ”-гээр насанд хүрэгчид их, дунд багтаамжийн автобусаар 500 төгрөг, цахилгаан тээврээр 300 төгрөг, туслах болон бүүхиа чиглэлийн бага багтаамжийн автобусаар 500-1300 төгрөг, хот орчмын чиглэлийн бүх төрлийн автобусаар 500-2300 төгрөгөөр (хүүхэд 200-1200 төгрөг) зорчиж байна. Мөн тус гэрээнд таксины үйлчилгээний нэг төлбөрт километрийн тарифыг 1000 төгрөгөөр тогтоож, үйлчилгээнд мөрдүүлэхээр заажээ.


Хүснэгт 129. Автобусны буудлын тоо, төвийн 6 дүүргээр

Дүүрэг	2014			2015			2016		
	Бүгд	эцсийн буудал	завсрын буудал	Бүгд	эцсийн буудал	завсрын буудал	Бүгд	эцсийн буудал	завсрын буудал
Хан-Уул	59	9	50	59	9	50	59	9	50
Баянзүрх	190	19	171	190	19	171	189	19	170
Баянгол	76	3	73	76	3	73	76	3	73
Сүхбаатар	119	5	114	130	7	123	120	5	115
Чингэлтэй	72	7	65	103	6	97	72	6	66
Сонгинохайрхан	195	25	170	195	25	170	195	25	170
Нийт	711	68	643	753	69	684	711	67	644


Нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд 2016 онд нийтдээ 711 автобусны буудал, зогсоол ажиллажээ. Нийт буудал, зогсоолын 9.4 хувийг “эцсийн”, 90.6 хувийг “завсрын буудал” эзэлж байна. Нийслэлд ажиллаж буй автобусны дөрвөн буудал, зогсоол тутмын нэгээс илүү буюу хамгийн олонх нь нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байршиж байна. Мөн автобусны арван буудал тутмын нэг нь Баянгол, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт тус тус байрлаж, хамгийн цөөн буюу 59 буудал Хан-Уул дүүрэгт байрладаг байна.

2016 онд нийслэлийн зорчигч тээврийн үйлчилгээний талаар иргэдээс дараах төрлийн нийт 2012 санал, гомдол Нийслэлийн Тээврийн газарт ирүүлсний 90.8 хувийг нь шийдвэрлэж, барагдуулсан байна.

Зураг 84. Үйлчилгээний талаар ирүүлсэн санал гомдлын шийдвэрлэлт



Зураг 85. Нийтийн тээврийн үйлчилгээний талаарх санал, гомдол





ХАРИЛЦАА ХОЛБОО


Шуудан, харилцаа холбоо, интернэтийн үйлчилгээний орлого 2016 онд 763.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 54.2 тэрбум төгрөгөөр (7.6%) өсчээ. Нийт орлогын 556.1 тэрбум орчим төгрөгийг (72.8%) нийслэлийн хүн амд үзүүлсэн үйлчилгээнээс бүрдүүлсэн байна.

Хүснэгт 130. Харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлт


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2012	2013	2014	2015	2016
Үйлчилгээний нийт орлого	сая төгрөг	551 544.0	619 126.4	725 995.8	709 373.3	763 602.9
Үүнээс: хүн амаас орсон	сая төгрөг	434 706.8	462 850.1	526 130.1	531 487.7	556 086.6
Суурин утасны цэг	тоо	116 276	175 496	193 590	232 327	263 465
Үүнээс: айл өрхийн	тоо	80 431	122 965	162 134	196 516	215 703
Утасгүй телефон	тоо	31 254	3 593	890	545	538
Үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчид (давхардсан тоогоор)	мянган хүн	2 060.8	1 745.5	1 772.2	1 967.3	1 753.2
Кабелийн телевиз хэрэглэгчид	тоо	192 227	234 456	302 439	323 344	355 724

2016 онд нийслэлийн хэмжээнд суурин телефон цэгийн тоо 263.5 мянга болж, өмнөх онтой харьцуулахад 13.4 хувиар өссөн байна. Нийт суурин телефон цэгийн 215.7 мянга (81.9%) нь айл өрхийн эзэмшилд байна. Өрхийн суурин телефон цэгийн тоо 2015 оноос 9.8 хувиар өссөн нь гурвалсан үйлчилгээний суурин утасны үйлчилгээг хэрэглэгч өрхийн тоо нийслэлд өсөн нэмэгдэж байгаатай холбоотой.

Зураг 86. Суурин телефон цэгийн тоо



Зураг 87. Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо



2016 онд Монгол Улсын хэмжээнд давхардсан тоогоор нийт 3.3 сая хүн үүрэн утас идэвхтэй хэрэглэж байгаагийн 1.7 сая (52.0%) хэрэглэгчид нь нийслэлийн оршин суугчид байна. Өмнөх онтой харьцуулахад үүрэн телефон хэрэглэгчдийн тоо нийслэлд 214.1 мянгаар буурсан үзүүлэлттэй байна.

Үүрэн холбооны нийт хэрэглэгчдийн 325.4 мянга нь дараа төлбөрт үйлчилгээний, 1427.7 мянга нь урьдчилсан төлбөрт үйлчилгээний хэрэглэгчид байна. 2016 онд хөдөлгөөнт утасгүй телефон буюу WLL үйлчилгээний хэрэглэгчдийн тоо 0.5 мянга, сансарын холбооны хэрэглэгч 0.7 мянга байв.

Өргөн нэвтрүүлгийн шугамаар Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, “Лавайн эгшиг” радио сүлжээ, “Шинэ Монгол” радио орон даяар нэвтрүүлгээ цацаж байгаагийн зэрэгцээ МҮОНР-гийн 2-р суваг Алтан сан радио 2016 онд үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ хүргэдэг болсноор тус ангиллын радио 4 болж нэмэгдсэн байна. Мөн түүнчлэн бүсийн хэмжээнд буюу Улаанбаатар хотод төдийгүй зарим аймгийн төвүүдэд нэвтрүүлгээ хүргэдэг 3 радио нийслэлд үйл ажиллагаа явуулж байв¹⁰.

2016 онд Улаанбаатар хотын хэмжээнд нэвтрүүлгээ цацдаг 3 радио шинээр нэмэгдсэн ч 5 радио үйл ажиллагаагаа зогсоосноор 23 радиотой болсон байна. Эдгээрээс 13 радиог онлайнгаар шууд, 8 радиог ухаалаг утасны аппликейшн ашиглан сонсох боломжтой ажээ.

Радиогийн долоо хоногийн нэвтрүүлгийн дундаж цаг Улаанбаатарт 151 болж өмнөх оноос 38 цагаар нэмэгдсэн байна. Энэ нь 24 цагаар эфирээ цацдаг радиогийн тоо нэмэгдсэнтэй холбоотой юм. Улаанбаатар хотын хэмжээнд нэвтрүүлгээ цацаж буй нийт радиогийн 17 нь хувийн, 1 нь олон нийтийн статустай, 5 нь бусад болон төрийн бус байгууллагын харьяалал дор үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийн судалгааны дүнгээс үзэхэд нийслэлийн иргэдийн 15.0 хувь нь “өдөр бүр радио сонсдог” бол 56.0 хувь огт сонсдоггүй байна. Нийслэлийн иргэд ихэвчлэн тээврийн хэрэгслээр зорчиж байхдаа радиог сонсдог бөгөөд өдөрт радио сонсоход зарцуулдаг цаг нь орон нутгийн иргэдийнхээс харьцангуй бага хугацаа гарчээ.

Хүснэгт 131. Радиогийн үндсэн үзүүлэлт

Он	Радио станцын тоо		7 хоногийн нэвтрүүлгийн нийт цаг	Үүнээс:		
				МҮОН-ийн радио	Улаанбаатар радио	FM радио
2016	30	23	4 503	126	-	3 486
2015	31	28	4 312	119	-	3 913
2014	29	26	4 088	119	-	3 689
2013	29	26	4 154	119	-	3 776
2012	29	25	4 312	119	28	3 955

Хүснэгт 132. Телевизийн үндсэн үзүүлэлт

Он	Телевизийн тоо, нэвтрүүлэг цацдаг хүрээгээр			7 хоногийн нэвтрүүлгийн дундаж цаг
	Улсын хэмжээнд	Улаанбаатарын хэмжээнд		
		телевиз	суваг	
2016	16	31	15	125.0
2015	16	37	17	118.0
2014	16	36	18	121.5
2013	16	37	18	125.0
2012	15	25	14	117.9

2016 онд Улаанбаатар хотын хэмжээнд нэвтрүүлгээ цацаж байсан 3а, NBS, PPTV зэрэг 14 телевиз үйл ажиллагаагаа зогсоож, Fashion channel суваг зөвхөн онлайнгаар нэвтрүүлгээ түгээдэг болж, Дотно, Channel 11, World, Smart HD зэрэг 7 телевиз шинээр байгуулагдсан хэдий ч телевизийн тоо 46 хүртлээ буурсан бөгөөд долоо хоногийн эфирийн дундаж цаг нь 125 болж, өмнөх оноос 7 цагаар нэмэгдсэн байна.

Радио давтамж болон DDish тавган антен ашиглан 16 телевиз эфирээ үндэсний хэмжээнд цацаж байна. Үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ хүргэж буй эдгээр телевизүүдийн долоо хоногийн нэвтрүүлгийн дундаж цаг 134 болж, өмнөх оноос 6 цагаар нэмэгджээ.

¹⁰ Хэвлэлийн Хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр” судалгааны тайлан, 2017 он

Хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийн судалгааны дүнгээс үзэхэд нийслэлчүүдийн 71.0 хувь нь “өдөр бүр телевиз үздэг” ч орон нутгийн иргэдтэй харьцуулахад харьцангуй бага хугацааг зарцуулдаг байна. Хот, хөдөө орон нутаг гэсэн аль ч байршилд ялгаагүй телевиз үзэгчид ихэвчлэн мэдээ, уран сайхны киног илүүтэй үздэг байна.

2016 онд нийслэлийн нийт өрхийн 379.4 мянга (99.6%) нь телевизортой байсан бөгөөд эдгээр өрхийн 87.5 хувь нь нэг телевизортой ажээ. Телевизортой өрхийн 29.7 хувь нь сууцны тусдаа байшинд, 42.8 хувь нь нийтийн зориулалттай орон сууцанд, 27.5 хувь (104.2 мянган өрх) нь монгол гэрт амьдарч байв.


Хүснэгт 133. Нийслэлийн телевизортой өрх, дүүргээр

Дүүрэг	Телевизортой өрх, бүгд				Үүнээс:			
					Гэртээ нэг телевизортой өрх			
	2013	2014	2015	2016	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	330 778	352 076	375 830	379 429	282 917	302 797	331 360	331 904
Багануур	7 972	8 162	8 422	8 541	7 385	7 686	8 055	8 121
Багахангай	1 031	1 076	1 190	1 186	879	918	1 155	1 152
Баянгол	52 386	55 529	57 844	58 220	37 843	40 741	43 091	43 361
Баянзүрх	79 525	85 866	93 055	93 037	67 700	73 599	80 658	78 340
Налайх	9 156	9 723	10 044	10 025	8 763	9 382	9 696	9 704
Сонгинохайрхан	70 654	77 093	82 835	84 826	63 435	68 336	75 742	77 544
Сүхбаатар	36 027	36 056	37 851	38 002	30 934	31 915	34 825	34 265
Хан-Уул	35 207	39 048	43 182	45 175	31 190	34 748	39 985	41 575
Чингэлтэй	38 820	39 523	41 407	40 417	34 788	35 472	38 153	37 842

Кабелийн телевизийн хэрэглэгчдийн тоо жил бүр өсөн нэмэгдэж байна. Монгол Улсын хэмжээнд кабелийн телевизийн сувагт холбогдсон нийт хэрэглэгчдийн дийлэнх буюу 85.0 хувь нь нийслэл хотод байна. Улсын дүнд нийслэл хотын эзлэх хувийн жин 2016 онд өмнөх оноос 0.9 пунктээр өссөн байна. 2016 онд нийслэлийн хэмжээнд кабелийн 18 телевизээр 355.7 мянган хэрэглэгч үйлчлүүлсний 94.7 хувийг айл өрх эзэлж байна.

Тогтмол үйл ажиллагаа явуулсан кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдээс 16 нь нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж, хоногт дундажаар 60-140 гаруй сувгаар (хотын захын дүүрэгт 50-70 хүртэл) нэвтрүүлэг хүргэсэн байна.

Зураг 88. КаТВ-ийн сувагт холбогдсон хэрэглэгчид



Хүснэгт 134. Кабелийн телевиз хэрэглэгчид

Он	Монгол Улс	Нийслэл	Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь
2016	418 397	355 724	85.0
2015	384 356	323 344	84.1
2014	360 923	302 439	83.8
2013	277 968	234 456	84.3
2012	227 045	192 227	84.7

Гурвалсан үйлчилгээнээс бусад кабелийн телевизийн сувагт холбогдох шинэ тавилтын үнэ нийслэлийн төвийн 6 дүүргийн айл өрхөд 10.0-99.0 мянган төгрөгийн хооронд байхад үйлчилгээний төлбөрийн сарын хураамж өрхөд 4000-9900 төгрөгийн тарифтай байв.


Хүснэгт 135. Компьютертэй болон интернэтэд холбогдсон өрх, дүүргээр

Дүүрэг	Компьютертэй өрх, бүгд				Үүнээс:			
					Интернэтэд холбогдсон өрх			
	2013	2014	2015	2016	2013	2014	2015	2016
Нийслэлийн дүн	156 761	172 085	185 512	191 238	94 795	111 268	133 963	144 349
Багануур	2 346	2 370	3 174	2 280	666	1 343	2 617	1 865
Багахангай	256	267	383	393	104	170	224	246
Баянгол	38 425	39 293	42 945	43 760	30 112	31 875	36 919	39 099
Баянзүрх	39 853	43 115	46 770	49 577	24 835	27 198	30 133	36 055
Налайх	2 764	3 314	3 288	3 008	1 012	2 004	2 353	1 984
Сонгинохайрхан	23 976	28 128	30 386	30 731	11 553	15 542	19 811	18 660
Сүхбаатар	19 894	21 955	19 584	20 845	13 372	15 425	15 587	16 402
Хан-Уул	14 785	19 003	24 031	25 850	6 576	11 127	19 489	20 616
Чингэлтэй	14 462	14 640	14 951	14 794	6 565	6 584	6 830	9 422

2016 онд нийслэлийн нийт өрхийн 191.2 мянга (50.2%) нь гэртээ компьютертэй байв. Эдгээр өрхийн 122.1 мянга (63.9%) нь нийтийн зориулалттай орон сууцанд, 23.6 мянга (12.3%) нь монгол гэрт амьдардаг байна.

Мөн нийслэлийн нийт өрхийн 37.9 хувь, гэртээ компьютертэй өрхийн 75.5 хувь буюу 144.3 мянга гаруй өрх интернэтэд холбогджээ. Интернэтэд холбогдсон нийт өрхийн 75.7 хувийг нийтийн зориулалттай орон сууцанд амьдардаг өрх, 16.9 хувийг сууцны тусдаа байшинд амьдардаг өрх эзэлж байна.

Зураг 89. Интернэтэд холбогдсон өрх, сууцны төрлөөр, 2016 он






ДОТООД ХУДАЛДАА


Монгол Улсын бөөний болон жижиглэн худалдааны нийт борлуулалт 2016 онд 16773.6 тэрбум төгрөгт хүрч үүнээс 13810.8 тэрбум (82.3%) төгрөг нь нийслэлд дангаараа хийгджээ. Худалдааны нийт борлуулалтын 51.6 хувийг бөөний, 48.4 хувийг жижиглэн худалдаа эзэлж байна.

Зураг 90. Худалдааны нийт борлуулалт, тэрбум төгрөг



2016 онд нийслэлд 4383 хүнсний дэлгүүр, 44 бөөний худалдааны төв, 29 зах, 757 түргэн үйлчилгээний цэгүүд жилийн турш үйл ажиллагаа явуулсан байна. Эдгээр худалдааны цэгт бөөний болон жижиглэнгийн нийт 13810.8 тэрбум төгрөгийн худалдаа хийгдсэн нь 2012 оноос 1852.2 тэрбум төгрөгөөр (15.5%), 2013 оноос 1636.0 тэрбум төгрөгөөр (13.4%) нэмэгдэж, харин 2014 оноос 775.0 тэрбум төгрөгөөр (5.3%), 2015 оноос 804.0 тэрбум төгрөгөөр (5.5%) түс түс буурсан байна.


Зураг 91. Худалдааны нэг цэгт ногдох хүний тоо, 2016 он



Хүснэгт 136. Бөөний болон жижиглэн худалдаа, тэрбум төгрөг

Үзүүлэлт		Нийт дүн	Бөөний худалдаа	Жижиглэн худалдаа
2012	Улсын дүн	13 350.0	7 668.5	5 681.5
	Нийслэлийн дүн	11 958.6	7 037.4	4 921.2
	Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь	89.6	91.8	86.6
2013	Улсын дүн	14 456.4	7 078.6	7 377.8
	Нийслэлийн дүн	12 174.8	6 895.4	5 279.4
	Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь	84.2	97.4	71.6
2014	Улсын дүн	16 980.5	7 809.7	9 170.8
	Нийслэлийн дүн	14 585.8	7 529.4	7 056.4
	Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь	85.9	96.4	76.9
2015	Улсын дүн	17 698.7	7 683.2	10 015.5
	Нийслэлийн дүн	14 614.8	7 246.4	7 368.4
	Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь	82.6	94.3	73.6
2016	Улсын дүн	16 773.6	7 820.9	8 952.7
	Нийслэлийн дүн	13 810.8	7 120.5	6 690.3
	Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь	82.3	91.0	74.7

Зураг 92. Худалдааны нийт борлуулалт, тэрбум төг




2016 онд Монгол Улсын хэмжээнд худалдааны нийт борлуулалт 16773.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт борлуулалтын 82.3 хувь нь нийслэлд, үлдсэн 17.7 хувь нь бусад аймгуудад хийгджээ.

Худалдааны салбарын нийт аж ахуйн нэгжийн 10.0 гаруй хувийнх нь жилийн борлуулалтын орлого 50 сая төгрөгөөс дээш байгаа бөгөөд эдгээр аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого худалдааны нийт борлуулалтын орлогын 90.0 гаруй хувийг эзэлж байна.

Зураг 93. Худалдааны цэг, төрлөөр, 2016 он

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулсан худалдааны нийт цэгийн 84.1 хувь нь хүнсний дэлгүүр, 14.5 хувь нь түргэн үйлчилгээний цэг, 0.8 хувь нь бөөний худалдааны төв байхад үлдсэн 0.6 хувийг хүнсний болон барааны зах эзэлж байв.



БАРИЛГА

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 2016 онд 1596.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 33.7 тэрбум төгрөгөөр (2.1%) буурсан байна. Гадаадын байгууллагын гүйцэтгэсэн ажил 27.5 тэрбум төгрөг (81.8%), дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн ажил 6.1 тэрбум төгрөгөөр (18.2%) өмнөх оноос буурсан байна. Нийт гүйцэтгэсэн ажлын 99.5 хувийг дотоодын барилгын байгууллага, 0.5 хувийг гадаадын байгууллага гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 137. Барилга угсралт, их засварын ажил, дотоод, гадаадын байгууллагаар, сая төгрөг

Гүйцэтгэгчийн төрөл	2014	2015	2016
Барилга угсралт, их засварын ажил, ¹¹ бүгд	1 577 168.1	1 629 913.3	1 596 236.7
Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн	1 545 035.5	1 594 417.4	1 588 293.1
Үүнээс:			
Гадаадтай хамтарсан байгууллагын гүйцэтгэсэн	39 497.2	13 756.2	12 103.6
Гадаадын байгууллагын гүйцэтгэсэн	32 132.6	35 495.9	7 943.6

Хүснэгт 138. Ашиглалтад оруулсан үндсэн хөрөнгө, барилгын төрлөөр, сая төгрөг

Барилгын төрөл	2014	2015	2016
Бүгд	2 133 896.2	1 948 956.0	2 033 680.2
Орон сууцны	1 309 926.4	1 255 448.0	1 179 550.7
Худалдаа, үйлчилгээний барилга	128 810.0	131 513.0	256 240.7
Эмнэлгийн	8 065.0	14 700.0	16 410.0
Сургууль, соёлын	121 081.4	109 802.4	144 569.9
Авто зам	70 268.1	132 290.4	39 919.5
Гүүр, гүүрэн гарц	4 770.0	3 874.0	16 488.2
Бусад	490 975.3	301 328.2	380 501.2

2016 онд ашиглалтад оруулсан үндсэн хөрөнгө өмнөх оноос 4.3 хувиар өссөн байна. Ашиглалтад орсон нийт үндсэн хөрөнгөөс 58.0 хувийг орон сууцны барилга, 12.6 хувийг худалдаа үйлчилгээ, 0.8 хувийг эмнэлгийн, 7.1 хувийг сургууль, соёлын барилга, 2.0 хувийг авто зам, 0.8 хувийг гүүр, гүүрэн гарц, 18.7 хувийг бусад үзүүлэлт эзэлж байна.

¹¹ Барилга угсралт, их засвар гэж барилга байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан угсрах зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагааг ойлгоно.

Хүснэгт 139. Ашиглалтад оруулсан барилга, хүчин чадлаар

Барилгын төрөл	Хэмжих нэгж	2014	2015	2016
Орон сууц	айлын тоо	20 865	18 463	15 130
Эмнэлэг	орны тоо	336	310	1 120
Сургууль, соёлын	суудлын тоо	13 836	16 880	12 000
Авто зам	километр	125	88	87
Гүүр, гүүрэн гарц	метр	484	196	32

Өмнөх онуудтай харьцуулахад 2016 онд ашиглалтад оруулсан орон сууцны барилга, авто зам, гүүр, гүүрэн гарцын тоо хэмжээ буурсан байна. Эмнэлгийн барилгын хүчин чадал 2016 онд өмнөх оноос 3.6 дахин өссөн байхад сургууль, соёлын барилгын хүчин чадал 28.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 140. Барилга угсралт, их засварын ажлын бүтэц, барилгын төрөл, өмчийн хэлбэр, дүнд эзлэх хувиар

Үзүүлэлт	2014	2015	2016
Барилга угсралт, их засварын ажил, бүгд	100.0	100.0	100.0
Орон сууц ¹²	56.7	61.1	61.0
Орон сууцны бүс ¹³	23.8	22.7	27.5
Үйлдвэрийн	4.2	4.5	1.5
Худалдаа, үйлчилгээний	42.9	32.9	37.4
Эмнэлэг, сургууль, соёлын	33.6	38.5	31.3
Бусад	19.3	24.0	29.8
Инженерийн байгууламж ¹⁴	18.6	15.8	11.3
Эрчим хүчний	56.3	39.7	56.1
Холбооны	0.0	0.2	0.9
Төмөр зам	0.0	0.0	0.0
Авто зам	17.3	22.9	21.0
Гүүр, гүүрэн гарц	4.2	3.5	1.3
Далан, суваг, шугам, сүлжээ	17.1	29.2	20.0
Бусад (зам, талбайн бусад ажил)	5.1	4.5	0.6
Их засварын ажил	0.9	0.4	0.2
Барилга угсралтын ажил	99.1	99.6	99.8
Барилга угсралт	81.3	84.2	88.7
Инженерийн байгууламж	18.7	15.8	11.3
Өмчийн хэлбэрээр	100.0	100.0	100.0
Хувийн байгууллагын	97.8	98.5	98.9
Төрийн өмчийн байгууллагын	2.2	1.5	1.1

¹² Орон сууцны барилга нь хамгийн багадаа гэхэд түүний тал хэсгийг нь орон сууцны зориулалтаар ашигладаг байгууламж юм.

¹³ Орон сууцны бус барилгад барилгын багахан хэсгийг (нийт талбайн 50%-аас бага хэсэг) орон сууцны зориулалтаар ашигладаг барилгыг оруулна.

¹⁴ Инженерийн барилгын ажилд зам, гүүр, хурдны зам, онгоцны буудлын талбай, ус хангамж, бохирын шугам, далан хаалт, усжуулалтын байгууламж зэрэг барилга угсралтад ангилагддаггүй барилга байгууламжийн бүх ажлыг оруулна.

Хүснэгт 141. Барилгын байгууллагын бүлэглэлт, гүйцэтгэсэн барилга, угсралт, их засварын ажил, дүнд эзлэх хувь

Гүйцэтгэсэн барилга, угсралтын ажлын төсөв	2014	2015	2016
Бүгд	100.0	100.0	100.0
10 сая хүртэл	0.0	0.0	0.0
10-50	0.1	0.1	0.1
51-100	0.1	0.1	0.1
101-500	1.7	1.0	0.1
500 саяас дээш	98.1	98.8	99.7

Барилга, угсралтын ажлын 98.1-99.7 хувь нь 500 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ажил байна.

Хүснэгт 142. Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, дүүргээр, сая төгрөг

Үзүүлэлт	2014	2015	2016
Нийслэлийн дүн	1 545 035.5	1 594 417.4	1 588 293.1
Багануур	6 015.4	5 778.5	12 493.5
Багахангай	0.0	28 563.5	2 070.0
Баянгол	106 455.1	205 072.2	123 902.3
Баянзүрх	392 217.2	389 240.5	452 902.9
Налайх	13 191.3	33 174.2	36 338.3
Сонгинохайрхан	103 436.0	173 919.5	134 176.8
Сүхбаатар	148 011.1	210 666.2	175 908.5
Хан-Уул	657 130.0	508 800.6	606 040.2
Чингэлтэй	118 579.4	39 202.2	44 460.6

Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 2015 онд 2014 оноос 3.2 хувиар өссөн бол 2016 онд өмнөх оноос 0.4 хувиар буурсан байна.


2016 онд дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн нийт барилга угсралт, их засварын ажлын 38.2 хувийг Хан-Уул, 28.5 хувийг Баянзүрх, 11.1 хувийг Сүхбаатар, 8.4 хувийг Сонгинохайрхан, 7.8 хувийг Баянгол, 2.8 хувийг Чингэлтэй дүүрэг эзэлж байгаа бол Налайх 2.3 хувийг, Багануур 0.8 хувийг, Багахангай дүүрэг 0.1 хувийг тус тус эзэлж байна.



АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

Монгол Улсын хэмжээнд бүртгэлтэй нийт аж ахуйн нэгж, байгууллагын 73.8 хувь, үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгж, байгууллагын 63.9 хувь нь нийслэлийн нутаг дэвсгэрт байршиж байна. Нийслэлийн хэмжээнд 2016 онд үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн 104477 аж ахуйн нэгж, байгууллага байв.

Зураг 94. Аж ахуйн нэгж, байгууллагын тоо




Бүртгэлтэй нийт аж ахуйн нэгж, байгууллагын 46153 (44.2%) нь жилийн турш байнга үйл ажиллагаа явуулсан байна.

Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоог өмнөх онтой харьцуулахад 12111 буюу 13.1 хувиар, үүний дотор үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо 5772 буюу 14.3 хувиар тус тус нэмэгдсэн байна.


Хүснэгт 143. Нийслэлийн аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хариуцлагын хэлбэрээр

Хариуцлагын хэлбэр	2012	2013	2014	2015	2016
Бүгд	65 587	71 654	81 748	92 366	104 477
Компани	58 981	65 121	73 722	81 800	90 635
Нөхөрлөл	738	739	887	969	1 169
Хоршоо	374	369	450	554	645
Улсын үйлдвэрийн газар	90	97	131	112	108
Төсөвт байгууллага	761	738	780	822	881
Төрийн бус байгууллага	4 366	4 383	5 513	7 830	10 521
Бусад	277	207	265	279	518

Зураг 95. Нийслэлийн аж ахуйн нэгж, байгууллагын тоо



Зураг 96. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, байршлаар



2016 онд бүртгэлтэй байсан аж ахуйн нэгж, байгууллагын 22.0 хувь нь Баянзүрх, 21.1 хувь нь Баянгол, 19.0 хувь нь Сүхбаатар, 12.4 хувь нь Чингэлтэй, 12.7 хувь нь Сонгинохайрхан, 11.1 хувь нь Хан-Уул, 1.0 хувь нь Налайх, 0.6 хувь нь Багануур, 0.1 хувь нь Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт байрлаж байжээ.

Хүснэгт 144. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо, өмч, ажиллагчдын тооны бүлгээр, 2016 он

Өмчийн хэлбэр			Бүгд	Үүнээс:			
				0-9	10-19	20-49	50+
Нийт			46 153	39 644	2 758	2 112	1 639
Төрийн өмчийн	Бүгд		955	168	153	307	327
	Үүнээс:	дан	946	168	151	307	320
		оролцоотой	7	-	2	-	5
		оролцоотой хамтарсан	2	-	-	-	2
Орон нутгийн өмчийн	Бүгд		142	40	30	28	44
	Үүнээс:	дан	137	39	29	28	41
		оролцоотой	5	1	1	-	3
		оролцоотой хамтарсан	-	-	-	-	-
Хувийн	Бүгд		45 056	39 436	2 575	1 777	1 268
	Үүнээс:	дан	41 754	36 766	2 339	1 600	1 049
		хамтарсан	1 218	1 013	79	56	70
		гадаадын	2 084	1 657	157	121	149

Үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгж, байгууллагын 2.4 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага, 97.6 хувь нь хувийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага байна. Эдгээр аж ахуйн нэгж, байгууллагуудын 41754 (92.7%) нь Монгол Улсын иргэний, 1218 (2.7%) нь гадаадын улстай хамтарсан, 2084 (4.6%) нь 100% гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага байна.

Хүснэгт 145. Аж ахуйн нэгж, байгууллага, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, байршлаар, 2016 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо	Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо	Үүнээс: байршлаар							Хан-Уул	Чингэлтэй
			Баянзүрх	Баянгол	Баянзүрх	Налайх	Сүхбаатар	Хан-Уул	Чингэлтэй		
Бүгд	104 477	46 153	407	71	9 680	9 840	572	5 251	9 067	5 063	6 202
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, ан агнуур	2 580	827	21	0	127	158	12	143	137	146	83
Уул уурхай, олборлох үйлдвэр	998	530	4	-	120	124	13	33	133	47	56
Боловсруулах үйлдвэр	6 970	3 124	35	10	630	632	43	478	565	412	319
Цахилгаан, хий үйлдвэрлэл, усан хангамж	136	57	3	1	11	6	2	7	13	5	9
Барилга	9 844	5 095	12	2	964	1 393	27	744	615	746	592
Бөөний, жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар	47 858	19 115	131	14	4 022	4 144	255	2 356	3 633	1 940	2 620
Зочид буудал, зоогийн газар	2 251	1 155	18	1	246	253	38	84	246	103	166
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	5 034	1 861	6	2	494	361	25	177	415	178	203
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	1 405	766	18	2	109	137	9	64	188	86	153
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	12 867	6 065	19	2	1 459	1 136	24	439	1 578	537	871
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгал	281	281	17	9	18	32	17	22	54	26	86
Боловсрол	3 001	1 744	22	4	345	384	22	189	274	204	300
Эрүүл мэнд, нийгмийн халамж	1 809	1 262	27	5	323	295	23	148	228	102	111
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	9 419	4 247	74	19	812	784	62	367	967	529	633
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	24	24	-	-	-	1	-	-	21	2	-

Хүснэгт 146. Аж ахуйн нэгж байгууллагын тоо, хариуцлагын хэлбэр, үйл ажиллагаа эрхлэлтээр,
2016 он

Байгууллагын хэлбэр	Бүгд	Үйл ажиллагаа явуулж буй	Үйл ажиллагаа явуулаагүй	Үүнээс:			
				Эхлээгүй	Түр зогсоосон	Бүрэн зогсоосон	Бусад
Дүн	104 477	46 153	58 324	26 340	28 826	769	2 389
Хувьцаат компани	157	113	44	32	11	1	-
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	90 478	39 374	51 104	22 357	25 780	675	2 292
Бүх гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	623	335	288	109	160	10	9
Зарим гишүүд нь Хариуцлагатай нөхөрлөл	546	235	311	131	161	6	13
Хоршоо	645	275	370	138	204	12	16
Төрийн өмчит үйлдвэрийн газар	52	47	5	1	3	1	-
Орон нутгийн өмчит Үйлдвэрийн газар	56	52	4	1	2	-	1
Төсөвт байгууллага	881	865	16	8	8	-	-
Төрийн бүс байгууллага	10 521	4 484	6 037	3 478	2 453	63	43
Бусад	518	373	145	85	44	1	15


2016 онд бүртгэлтэй нийт аж ахуйн нэгж, байгууллагын 55.8 хувь нь үйл ажиллагаа явуулаагүй байна. Эдгээр аж ахуйн нэгж, байгууллагын 26340 (45.2%) нь үйл ажиллагаагаа эхлээгүй, 28826 (49.4%) нь үйл ажиллагаагаа түр зогсоосон, 2389 (4.1%) нь хаяг тодорхойгүй буюу олдохгүй, 769 (1.3%) нь үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон аж ахуйн нэгж, байгууллагууд байна.

Хүснэгт 147. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо, ажиллагчдын тооны
бүлгээр, 2016 он

Дүүрэг	Бүгд	Үүнээс: ажиллагчдын тооны бүлгээр			
		1-9	10-19	20-49	50+
Нийслэлийн дүн	46 153	39 644	2 758	2 112	1 639
Багануур	407	330	32	22	23
Багахангай	71	54	5	10	2
Баянгол	9 680	8 351	610	450	269
Баянзүрх	9 840	8 596	569	399	276
Налайх	572	503	29	23	17
Сонгинохайрхан	5 251	4 710	261	174	106
Сүхбаатар	9 067	7 425	602	533	507
Хан-Уул	5 063	4 337	296	223	207
Чингэлтэй	6 202	5 338	354	278	232

2016 онд үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгж байгууллагын 85.9 хувь нь 1-9, 6.0 хувь нь 10-19, 4.6 хувь нь 20-49, 3.5 хувь нь 50-иас дээш тооны ажиллагчидтай байна.

Зураг 97. Аж ахуйн нэгж, байгууллагуудын ажиллагчид, дүүргээр



2016 онд үйл ажиллагаа явуулсан 50-иас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллагуудын 30.9 хувь нь Сүхбаатар, 16.4 хувь Баянгол, 16.9 хувь нь Баянзүрх, 14.2 хувь нь Чингэлтэй, 12.6 хувь нь Хан-Уул, 6.5 хувь нь Сонгино-хайрхан, 1.4 хувь нь Багануур, 1.0 хувь нь Налайх, 0.1 хувь нь Багахангай дүүрэгт ажил хөдөлмөр эрхэлсэн байна.